



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ АНХДУГААР ЧУУЛГАН

2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр, Баасан гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>I</i>
<i>Хуралдааны төвч тэмдэглэл:</i>	<i>2-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>6-62</i>

---

1. Намын бүлэг байгуулсан тухай мэдээллийг Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлснийг сонсох тухай	6-8
2. Улсын Их Хурлын дэд дарга нарыг сонгох тухай	8-10
3. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай асуудал	10-16
4. Дөрөв. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай	16-62

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

**Чөлөөтэй:** Ж.Батсуурь, Б.Батцэцэг, Ж.Ганбаатар, Ж.Чинбүрэн;  
**Тасалсан:** С.Лүндэг.

**Нэг Улсын Их Хуралд намын бүлэг байгуулагдсан тухай шийдвэрийг танилцуулах тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2-т тус заасны дагуу Монгол Ардын намын бүлэг болон Ардчилсан намын бүлэг байгуулсан тухай шийдвэр, түүний бүрэлдэхүүнд орсон гишүүдийн нэрийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлснийг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.3-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн даргаар Одонгийн Цогтгэрэлийг сонгосон тухай шийдвэрийг тус тус танилцуулав.

*Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. Улсын Их Хурлын дэд дарга нарыг сонгох тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлэх саналыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын

намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар, Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшигүүлэх саналыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл нар тус тус танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Д.Амарбаясгалан:** 1.Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Хүрэлбаатарын Булгантуюаг сонгох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	110
Татгалзсан:	0
Бүгд:	110
100 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Бөхчүлүүны Пүрэвдоржийг сонгох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	110
Татгалзсан:	0
Бүгд:	110
100 хувийн саналаар дэмжигдлээ.	

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т тус тус заасны дагуу санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын дэд дарга нарыг сонгох тухай” тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Улсын Их Хурлын дэд дарга нарыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /10:38/

*Уг асуудлыг 10 цаг 39 минутад хэлэлциэж дуусав.*

#### **Гурав.Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл 20 минутын завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./10:40/

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай асуудлаар

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./13:05/

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Д.Амарбаясгалан:** “Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	109
Татгалзсан:	0
Бүгд:	109
100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.	

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа, О.Цогтгэрэл, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан хариулж, тайлбар хийв. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /13:24/

*Үдээс өмнөх хуралдаан 50 минут үргэлжилж, 13 цаг 25 минутад завсарлав.*

*Үдээс хойших нэгдсэн хуралдаан 15 цаг 42 минутад эхлэв.*

### **Дөрөв. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай саналыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нар танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, П.Наранбаяр, Б.Пүрэвдорж, Б.Батбаатар, Р.Эрдэнэбүрэн, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, О.Цогтгэрэл, О.Алтангэрэл, Ц.Туваан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшигч Л.Оюун-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, С.Эрдэнэбат, Б.Бейсен, Х.Тэмүүжин, Л.Мөнхбаясгалан, Н.Алтанхуяг, М.Нарантуяа-Нара, Д.Ганбат, Ж.Алдаржавхлан, Ц.Баатархүү, Д.Энхтүвшин, Ц.Сандаг-Очир, Ж.Золжаргал, С.Эрдэнэболд, Б.Түвшин, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа, Д.Цогтбаатар, Г.Очирбат, Р.Сэддорж, Ц.Идэрбат нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын Ерөнхий сайдыар Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	103
Татгалзсан:	15
Бүгд:	118
87.2 хувийн саналаар дэмжигдлээ.	

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т заасны дагуу нэр дэвшигчийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцаа./18:14/

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ үг хэлж, Төрийн сүлдэнд мэхийн ёслов.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.*

*Хуралдаан 3 цаг 50 минут үргэлжилж, 126 гишүүнээс 121 гишүүн хүрэлцэн ирж, 96.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 42 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
**ЕРӨНХИЙ НАРИЙН**  
**БИЧГИЙН ДАРГА**

Д.ЭНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
**ПРОТОКОЛЫН АЛБАНЫ**  
**ШИНЖЭЭЧ**

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр,  
Баасан гаралт Төрийн ордон “Их  
хуралдай” танхим 12 цаг 42 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы 7 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаан нээгдсэндэйг мэдэгдье ээ. Энэ олон сонгогдсон гишүүд танхимд ярихаа багасгана шүү. Шинэ гишүүдэд шинэ улгэр дуурайлал өгнө өө. Та бид ард түмний элч төлөөлөгч учраас хуралдаандaa идэвхтэй анхааралтай оролцоно оо. Өнөөдөрийн хурлаар б асуудал хэлэлцэхээр оруулж байна

**Нэгдүгээрт,** Улсын Их Хуралд нам эвслийн бүлэг байгуулагдсан тухай шийдвэрийг ушииж таницуулна.

**Хоёрдугаарт,** Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудал орно.

**Гуравдугаарт,** Байнгын хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай асуудал.

**Дөрөвдүгээрт,** Дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай асуудал.

**Тавдугаарт,** Байнгын хороодын хорооны даргыг сонгох тухай асуудал,

**Зургаадугаарт,** Монгол Улсын ерөнхий сайдыг томилож тухай асуудал хэлэлцэнэ ээ.

**Ингээд** хэлэлцэх асуудлын дарааллаар 1 дүгээр асуудалдаа орьё.

Улсын Их Хурал дахь нам эвслийн бүлэг байгуулагдсан тухай шийдвэрийг таницуулах тухай асуудлыг оруулъя аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20.1-д, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29.1-д заасан суудал авсан нам, эвслийн гишүүд бүлэг байгуулсан тухай шийдвэр бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг бүлгийн дарга Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлэг байгуулсанд тооцно уу.

Мөн хуулийн 20.2-т Улсын Их Хурлын дарга нам эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр түүний бүрэлдэхүүнд орсон гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдаанд ушииж танилуулна гэж заасны дагуу Улсын Их Хуралд намын бүлэг байгуулах тухай тухай шийдвэрийг ушииж танилуулъя.

Бүлгийн хурлууд тулгамдуу болсон учраас бичиг бүрдүүлэх ажил дээр жсоохон цаг алдлаа. Ингээд ушииж танилуулъя аа.

Бүлэг байгуулж бүлгийн даргыг сонгох тухай Монгол Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.3 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд МАН-аас нэр дэвшиж сонгогдсон 68 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулаж бүлгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг сонгосон болохыг өргөн мэдүүлж байна аа.

Хавсралт Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг байгуулах тухай Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн даргыг сонгох тухай Намын бүлгийн 2024 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 0:01 тоот шийдвэр гаргалаа. Бүлгийн гишүүдийг ушииж танилуулъя.

Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн гишүүд:

1. Жуковын Алдаржавхлан
2. Наранцэцэгийн Алтанишагай,
3. Даизэгвийн Амарбаясгалан,
4. Сайнбуянгийн Амарсайхан,
5. Чинбаатарын Анар,
6. Аюушийн Ариунзаяа,
7. Тилеуханы Аубакир,
8. Хүрэлбаатарын Баасанжаргал,
9. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн,
10. Энхтайваны Бат-Амгалан,
11. Жигжидийн Батжаргал,
12. Дамбын Батлут,
13. Отгоншарын Батнайрамдал,
14. Нацагдоржийн Батсүмбэрэл,
15. Батмөнхийн Батцэцэг,
16. Энхбаярын Батшугар,
17. Баярмагнайн Баярбаатар,
18. Энхбатын Болормаа,
19. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ,
20. Жадамбын Бат-Эрдэнэ,
21. Дуламын Бум-Очир,
22. Хүрэлбаатарын Булгантуяа,
23. Сандагийн Бямбацогт,
24. Жанчивын Галбадрах,
25. Жамбалын Ганбаатар,
26. Даваасамбуугийн Ганмаа,
27. Хассуурийн Ганхуяг,
28. Мөнгөнцогийн Ганхүлэг,
29. Цэрэнтилийн Даваасүрэн,
30. Гонгорын Дамдиням,
31. Борхуугийн Дэлгэрсайхан,
32. Болдын Жавхлан,
33. Сүрэнжавын Лүндэг,
34. Хажекбериийн Жангабыл,
35. Батжаргалын Заябал,
36. Сархадын Зултхар,
37. Цагаанхүүгийн Идэрбат,
38. Ганзоригийн Лувсанжамц,
39. Мэндбаярын Мандухай,
40. Лхагвын Мөнхбаатар,
41. Тогтолын Мөнхсайхан,
42. Загджавын Мэндсайхан,
43. Нанзадын Наранбаатар,
44. Чинбатын Номин
45. Одсүрэнгийн Номинчимэг
46. Ухнаагийн Отгонбаяр
47. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ
48. Дүгэрийн Рэгдэл

49. Пүрэвжавын Сайнзориг
50. Цэндийн Сандаг-Очир
51. Отгоны Саранчуулун
52. Лхагвасүрэнгийн Соронзонболд
53. Буяагийн Тулга
54. Ганзоригийн Тэмүүлэн
55. Чинбатын Ундрам
56. Ням-Осорын Учрал
57. Болдын Уянга
58. Доржсүрэнгийн Үүрийнтуяа
59. Бадарчийн хэрэглэн Хэрлэн
60. Дамдины Цогтбаатар
61. Жигжидсүрэнгийн Чинбүрэн
62. Баттогтохын Чойжилсүрэн
63. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан
64. Баттөмөрийн Энхбаяр
65. Жадамбын Энхбаяр
66. Дашицэрэнгийн Энхтувшин
67. Мөнхчулууны Энхцэцэг
68. Сүхбаатарын Эрдэнэбат гэсэн хүний бүрэлдэхүүнтэй бүлэг байгуулсан шийдвэрийг ирүүлсэн байна. Унииж танилууллаа. Мөн УИХ дахь АН-ын бүлгээс бичиг ирүүлсэн байна. Унииж танилуулъя.

УИХ дахь АН-ын бүлгийн дарга сонгосон тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт заасны дагуу УИХ дахь АН-ын бүлгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл сонгогдоноыг уүгээр мэдээлж байна аа гэсэн байна. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу УИХ дахь АН-ын бүлэг байгуулсан шийдвэр түүний бүрэлдэхүүнд орсон гишүүдийн нэrsийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд унииж танилуулж өгнө үү гэсэн бүлгийн даргын гарын үсэгтэй албан тоот иржээ.

Бүлэг байгуулагдсан тухай унииж танилуулъя.

Монгол УИХ дахь АН-ын бүлгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Улсын Их Хурлын гишүүн

1. Оюунсайханы Алтангэрэл
  2. Очирбатын Амгаланбаатар
  3. Норовын Алтанхуяг
  4. Цэндийн Баатархүү
  5. Далайн Батбаяр
  6. Жамбын Батсуурь
  7. Халтмаагийн Баттулга
  8. Пүрэвийн Батчимэг
  9. Жудгийн Баярмаа
  10. Жадамбаагийн Баясгалан
  11. Буланы Бейсен
  12. Хөххүүгийн Болормаа
  13. Шинэбаярын Бямбасүрэн
  14. Амгаланбаатарын Ганбаатар
  15. Гомбын Ганбаатар
  16. Сайнхүүгийн Ганбаатар
  17. Дашидондогийн Ганбат
  18. Лувсаннямын Гантөмөр
  19. Батбаярын Жаргалан
  20. Дамдинсүрэнгийн
- Жаргалсайхан
21. Чулуунбилигийн Лодойсамбуу
  22. Цагаанхүүгийн Мөнхбат
  23. Лувсанбямбаагийн
- Мөнхбаясгалан
24. Пүрэвбаатарын Мөнхтулга
  25. Цэндсүрэнгийн Мөнхтуяа
  26. Салдангийн Одонтуяа
  27. Эрдэнэбилигийн Одбаяр
  28. Ганбатын Очирбат
  29. Бадамдоржийн Пүнсалмаа
  30. Бөхчулууны Пүрэвдорж
  31. Ринчинбямбын Сэддорж
  32. Цэвэгдоржийн Туваан
  33. Банзрагчийн Түвшин
  34. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин
  35. Ганбатын Хосбаяр
  36. Даваагийн Цогтбаатар
  37. Одонгийн Цогтгэрэл
  38. Саруулсайханы Цэнгүүн
  39. Өлзийхүүгийн Шижир
  40. Доржсодоловын Энхтуяа
  41. Сүхбаатарын Эрдэнэболд
  42. Арвижихын Эрдэнэбүрэн гэсэн бүрэлдэхүүнтэй бүлэг байгуулсан тогтоол иржээ.

Ингээд бүлэг байгуулагдсан тухай шийдвэрийг та бүхэнд уншиж танилууллаа.

Үүгээр УИХ дахь МАН, УИХ дахь АН үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдээж байна аа. Бүлгүүдийн үйл ажиллагаанд амжилт хүсье ээ.

7 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хурлын Анхдугаар чуулганаар хэлэлцэх асуудлын санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу гар өргөж явуулах горимын санал гаргасныг Улсын Их Хурлын гишүүд 100 хувь дэмжссэн. Иймд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг санал хураалтыг гар өргөж явуулах нь байна.

Ирэх даваа гарагт үргэлжлэх анхдугаар чуулганы хуралдааны эхэнд санал хураалтын тоног төхөөрөмжийг төст хийнэ.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдэд тусгайлан зар хүргэнэ ээ. Ингээд хэлэлцэх асуудлын дарааллаар 2 дугаар асуудалд орьё.

10.30 цагт

Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье ээ.

Дараагийн асуудалд Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай асуудал орж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д Улсын Их Хурлын дэд даргыг тухайн Улсын Их Хурлын сонгуулийн дунд бий болсон нам эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн ил санал хураалтаар сонгоно гэж заасны дагуу УИХ дахь МАН-ын бүлгээс Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлэх саналыг МАН-ын бүлгийн дарга Лхагвын Мөнхбаатар танилуулна аа. Индэрт урьж байна.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

МАН-ын булгээс нэр дэвшүүлэх тухай шийдвэрийг танилуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг МАН-ын Удирдах зөвлөлийн 2024 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн Б 26 дугаар тоот тогтоол Улсын Их Хурал дахь МАН-ын булгийн гишүүдийн саналыг тус тус ундэслэн УИХ дахь МАН-ын булгээс Монгол Улсын Их Хурлын дэд даргад Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяаг нэр дэвшүүлж байна аа. Булгантуяагийн төвч намтрэг танилуулъя.

Хүрэлбаатарын Булгантуяа нь 1981 онд Архангай аймгийн Цэцэрлэг хотод төрсөн, 2012 онд МАН-ын гишүүнээр элссэн. МАН-ын удирдах зөвлөлийн гишүүн, Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны ерөнхийлөгч сонгуульт ажилтай. Монгол Улсын Их Хурлын гишүүн. 1997-1998 онд Монгол Туркийн хамтарсан дунд сургууль, 1999-2006 онд БНХАУ-ын ШУТИС эдийн засагч мэргэжлээр, 2007-2008 онд АНУ-ын Ейлийн Их сургуульд эдийн засагч мэргэжилтэй. Хөгжлийн эдийн засаг олон улсын эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй. 2006-2008 онд Бүтээлч шийдлүүд компанийн хөрөнгө оруулалтын зөвлөх, 2008-2010 онд Дэлхийн банкны төслийн хөтөлбөрийн зөвлөх, 2010-2011 онд Оюутолгой Компанийн инженерийн албаны төслийн менежер, 2011-2012 онд Оюутолгой компанийн Бизнес стратегийн газарт арилжааны үндсэн зөвлөх, 2012-2013 онд Петровис компанийн Бизнес хөгжлийн газрын дарга, 2013-2016 онд МАН-ын олон улсын харилцаа намын зохион байгуулалт хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга, 2016-2020 онд Сангийн дэд сайд, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2020-2023 онд Монгол Улсын Их Хурал дахь МАН-ын булгийн дэд дарга, 2023 онд Монгол Улсын

Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, 2023 оноос Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны Ерөнхийлөгч, 2023 оноос Монгол Улсын Засгийн газрын гишүүн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна аа.

Монгол Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлсэн Хүрэлбаатарын Булгантуяаг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа.

Улсын Их Хурал дахь АН-ын булгээс Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлэх саналыг АН-ын булгийн дарга Одонгийн Цогтгэрэл танилуулна аа. Индэрт урьж байна.

**О.Цогтгэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлэх тухай Монгол Улсын Их Хурлын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу Улсын Их Хурал дахь АН-ын булгийн гишүүдийн хурлын санал хураалтын дунг ундэслэн Монгол Улсын Их Хурлын гишүүн Бөхчүлүүны Пүрэвдоржийг Монгол Улсын Их Хурлын дэд даргад нэр дэвшүүлж байна аа. Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ингээд 2 дэд даргин танилуулга хийгдлээ. Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Хүрэлбаатарын Булгантуяаг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт илээр явагдана.

Их Хурлын дэд дарга дээр дэгээрээ хэлэлцүүлэг байхгүй явж байгаа. Намын

бүлгүүд санал болгож хэлэлцүүлж байгаа учраас шийдвэр хэмжээнд ингээд илээр санал хураалтыг явуулъя. Дахиад уншиж танилуулъя.

Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Хүрэлбаатарын Булгантуяаг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа. Дэмжиж байгаа гишүүд гаралт өргөхийг хүсье.

Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүн байна уу? Алга байна.

Хуралдаанд 110 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар Хүрэлбаатарын Булгантуяаг Их Хурлын дэд даргаар дэмжлээ. Монгол Улсын Их Хурлын Дэд даргаар Бөхчулууны Пүрэвдоржийг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя.

Дэмжиж байгаа гишүүд гаралт өргөхийг хүсье.

Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүд байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Бөхчулууны Пүрэвдоржийг хуралдаанд оролцсон 110 гишүүн 100 хувийн саналаар дэмжлээ.

Улсын Их Хурлын дэд даргаар Хүрэлбаатарын Булгантуяа, Бөхчулууны Пүрэвдорж нарыг сонгох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжссэн тул Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Тогтоолыг уншиж танилуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

Монгол Улсын Их Хурлын дэд дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг 16 дугаар зүйлийн 16.3.4 дэх заалт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйл санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Улсын Их Хурал дахь МАН-ын булгээс нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа, АН-ын булгээс нэр дэвшүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж нарыйг Монгол Улсын Их Хурлын дэд даргаар тус тус сонгосугай.

2. Энэ тогтоолыг 2024 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоол байна аа.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна тэгвэл эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.38 цагт

Ингээд Байнгын хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай асуудал руу орьё.

АН-ын булгийн дарга Цогтгэрэл.

**О.Цогтгэрэл:** Гишүүддээ өглөөний мэнд хүргээ.

Байнгын хорооны бүрэлдэхүүн гишүүдийг хуваарилж ороход АН-ын булгээс шинээр сонгогдсон гишүүд их олон байгаа учраас Их Хурлын дарга манай бүлэгт 20 минутын завсарлага өгөхийг хүсье. Бид нар энэ хооронд яаралтай хуралдаад асуудлаа цэгцлээд ороод ирье. 20 минутын завсарлага өгөхийг хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Тэгье.

*АН-ын бүлгийн даргын хүсэлтээр  
20 минутын завсарлага хуралдаан 11  
цагаас ургэлжилнэ.*

*Гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ  
АН-ын бүлгээс авсан авсан завсарлагын  
хугацаа дууссан байна. Хуралдаанаа  
ургэлжлүүлье.*

*Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшүүлж Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд унишиж танилцуульяа.*

*Монгол Улсын Их Хурлын тогтоол*

*Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай*

*Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:*

*1. Монгол Улсын Их Хурлын байнгын хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.*

*Үүнд:*

*Нэгдүгээрт, Аюулгүй байдал,  
гадаад бодлогын байнгын хороо*

1. Ч.Анар
2. Э.Бат-Амгалан
3. Э.Болормаа
4. Б.Дэлгэрсайхан
5. Батсүмбэрэл
7. Х.Жангабыл

8. Д.Цогтбаатар
9. Ж.Энхбаяр
10. С.Бямбацогт
11. П.Наранбаяр
12. Н.Номтойбаяр
13. Б.Батбаатар
14. Л.Энхнасан
15. О.Алтангэрэл
16. Д.Ганбат
17. Б.Жаргалан
18. Хосбаяр. Энэ гишүүдийн овог бичээгүй байх юм. Г.Хосбаяр
19. С.Эрдэнэболд
20. Р.Эрдэнэбүрэн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй гишүүдийн нэр ирсэн байна.

*Хоёрдугаарт, Байгаль орчин, хүнс, хөдөөг аж ахуйн байнгын хороо.*

- Т.Аубакир,  
Ж.Батжаргал,  
Ж.Бат-Эрдэнэ,  
М.Ганхулэг,  
Ц.Идэрбат,  
З.Мэндсайхан,  
Н.Наранбаатар,  
У.Отгонбаяр,  
С.Лундэг.  
Г.Тэмүүлэн,  
М.Мандухай,  
Б.Найдлаа  
А.Ундраа  
Л.Энхнасан  
Замира,  
О.Амгаланбаатар,  
П.Батчимэг,  
Б.Бейсен,  
Г.Ганбаатар,  
С.Ганбаатар,  
Ц.Мөнхбат,  
Л.Мөнхбаясгалан,  
Р.Сэддорж,  
Ө.Шижир.*

*Гуравдугаарт, Боловсрол, соёл,  
шинжслэх ухааны байнгын хороо*

- О.Батнайрамдал  
Д.Бум-Очир,  
Ж.Галбадрах,*

Г.Дамдиняа, Д.Рэгдэл, О.Саранчулун, Ч.Ундрэм, Б.Хэрлэн, У.Отгонбаяр, П.Наранбаяр М.Сарнай, Ш.Бямбасүрэн А.Ганбаатар, Ц.Мөнхтуяа Г.Хосбаяр.

Дөрөвдүгээрт, Ёс зүй, дэгийн байнгын хороо

Б.Баярбаатар, Д.Ганмаа, Д.Рэгдэл Б.Хэрлэн Х.Баасанжаргал, Ж.Батсуурь Д.Бум-Очир, Ж.Галбадрах, А.Ариунзаяа, Д.Жаргалсайхан, Ч.Лодойсамбуу, Г.Очирбат, Д.Энхтуяа.

Тавдугаарт, Инновац, цахим бодлогын байнгын хороо

Э.Батшуугар Т.Мөнхсайхан Ж.Чинбүрэн Ж.Золжаргал, Б.Уянга Б.Заябал, А.Ганбаатар, Л.Соронзонболд П.Сайнзориг Н.Алтанишагай, Л.Гантөмөр Ц.Мөнхбат, С.Цэнгүүн, С.Эрдэнэболд.

Энэ Улсын Их Хурлын гишүүдийн овгийг бүтэн бичиж орж ирж байна шүү.

Зургаадугаарт, бодлогын байнгын хороо

А.Ариунзаяа, Д.Ганмаа, С.Зултхар Ц.Идэрбат, Т.Мөнхсайхан, О.Саранчулун, Ж.Чинбүрэн, С.Эрдэнэбат, Б.Мөнхсоёл, М.Сарнай, М.Нарантуяа-Нара, Ц.Баатархүү, Ж.Баярмаа, Ж.Баясгалан, Б.Бейсен, Х.Болормаа, Л.Энх-Амгалан, Х.Булгантуяа, Ц.Мөнхтуяа, Э.Одбаяр, Ц.Туваан, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа гэсэн 23 хүний бурэлдэхүүнтэй.

Долоодугаарт, байгуулалтын байнгын хороо.

Д.Амарбаясгалан С.Амарсайхан, Б.Баярбаатар, Э.Болормаа, С.Бямбацогт, С.Зултхар, Ц.Сандаг-Очир, Л.Оюун-Эрдэнэ, Л.Энх-Амгалан, Л.Мөнхбаатар, Т.Доржсханд, Б.Найдлаа Н.Номтойбаяр, Б.Батбаатар, Б.Жавхлан, Н.Учрал. О.Номинчимэг, Ж.Батсуурь, Ж.Баярмаа, Л.Гантөмөр, Э.Одбаяр,

Нийгмийн

Төрийн

Б.Пүрэвдорж,  
Ц.Туваан,  
Х.Тэмүүжин,  
О.Цогтгэрэл гэсэн 25 хүний  
бүрэлдэхүүнтэй Төрийн байгуулалтын  
байнгын хороо гарч ирсэн байна аа.

Инновац цахим бодлого дээр  
Ч.Номин гэж нэмэгдэх юм байна.

Ч.Анаар,  
Э.Батшиугар,  
Т.Мөнхсайхан,  
Ж.Чинбүрэн,  
Ж.Золжаргал,  
Б.Уянга,  
Б.Заяабал,  
А.Ганбаатар,  
Л.Соронзонболд,  
П.Сайнзориг,  
А.Алтаншагай,  
Л.Гантөмөр,  
Ц.Мөнхбат,  
С.Цэнгүүн,  
С.Эрдэнэболд,  
Ч.Номин гэсэн 16 хүний  
бүрэлдэхүүнтэй болж байна.

Наймдугаарт, Төсвийн байнгын  
хороо

Т.Аубакир,  
Б.Батжаргал,  
Х.Булгантуяа,  
Х.Ганхуяг,  
Ц.Даваасүрэн,  
Б.Заяабал,  
Г.Тэмүүлэн,  
Б.Чойжилсүрэн,  
Т.Доржсханд,  
П.Ганзориг,  
Д.Пүрэвдаваа,  
Р.Батболд,  
З.Мэндсайхан,  
Д.Батлут,  
Г.Дамдиняа,  
Ч.Үндрам,  
С.Амарсайхан,  
О.Амгаланбаатар,  
Н.Алтанхуяг,  
Д.Батбаяр,

Ж.Баясгалан,  
Х.Болормаа,  
Г.Ганбаатар,  
П.Мөнхтүлга,  
Б.Пунсалмаа гэсэн 25 хүний  
бүрэлдэхүүн байна.

Есдүгээрт, Уйлдвэржилтийн  
байнгын хороо

М.Бадамсүрэн,  
Э.Батлут,  
Г.Лувсанжамц,  
Б.Уянга,  
Д.Үүрийнтуяа,  
Д.Энхтүвшин,  
П.Ганзориг,  
Ж.Золжаргал,  
Д.Пүрэвдаваа,  
Ц.Даваасүрэн,  
Б.Чойжилсүрэн,  
Д.Батбаяр,  
С.Ганбаатар,  
Х.Жангабыл,  
М.Энхцэцэг,  
Б.Тулга,  
С.Ганбаатар,  
Д.Жаргалсайхан,  
Л.Мөнхбаясгалан,  
П.Мөнхтүлга,  
С.Одонтуяа,  
Г.Очирбат,  
Б.Пунсалмаа,  
Д.Энхтуяа гэсэн 24 хүний  
бүрэлдэхүүнтэй байна.

Аравдугаарт, Хууль зүйн байнгын  
хороо

Б.Бат-Эрдэнэ,  
Б.Дэлгэрсайхан,  
Л.Мөнхбаатар,  
О.Номинчимэг,  
П.Сайнзориг,  
Ц.Сандаг-Очир,  
Д.Цогтбаатар,  
Г.Уянгахишиг,  
М.Нарантуяа-Нара,  
Ж.Алдаржавхлан,  
О.Алтангэрэл,  
Н.Алтанхуяг,

Х.Баттулга,  
Ж.Энхбаяр,  
Б.Тулга,  
Э.Бат-Амгалан,  
Д.Ганбат,  
С.Одонтуяа,  
Б.Пүрэвдорж,  
Х.Тэмүүжин,  
Даваагийн Цогтбаатар,

Арваннэгдүгээрт, Эдийн засгийн  
байнгын хороо

Н.Алтанишагай,  
Э.Батшигар,  
Ж.Бат-Эрдэнэ,  
Ж.Ганбаатар,  
Г.Лувсанжамц,  
Д.Энхтүвшин,  
М.Энхцэцэг,  
Б.Мөнхсоёл,  
Д.Уянгахишиг,  
А.Ундраа,  
Р.Батболд,  
Ж.Алдаржавхлан,  
Л.Соронзонболд,  
Н.Батсүмбэрэл,  
М.Мандхай,  
Ц.Баатархүү,  
Х.Баттулга,  
П.Батчимэг,  
Ш.Бямбасүрэн,  
М.Бадамсүрэн,  
О.Батнайрамдал,  
Б.Жаргалан,  
Ч.Лодойсамбуу,  
Р.Сэддорж,

О.Цогтгэрэл гэсэн ийм  
бүрэлдэхүүнтэй Байнгын хороодын  
гиишүүдийн нэрсийг уншиж таницууллаа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын  
байнгын хорооны бүрэлдэхүүнийг батлах  
тухай Улсын Их Хурлын тогтоолын  
төслийг баталья гэсэн томьёоллоор  
санал хураалтыг явуулна аа.

Санал хураалт илээр явагдааж  
байгаа.

Асуулт хариулт, асуулт санал  
байхгүй. Хуулиараа Улсын Их Хурлын  
гиишүүн аль Байнгын хороонд орох саналаа  
булэгтээ ирүүлээд бүлгээс ирсэн саналыг  
Улсын Их Хурлын дарга, бүлгийн дарга  
нартай зөвшшилцөж оруулж байгаа.

Ингээд санал хураалт явуулъя.  
Дэмжиж байгаа гиишүүд гарваа өргөхийг  
хүсье.

Баярлалаа.

Татгалзсан гиишүүд байна уу? Алга  
байна.

Тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолын эцсийн найруулга дээр  
саналтай гиишүүн байна уу? Эцсийн  
найруулга дээр Боловсрол, соёл, шинжслэх  
ухааны байнгын хороон дээр Улсын Их  
Хурлын гиишүүн Б.Батцэцэг гэж нэмэгдэх  
юм байна.

А.Ундраа гиишүүн эцсийн найруулга  
дээр санал хэлнэ. Ундраа гиишүүний  
микрофоныг өгье.

**А.Ундраа:** Манайх бүлэггүй учраас  
бичгээр саналаа өгсөн байгаа.

Тэгээд саналууд маань зарим нь  
тусаагүй байх шиг байх юм. Номтойбаяр  
гиишүүн асууж байгаа нь та Төрийн  
байгуулалт дээр нэрийг нь ушилаа.

Нөгөөдөх нь Аюулгүй байдал,  
гадаад бодлого дээр унисан уу, угүй юу,  
лавлаад л асуух гэсэн юм? Нөгөө  
найруулгын асуулт нь болохоор би Эдийн  
засгийн байнгын хороон дээр орьё гэж  
саналаа өгсөн. Мөн Хүнс, хөдөө аж ахуй  
байгаль орчны байнгын хороонд орьё гэж  
саналаа өгсөн. Сая уншигдахгүй байх шиг  
байх юм. Та баталгаажуулаад хэлээдэх  
үү?

**Д.Амарбаясгалан:** Таны асуусан  
Номтойбаяр гиишүүн Аюулгүй байдал,  
гадаад бодлогын байнгын хороон дээр

ушигдсан. Улсын Их Хурлын гишүүн Үндраа Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр ушигдсан. Эдийн засгийн байнгын хороон дээр ушигдсан.

### Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Манай бүлгээс өгсөн санал дээр Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн түвшнийг Төсвийн байнгын хороон дээр санал өгсөн нь сая ушигдсангүй гэж байна. Б.Түвшиний хувьд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын холбооны ерөнхийлөгчөөр ажилладаг.

Тийм учраас энэ бид бүгдийн хувьд заавал Төсвийн байнгын хороонд оруулах шаардлагатай гэж үзэж байгаа. Би энэ дээр тайлбар хийе.

Байнгын хороодыг хуваарилахдаа өмнөх Улсын Их Хурлууд нам эвслийн авсан суудлын тоонд харьцуулж Байнгын хороодод квот тогтоож хуваарилдаг. Энэ квотын дагуу өнөөдрийн 126 гишүүний 53.9 хувийг МАН, 33.3 хувийг АН, 6.3 хувийг Хүн нам, Үндэсний эвсэл Иргэний зориг ногоон нам тус бүр 3.1 хувийг эзэлж байгаа.

Тийм учраас байнгын хороони гишүүн хуулиараа 25 хүртэлх гишүүнтэй байхаар хуульчлагдсан байгаа учраас энэ эзэлж байгаа хувиараа Байнгын хороо тус бүр дээр МАН 13 гишүүн, АН 8 гишүүн, ХҮН нам 2 гишүүн, Үндэсний эвсэл болон Ногоон нам тус бүр 1, 1 гишүүн оруулах боломж бүрдэж байгаа. Тэгэхээр ялангуяа Төсвийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо зэрэг Байнгын хороод дээр Улсын Их Хурлын гишүүд орох хүсэлт их олноор ирж байна. Энэ олноор ирсэнтэй холбогдуулаад энэ квотоор тайрагдаж байгаа.

АН-ын бүлгээс ирсэн саналаар Улсын Их Хурлын гишүүн Түвшингийн санал Төсвийн байнгын хороон дээр 9

дүгээрт эрэмбэлэгдээж ирсэн байгаа юм. Ирсэн нэр дээр ирсэн дарааллаар. Тэгэхээр бид Улсын Их Хурлын гишүүдэд ижил тэнцүү хандах үүднээс ирсэн дарааллаар эхний 8-ыг нь аваад, 9 дэх хунийг бол оруулаагүй байгаа гэдгийг 1 дүгээрт нь хэлье.

Хоёрдугаарт гишүүд маань тайван байх хэрэгтэй. Улсын Их Хурлын хуралдааны дэг, зохион байгуулалттай холбоотой асуудлаар Байнгын хороонд орох тодорхой зохицуулалтууд байгаа.

Жишээлбэл Засгийн газрын гишүүд нэг Байнгын хороонд 2-оос илүүгүй байна гэдэг нэг заалт байна. Засгийн газрын гишүүн нэг Байнгын хороонд харьялагдах хуульчилсан зохицуулалт нь байж байна. Тэгээд энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудал шийдвэрлэгдээд Засгийн газрын гишүүнээр сонгогдож томилогдсоны дараа Байнгын хороод дээр хөдөлгөөн орох боломж дахиж нээгдэнэ ээ. Тэгээд энэ үед нь Байнгын хорооноос зохион байгуулалтын асуудлуудыг бүлгийн дарга, намын удирдлагуудтай ярилцааж, дахин өөрчлөлт хийх боломж байгаа гэж ингэж үзэж байгаа.

Тэгэхээр өнөөдөр Улсын Их Хурлаа байгуулах үүднээс Байнгын хорооны бүрэлдэхүүнийг баталж байгаа. Яах вэ энийг тэгээд зохион байгуулалтын асуудал эргээд хийгдэх боломжтой юм чинь бүгдээрээ ярилцаад дараачийн хурал дээрээ зохицуулалтаа хийгээд явчихъя аа. Ер нь Улсын Их Хурлынхаа үйл ажиллагааг бүгдээрээ аль болох нээлттэй уян хатан байдлаар зохион байгуулж авч явна. Нэг орсон бол орсон гэдэг байдлаар асуудалд хандахгүй.

Ер нь энэ Төсвийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо зэрэг гишүүд олноороо орох хүсэлтэй Байнгын хороодын зохион байгуулалт дээр харилцан ярилцаад зохицуулалт хийж болно гэж ингэж үзэж байгаа. Иргэний зориг ногоон намын дарга

Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн  
Батбаатар.

**Б.Батбаатар:** Иргэний Зориг ногоон нам энэ парламент нэг хувь нь өөр боловч 5 улс төрийн хүчинээс бүрдэж байгаа. Цаашицаашидаа бид нар Улсын Их Хуралд бүлэгтэй байхын төлөө ажиллана. Хууль дэг номд нь өөрчлөлт оруулах чиглэлээр та бүхнийг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна. Манай нам 4 гишүүнтэй учраас бүх Байнгын хороонд харьялагдаж чадахгүй. Тийм болохоор намын сонгогчдод амласан, сонгогчдод танилуулсан, сонгогчдоос санал авч баталсан манай намын мөрийн хөтөлбөр гэж байгаа. Энэ сонгуульд орсон. Тэр сонгуульд орохдоо бид нар 23 хуулийн төсөл барьж орсон. Тэгээхээр энэ ажлуудаа хэрэгжүүлэхийн тулд Байнгын хороод дээр аль Байнгын хороонд орох тал дээр намын зүгээс саналыг нь авах нь зүйтэй байх аа. Тэгээд дараагийн удаа өөрчлөлт оруулъя гэсэн учраас тэгэхгүй бол нөгөө бүлэгтэй биш байна аа гэдэг утгаар нь намын саналыг авахгүй, ард түмний 5-аас дээши хувийн санал авсан энэ улс төрийн хүчинийг орхиж явж болохгүй шүү гэж сануулмаар байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Бүх зүйл Улсын Их Хурлынхаа дэгийн тухай хуулиар зохицуулагдана. Бүлэггүй гишүүд өөрийн хүсэлтийг Улсын Их Хурлын даргад гаргах эрх зүйн зохицуулалттай гэдгийг ойлгох ёстой. Намын зохион байгуулалтыг та бүхэн нам дотроо ярих нь зүйтэй. Энэ зохицуулалтыг Улсын Их Хурал дээр хийж өгөх боломжгүй гэдгийг ойлгох нь зөв болов уу гэж бодож байна. Ингээд эцсийн найруулгыг сонссонд тооцье. Одоо Байнгын хороод хуралдаж дэд хорооддоо байгуулна. Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж хэлэлцэх асуудлын дараалалд байгаа Монгол Улсын Ерөнхий сайдыг сонгох асуудлыг хэлэлцэхээр байгаа. Ингээд үдээс өмнөх хуралдааныг завсарлуулъя.

Үдээс хойших хуралдаан 14 цагт.

## ЗАВСАРЛАГА

**Д.Амарбаясгалан:** Ингээд үдээс хойших хуралдаанаа эхлүүлье.

Байнгын хороодын хурал хуралдаж дуусаагүй, дэд хороодоо бүрэн сонгоогүй байгаа учраас Байнгын хороон дарга болон Дэд хорооны бүрэлдэхүүний асуудлыг хойшилуулаад хэлэлцэх асуудлын дарааллын дагуу дараачийн асуудал руу орьё.

Ингээд Монгол Улсын ерөнхий сайдыг томилох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын ерөнхий сайдыг томилох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх танилуулна.

Эрхэм хүндэт Ерөнхийлөгч таныг индэрт үрьж байна.

**У.Хүрэлсүх:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дунгээр Улсын Их Хуралд олонх суудал авсан МАН-аас Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшүүлэн 2024 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлжээ.

Монгол Улсын үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна гэж заасны дагуу Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд танилуулж байна аа.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ нь 1980 онд Улаанбаатар хотод төрсөн, 44 настай, эхнэр, 3 хүүхдийн хамт

амьдардаг. Тэрбээр 2001 онд Бээрс дээд сургуулийг сэтгүүлч, 2008 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрхзүйч 2011 онд МУИС-ийн Улс төр нийгмийн шинжслэх ухааны сургуулийг улс төр судлаач мэргэжлээр тус тус төгсөөж, 2015 онд АНУ-ын Харвард Геннееди их сургууль, Төрийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан байна аа.

2001 онд Хэнтий аймгийн Бэрх хотын Захирагчийн албанад Тамын газрын дарга, 2002-2008 онд Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын хөгжлийн хөтөлбөрийн удирдагч, бусийн захирал, 2008 онд Нийслэлийн БЗД-т Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, 2009 онд МАН-ын Удирдах зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга, 2010-2014 онд Нийгмийн Ардчилал МЗХ-ны ерөнхийлөгч, 2011 онд МАН-ын ЕНБД, 2012 онд МАН-ын ЕНБД-ын үүрэг гүйцэтгэгч, 2016 оноос одоог хүртэл Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2019 оноос Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, 2021 оноос Монгол Улсын Ерөнхий сайдын албыг хашиж байна аа.

Монгол Улсын ерөнхий сайдыар томилуулахаар санал болгосон Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийн асуудлыг Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Эрхэм хундээт Их хурлын гишүүд та бухний төрийн их ажилд амжилт хүсэж байна аа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхийлөгчид баярлалаа.

ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалан танилуулна аа. Индэрт урьж байна.

**Л.Энх-Амгалан:** Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дугаар хэсэгт заасан

бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг Монгол Улсын Ерөнхий сайдыар томилох саналыг Улсын Их Хуралд 2024 оны 7 сарын 5-ны өдөр оруулсан.

Монгол Улсын үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдыар томилох тухай саналыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 7 сарын 5-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцилээ.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийн намтрыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх танилуулсан тул намтрыг товчлон уншьяа. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг Монгол Улсын Ерөнхий сайдыар томилох саналыг хэлэлцисэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдыар томилох тухай саналыг хэлэлцисэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ингээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байгаа эсэхийг асууж тодруулж байна аа.

Төхөөрөмжөөр санал асуух гишүүд маань төхөөрөмжөөрөө нэрсээ бүртгүүлэхээр байгаа. Асуулт асуух гишүүдийг нэрсээ өгөхийг хүсэж байна аа.

Ингээд Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүнээр тасаллаа.

Нэмж нэр авч байна гишүүд тэгээд бүртгэгдсэн гишүүний микрофон ногоон гэрэл асаж байгаа 8 хүн байна. Цогтгэрэл гишүүнийх орохгүй байна өөрөө ирцдээ ороогүй байна картaa хийгээгүй байна. Нэр ороогүй гишүүд байна уу? Ингээд 9 гишүүн байна.

Оюунсайханы Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн.

**X.Тэмүүжин:** Хамгийн түрүүнд нь би байгаа юм уу? нэг л асуулт асуух гэсэн юм аа. Саяын сонгуулиар МАН-ын зүгээс хамгийн хүчтэй Pi Ar гэдэг юм уу сонгогч олон нийт рүү хүргэсэн нэг мессеж авлигатай тэмцэнэ гэсэн ийм зорилт байсан. Системийн авлига гэж нэрлэж байгаад энэ тогтолцооны авлигатай холбоотой асуудал дээр нэлээн хатуу байр суурь илэрхийлнэ, нэлээн зарчмын өөрчлөлтүүд хийнэ. Хүний өөрийн байхгүй хариуцлага тооцно гэдэг ийм зарчим явсан байсан. Тэгээд би нэг л асуулт асуух гэж байгаа юм. Анх АТГ-ыг байгуулахдаа бид бол нэг тийм гүйцэтгэх эрх мэдэл юм уу, хууль тогтоох юм уу хаана байгаа нь мэдэгдэхгүйгээр байгуулсан. Тэгээд 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбогдуулаад АТГ, Ерөнхий сайдын буюу гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд бүрэн шилжисж орсон байгаа. Гэхдээ нэг том алдаа байгаа. Хөрөнгө орлогын мэдүүлэг болон соён гэгээрүүлэх чиг үүрэг бол парламентын хяналтын хамгийн чухал чиг үүрэг байдал. Төрийн албыг ёс зүйтэй байна уу, сонирхлын зөрчилгүй байна уу тэнд ямар нэгэн аргаар төсөв, санхүү зарцуулах болон чиг үүрээ хэрэгжүүлэхдээ үндэслэлгүйгээр хөрөнгөжөөд байна уу угүй юу гэх мэтчилэн олон хяналтыг хэрэглэхэд нь парламентад зориулж энэ Хөрөнгө орлогын мэдүүлэг гэдэг систем ажилладаг.

Манайд бол одоо АТГ-ыг дагаад Засгийн газар буюу гүйцэтгэх эрх мэдэл рүү шилжихсэн байгаа.

Хоёрт нь соён гэгээрүүлэх чиг үүрэг. Мөрдөн шалгах болон соён гэгээрүүлэх чиг үүрэг 2 бол нэг байгууллагад давхцаж өрөөсөө олгогдож болдоггүй. Бид нар нэг байгууллагад энэ чиг үүргийг өгснөөсөө болоод гэмт хэрэгтэй нэг гараараа тэмцдэг нөгөө гараараа соён гэгээрүүлэх гэдэг энэ чиг үүрэг хэрэгжүүлдэг. Ийм юм болсноосоо болоод нөгөө мөрдөн шалгах чиг үүргийн байгууллагууд шүүх рүү нотлох баримт зөөх биши, хэвлэл рүү мэдээ гаргаж намнадаг болоод хувирчихсан. Хэвлэл сошиал дээр хүнийг харлуулж гүтгэж байна ухаад үзэхэд дандаа мөрдөн шалгах чиг үүргийн байгууллагууд байж байгаа. Хүнийг харлуулж гүтгэж доромжилчоод араас нь шүүх рүү аваачих гэж оролддог. Шүүх дээр очоод нотлох баримтын шаардлага хангахгүй унааж байдал. Ийм болоод хувирчихсан.

Тийм учраас энэ соён гэгээрүүлэх чиг үүрэг мөрдөн шалгах чиг үүргийг салгахгүй бол энэ дампуу үйл явц байнга байна аа. Дэлхийн жишгээр чинь бусад улс оронд соён гэгээрүүлэх чиг үүрэг болон ХОМ-ийг авч хянах чиг үүрэг чинь Төрийн албаны зөвлөл дээр байгаа.

Тийм учраас АТГ-т байгаа давхардсан энэ чиг үүргийг парламент рүү шилжүүлж Төрийн албаны зөвлөл рүү шинэтгэл хийх үйл явцад битгий саад болоорой гэж хэлж байгаа юм. Тэгвэл Авлигатай тэмцэх энэ үйл явц чинь сонирхлын зөрчилгүй үр дүнтэй болно шүү.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайд шууд хариулаад явчихъя.

**Л.Оюун-Эрдэнэ:** Баярлалаа. Тэмүүжин гишүүний асуултад хариуља. 1990 онд ардчилсан хувьсгал болоод маш гоё итгэлтэйгээр ард иргэд эхэлсэн. Хэдийгээр тухайн уед картын бараатай

байсан ч гэсэн бүгдээрээ итгэл нийдвартай урагшилсан. Зориг нэг зүйлийг хэлж байсан. Эхлээд улс орны эрх ашиг нэгдүгээрт байна, дараа нь намын эрх ашиг байна. Тэгээд хувь хүний эрх ашиг байна гэсэн. Харамсалтай нь энэ эрх ашигийг яг эсрэгээр нь хийсэн. Хувийн эрх ашигийн төлөө намыг ашигладаг. Тэгээд улсаа тонодог болсон. Сүүл рүүгээ Зоригийн хөшөөгөө Сүхбаатарын талбайтайгаа худалдах хүртлээ л дамжуурлаа.

Тэгээд мэдэхгүй энэ 30 жил дотор тэгээд авлигалтайгаа тэмцэхгүй яасан юм гэж би боддог юм. Нам харгалзахгүй зөндөө зүйл болсон. Олон ч парламентын гишүүд дээр уйлаан майлаан болсон. Би энэ тэмцлээсээ ухрахгүй. Тэмүүжин сайд орж ирснээрээ энэ тэмцэлд хувь нэмэр оруулна гэж маш их итгэж байгаа. АН мөн одоо таван ч том нам эвсэл бүрдсэн ийм парламент боллоо. Тэгэхээрээ энэ зүйл дээр ялангуяа бараг 50-аас дээш хувь нь солигдчихсон шинэ парламент, шинэ залуучууд, авлигалгүй нийгмийн төлөө та бүхэн маань ярьж байсан шигээ үнэн байж хунд хэцүү тэмцэл дундуур мэдээлэлтэй байж иргэдийн мэдэх эрхийг хангах олон сонсголууд байгаа. Тэр бүх зүйл дээр үнэлэлт дүгнэлт хийж Засгийн газарт Ерөнхий сайдад энэ авлигын эсрэг тэмцэл дээр дэм болоосой л гэж би чин сэтгэлээсээ хүснэ.

Соён гэгээрүүлэх болон тэр бусад чиг үүргийг ярилцаад явж болох байх аа. Гол нь яг энэ олон асуудлууд үнэн байгаасай л гэж би хүсдэг болсон. Нэг чиг үүрэг нэг тийш нь шилжүүлээд л заавал цаад талд нь өөр тийм хуйвалдаан байдал юм байна лээ. Далд тохироо ийм юмыг больчхооч. Ийм юмыг зогсоогоод өгчхөөч, энэ миний хамаатан, тэр манай ах дүү, тэр манай компанийн хувь эзэмшиж байсан ийм л яриа болдог юм билээ. Тийм биши байгаасай. Яагаад гэхлээр цоо шинэ парламентын эрин үе эхэлж байна. Хяналт тэнцэл бүхий цоо шинэ парламент бүрдэж байна. Шинэ 30 жилийн хуудас эхэлж байна.

Тийм учраас яг л эрх ашигийнхаа тэр эрэмбийг бүгдээрээ яг л хэвээр нь болгочихмоор байгаа юм. Эхлээд улс орны эрх ашиг, тэгээд намын эрх ашиг тэгээд хувийн эрх ашиг тэгж л үнэн байж чадвал их өөр ч өөрчлөлт энэ парламент гаргах байх аа. Тэгэхгүй урьдын адил явбал тэгээд л олон нийт дордоо л мэдэх байх. Тэгээд авлигалтай хийх энэ бүх тэмцэл дээр би Тэмүүжин гишүүн таны ярьдаг хяналт тэнцэл бүх зүйл дээр өөрийн зүгээс шаардлагатай бүх л зүйлээр үзэл санааны хувьд хамт байжс хамтран тэмцэх болно гэдгээ илэрхийлье ээ.

Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:**  
Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуулт асууна аа. Баярлалаа.

**П.Наранбаяр:** Тэгээд миний асуулт ер нь товч. Өнөөдөр төр нийгмийн хооронд үл итгэлцэл үүсгэсэн нэг гол зүйл бол энэ төрийн алба. Төрийн алба маань данхайгаад төрийн алба маань өөрөө шударга бус байдал ингээд ноёлоод ирчихсэн учраас үзтэл үнэнээр явагчийг ургэлж өөд нь дэмжих ёстой төр. Үзтэл хуурмагаар явагчийг ургэлж өөд нь дэмжссэн өөрөөр хэлбэл мерит зарчимд тулгуурлаагүй ийм төрийн алба болж хувирсанд миний бие эмзэглэж явдаг. Ганц хоёрхон тоо хэлье. Жишээлбэл төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцийн ашиглалт ердөө 38 хувьтай байгаа.

Өөрөөр хэлбэл 3 хүний нэг нь тэндээ шалгалтаа өгчхөөд ажилдаа орж чадаагүй ийм нөхцөл байдалтай байна. Мөн 2012 онд 9 байсан яам өнөөдөр 16 болоод нэмэгдчихээд байж байна. Агентлагуудын тоо 39 болчихсон байна. Нийт төрийн албан хаагчийн тоо нь 226 мянга. Энэ хөдөлмөрийн зах зээлийнхээ 18.2 хувийг эзэлж байгаа өссөөр байна.

Тэгэхээр энэ дээр энэ чиглэл дээр Ерөнхий сайдын хувьд төрийн албыг хэрхэн цомхон чадварлаг болгож

ажиллуулах ямар бодлого барьж байна вэ. Мөн ингээд мэдээж шинэ парламент бүрдээд янз янзын яамдууд ингээд янз янзын хүн дээр очно улс төрчид дээр очно. Төрийн албыг минь битгий самраасай л гэж хүсэж байна. Самарч болохгүй. Төрийн захиргааны алба чинь энэ чинь өөрөө тусгай хуультай.

Энүүгээрээ явах ёстой. Энэ дээрээ хэдэн хувийг нь өөрчилнө хэдэн хувийг нь өөрчлөхгүй гэсэн ийм тодорхой тоо узуулэлт байна уу? Яг АНУ-д явдаг шиг байдаг шиг Японыг нь зориод манаих төрийн албаныхаа хуулийг хийчихсэн. Гэхдээ энийг хэзээ ч хэрэгжүүлж байгаагүй.

Тийм учраас би Америкт байдаг шиг энийг асуучихъя. Хэдэн хувийг нь өөрчилж хэдэн хувийг нь өөрчлөхгүй байх вэ. Ингэж байж төрийн залгамж чанар чинь өөрөө бүрдэнэ гэж харж байна. Энэ чиглэлээр таны бодол бодлого ямар юм зүйл байна вэ? Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Баярлалаа гишүүний асуултад хариулаа.

Маши чухал асуудал хөнлөө. Бид эхлээд үнэт зүйл ерөнхий идеологи юу байх вэ гэдэг дээрээ илүү тулгуурлаад тэгээд түүнийг ямар хөтөлбөрөөр хэрэгжүүлж ямар хугацаанд ямар үр дүнд хүрэх вэ гэдгээ 2 дугаарт тавиад 3 дугаарт ямар бүтцээр хийх вэ гэдгийг 3 дугаарт тавиад үүн дээрээ хэнээр хийлгэх вэ гэдэг хүний нөөцөө 4 дүгээрт тавиад ингээд төсвийг яаж хэрхэн босгох вэ гэдгийг нэг үгээр хэлбэл улсын төсвөөр босгох ихэнх зүйлийг шийдэх боломжгүй учраас энэ орчныг яаж бүрдүүлэх вэ гэдгээ 5 дугаарт тавиад ингэж явах ёстой зүгээр.

Манай яг төрийн байгууллагын онөөдрийн бүтэц ер нь 1990-ээд оны эхэн

уеийн системтэй зарим талаараа одоо хүртэл адилхан байгаа.

Хоёрдугаарт дундуур нь өөрчлөлтүүдийг хийж байсан гэхдээ дандаа хагас болсон. Яагаад гэвэл Засгийн газрын дундаж нас дандаа л 1.5 жил ер нь голдуу байсан. Тэгэхээр одоо ингээд шинэ парламент бүрдчихэж байгаа учраас би нэг нам давамгайлж байгаа тохиолдолд яг ийм том хэмжээний реформ хийгдэх их тийм эрсдэлтэй нийгэм ч өөрөө хулээж авахгүй ингээд байдаг бүлтэрчих гээд.

Тийм учраас одоо ингээд олон намын тогтолцоо орчихсон байгаа тохиолдолд төрийн албаны энэ бүтцийг нэлэн тийм том хэмжээнд яг шинэ 30 жилд нь тохируулаад реформ хийх юмсан гэдэг ийм бодолтой байгаа. Энэ нь юу вэ гэхээр аливаа асуудлыг дундаа орхидоггүй байх ёстой. Одоо манайх дундаа орхичихдог. Жишээлбэл нийгмийн хамгаалал хөдөлмөр гээд байхад сайд нь жишээлбэл нэг салбарaa илүү ингээд барид явчихдаг. Аялал жуулчлал байгаль орчин гээд байлаа гэхэд байгаль орчин талынх нь хүн байгаль орчноо илүү талаа барид ингээд явчихдаг. Хүүхэд гэр булийн агентлаг гээд тэгэхээр хүүхдийн байгууллагаас томилогдсон нь хүүхдийнхээ асуудлыг залуучуудын байгууллагаас томилогдсон залуучуудынхаа байгууллагыг л тулгуу яваад байдаг. Дунд нь ингээд орхигдчихдог.

Тийм учраас одоо таны түришлага судалсан гэх юм уу суралцсан Япон улсад бүх л асуудлыг нэг нэг хүн хариуцдаг байгаа. Ковид болсон ч эрхэлсэн сайд мөн аливаа асуудлын газар хөдлөлт болсон ч тухайн хүнийг яг эрхэлсэн асуудал шийддэг. Тэгэхээр сонгодог парламент бол өөрөө илүү яг эрхэлсэн сайдтай байх яг тэр Шинэ Зеланд, Сингапур эд нар гээд тэр загвар луугаа орвол их сайн. Дундаа орхигдохгүйгээр. Энэ тохиолдолд төрийн албаны данхгар бүтэц хамгийн багадаа 30 орчим хувиар буурна. Маш их олон хоорондоо уялдаггүй агентлагуудын тоо

багасах нэг үгээр хэлбэл тулгамдаж байгаа асуудлаа бид нар яг толинын тусгал шиг өөдөөс нь харуулаад бүтэц хийнэ гэсэн уг. Одоо бид нар хот байгуулалтын талаар бүтэц хийе ээ гэж байгаа бол хотын бүтцээ шууд урд талдаа тавиад л төсвөө тавиад явна. Тэгээд бух юмыг ажлын хэсгээр шийдэх гэж ирсэн нь өөрөө алдаа болсон гэж би хувьдаа дүгнэдэг. Гэхдээ мэдээж төрийн байгууллагын бүтцийн тогтвортой байдлыг хадгалах нь зүйтэй.

Тэгээд цаашидаа яг энийг бол улс төрийн намуудтай зөвшүүлж чадвал нэлээн тийм том хэмжээний бүтцийн өөрчлөлт хэрэгтэй. Тэгээд дээрээс нь ийм эрх мэдэлгүй гэх юм уу төсөв захиран зарцуулж чаддаггүй ийм бүтцийг ер нь танах ёстой гэж бодож байгаа. Жишээлбэл яах вэ учлаарай би зүгээр илэн далангүй л ярья.

Жишээлбэл дэд сайд бол сайд нь ч юм хийлгэдэггүй, төрийн нарийн ч юм хийлгэдэггүй ийм дунд нь байдаг л ийм ажил. Яах вэ байх ёстой бэлтгэгдэх ёстой мөн үү мөн. Гэхдээ яг үнэндээ юу ч шийдэж чаддаггүй. Тэгэхээр энэ асуудлыг бид нар яг яаж төсөвтэй яаж эрх мэдэлтэй болгох вэ? Дуургийн нийгмийн даатгал байна, нийслэлийн нийгмийн даатгал байна. Дүүргүүдээс тайлан авч нэгтгэдэг л байгууллага. Улсын ерөнхий газар байж байхад хажууд нь нийслэлийн ийм бүтэц байх хэрэгтэй юу үгүй юу бodoх л ёстой асуудал. Гэх мэтчилэн ийм томоохон 4 дүгнэлт байдаг юм байна лээ. 4 дүгнэлт байгаа.

Аль нэг дүгнэлтээр нь яг бүтэн шийдвэрлэх тийм зориг гаргаж байсан тохиолдол байхгүй.

Тийм учраас авлигатай тэмцэх ч гэсэн нэг том тэмцэл бол эрх мэдэл бүхэн хяналттай.

Хоёрдугаарт гэвэл бүх хүний ачаалал жигд. Тэгээд бүгдээрээ ийм адилхан функцтэй байх нь чухал.

Дээрээс нь бас нэг зүйл. Энэ журмуудыг өөрчлөхгүй бол манайх хууль биш ийм журмын улс болчихсон байгаа. Тийм учраас хууль дээр энэ Их Хурлаас дэмжлэг хүсэхэд энэ олон журмуудыг бүтэн цэгцэлж яг хуульчилж өгөхгүй бол үндсэндээ бүх зүйлийг журмаар зохицуулсаар байгаад яам, Тамгын газар болон бусад байгууллагууд дээр маш их хэмжээний ийм зүгээр хувь хүнээс хамаарсан ийм эрх мэдэл төвлөрсөн зүйл байгааг нуугаад яах вэ. И Монголиаг нэлээдгүй хэмжээнд өөрчилж байгаа. Гэхдээ мэдээж 1, 2 жилийн хугацаанд яг ийм эрх зүйн реформ бүтэн явдаггүй та бүхэн мэдэж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Бөхчүлүүны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Өнөөдөр дэд даргаар томилогдож олонхоор сонгогдсонд баяртай байна. Та бүхэндээ баярлалаа.

Тэгэхдээ З зүйлдээ нэг жоохон төвлөрүүлж ажил хийнэ гэж бодож байна. Тэгэхээр сөрөг хүчинийхээ үүргийг биелүүлээд явна аа. Яагаад гэвэл ард түмэн бид нарыг сөрөг хүчин гэж сонгосон. Тийм учраас өнгөрсөн 8 жилийн туршид эрх баригчдын олон олон хулгай гарсан байгаа. ЖДҮ, концесс, тендер, Хөгжлийн банк, нүүрсний хулгай, Төмөр замын хулгай, ковидын хулгай, аптекийн хулгай, ногоон автобусны хулгай, боловсролын зээлийн сангийн зэрэг олон олон хулгайнууд гарсан. Энэ хулгай хийсэн зарим нөхдүүд энэ тэр хулгайлсан мөнгөнийхөө хусмыг зарцуулж ард түмний саналыг авч гарч ирсэн зарим хүмүүс бий.

Тийм учраас Ерөнхий сайд авлигатай тэмцэнэ, хулгайтай тэмцэнэ гэж энэ сонгуульд маш том амлалтыг авч орж ирсэн.

Тийм учраас энэ хулгай хийсэн нөхдүүдэд сард нэг нөхрийг хариуцлага

тооцож явуулах тэр ард түмний өмнө авсан амлалтаа биелүүлэхийн төлөө хамтарч ажилана гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт нь намын хөтөлбөрийг, намын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ өөрийн бас нэг хувийн зорилт байгаа. Таван хууль эхний ээлжид батлуулах зорилтой байна. Эхэнд нь нэгдүгээрх нь НӨАТ-ын татварыг 5 хувь болгох хуулийн төслийг 2020 оны 5 сард өргөн барьсан. Энэ хуулийг батлуулж ард иргэдийгээ хямдхан бараа бүтээгдэхүүнээр хангах тэр боломжийг гаргахын төлөө ажилана.

Хоёрдугаарт нь давхар АМНАТ-ын тухай хуулийг 2017 онд баталж үүнээс болж 50 гаруй боловсруулах үйлдвэр хаагдсан байгаа. Тэгэхээр энэ давхар АМНАТ-ыг авахыг болцуулах энэ хуулийн төслөө батлуулж энэ 50 үүлдрийг буцааж хаалгыг нь нээх дахиад 50 үүлдрийг энэ 4 жилийн туршид нээх шинээр оруулах ийм зорилтыг гаргаж байна.

Гуравдугаарх нь хуурамч шатахууны эсрэг хуулийг дахин батлуулж энэ ард түмнийхээ машин, мотоцикл тэр бүх зүйлийг хамгаалах ажлыг хийнэ.

Дөрөвдүгээрх нь Бор тээгийн уурхайг олон нийтийн нээлттэй компани болгох тогтоолын төслийг бэлтгэчихсэн тун ойрын үед өргөн барина. Ингэж ард түмэндээ энэ Бор тээгийн уурхайг буцааж авчирна. Эдгээр хуулиудыг батлуулсны үр дунд эдийн засгийн эрчимжилт бий болсны үндсэн дээр нэг хуулийг дагуулж батлах саналтай байгаа. Энэ маш хунд 40, 50 жил болоогүй зуд болсон.

Тийм учраас малчдын зээлийг тэглэх, Улсын Их Хурлын АН-ын бүлгийн тогтоолыг баталж энэ малчдын зээлийг тэглэхийн төлөө зорино.

Гуравдугаарх нь АН-ынхандаа хандаж хэлэх уг байна 8 жилийн туршид би нэг ч удаа энэ АН-ын тухай АН-ын хэн нэгний тухай ярьж энд сууж байгаагүй бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээр энэ АН хамтарсан засагт орох тухай асуудлыг ярьж байгаа. Тэгэхээр энийг дүрмийн дагуу хийх ажил байна аа. Өчигдөр АН-ын Улс төрийн зөвлөл хуралдсан.

**Д.Амарбаясгалан:** Энэ асуултын цаг явж байгаа шүү дээ Пүрэвдорж гишүүн ээ?

**Б.Пүрэвдорж:** Тийм ээ тэгж байгаа би сүүлд нь асуух гэж байгаа юм. 2024 оны сонгуульд АН....

**Д.Амарбаясгалан:** Пүрэвдорж гишүүн мөрийн хөтөлбөр ярих шиг боллоо. Ерөнхий сайдад микрофон өгье. Баярлалаа.

**Л.Оюун-Эрдэнэ:** Пүрэвдорж гишүүн бид 2 бие биеэ сайн мэднэ дээ. Тэгээд би л яг ярьсан хэлсэн зүйлүүд яг 2 узүүртэй тэгээд 1 нүүрний доор 2 амьдрахгүй байвал маш сайн. Тэгэхгүй ер нь яах вэ дээ тэгээд хүмүүс мэддэг юм даа тэгээд л. Нэг ярихаараа нэг өөр юм яриад л, нөгөө ярихаараа нэг өөр юм яриад л тэгээд л учиргүй гоё бодлого ярьж байснаа цаанаа дарга болчих гээд л ингээд л яваад байвал мэдэхгүй тэгээд бид нар ч гэсэн эргэлзээтэй.

Яагаад гэхээр анх Үндсэн хуулийг хийхдээ ер нь бид нар энэ хяналт тэнцлийг хангах нь зүйтэй юмаа л гэж хамтдаа хийсэн. Тэрэн дээр манай Пүрэвдорж гишүүн байсан. Манай Цогтгэрэл гишүүн ч байсан, манай Одонтуяа дарга, манай Ганбат дарга, Туваан бүгдээрээ л тэмцсэн. Бид нар ч гэсэн яг тухайн үед их л төвөгтэй л нөхцөл байдал байсан. Алтанхуяг дарга маань ч байж байна. Тэгээд бид нар бүгдээрээ л энэ хяналт тэнцэл бүхий олон намын тогтолцоо руу орох нь зүйтэй юм аа. Ингэж байж хамтарч олон асуудлуудыг шийдэх боломж бурдэх юм аа. Герман ийм Шинэ

Зеланд ийм гээд л бүгдээрээ яриад сууж байсан. Тэгээд та хэд маань байр сууриа нэгтгэх нь улсын эрх ашигт их хэрэгтэй болов уу л гэж бодох юм. Хувь гишүүн биш та Их Хурлын дэд дарга хүн. Яг одоо нам чинь ямар байр суурьтай байгаа юм? Заавал бид ингэнэ тэгнэ гэсэн юу ч байхгүй л байгаа. Тэгээд ингээд та хэд маань ингээд л нэг гараараа нэг юм яриад л, нөгөө гараараа өөр юм яриад байвал энэ бас их төвөгтэй нөхцөл байдал. Том агуулгаараа сонгогчдын санал бүхэнд л хүндэтгэлтэй хандах ийм л зарчим.

Тэгэхээр бид нар сонгогчдын санал бүхэнд л хүндэтгэлтэй хандахыг л маш их хичээж байгаа. Гол нь энэ бол хувь хүний тогтолт биш. 126-тاي парламент бол 76-тاي парламентаас ялгаатай нь энэ институцийн тогтолт. Тийм учраас институц иниституц шиг байгаасай, байр суурь байр суурь шиг байгаасай л гэж хүснэ.

Авлигатай асуудал дээр санал нэг байгаа. Маргалдахгүй тэмцэнэ. Саяын ярьсан зүйлүүдийг ярилцаад л явъя. Зүгээр яг ярилцаад шийдвэрлэх үед л өөр битгий байгаасай. Ярьж байгаа зүйлүүд дээрээ хэн нэгнийг аваад улдчихдэг битгий байгаасай. Ийм л зарчмын дагуу парламентаад суудалтай байгаа намууд хамтраад явбал өөрчлөлт гарна аа. Тэгэхгүй камерын өмнө нэг юм яриад камерын талд нэг юм яриад байвал энэ асуудал явахгүй.

Ард иргэдийн хувьд ч гэсэн маш их итгэлтэй байгаа. Энэ 126-тاي парламентаад шинэ 30 жилийг эхлүүлж байгаа гээд чин сэргэлээсээ парламентын сонгуулийн дараа тэд итгэсэн. Итгэлийг алдсан зүйл дандаа худлаа байсан л байхгүй юу.

Тийм учраас худлаа байхгүй. Яг ярьсан ярьсан, зарчим зарчим байж чадвал их чухал болов уу л гэж би зүгээр бодож байна. Тэгээд манай Пүрэвдорж гишүүний саналуудыг тэмдэглэж авлаа. Хамт ярилцаад явчхаж болох байх аа. Гол

нь та хэд маань байр сууриа нэгтгэх нь чухал болов уу л гэж миний хувьд бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Та чинь асуулт асуугаагүй юм чинь тодруулга байхгүй. Нэг минут.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр би зүгээр яах вэ хамгийн сүүлд ярих гэж байгаа зүйл маань засагт хэрвээ хамтарч байгаа тохиолдолд тогтвортой байгаасай л гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл АН-ын дүрмээр Үндэсний бодлогын хороогоор Засагт орох тухай асуудлыг шийдвэрлэдэг байхгүй юу даа. Тэгэхээр энэ улс төрийн зөвлөлөөр асуудал шийдээд ороод ирэхээр цаана нь нэг хэсэг хүмүүс дээр өөрөөр хэлбэл 400 гаруй Үндэсний бодлогын хорооны хүмүүс өөр бодол санаатай байх юм бол энэ засаг чинь тогтвортой байх уу, тэнд баахан хүмүүс улдчихээд янз янзын асуудал ярих уу гэдэг асуудал чинь л гол байхгүй юу.

Тийм учраас би энэ Үндэсний бодлогын хороогоор хэлэлциүүлэх асуудлынхаа л нам намынхаа нөхдүүдэд хандааж хэлж байгаа юм. Ингэж байж бид нар тогтвортой засагтай, илүү урт хугацаанд хамтарч энэ тал талын мөрийн хөтөлбөрийг биелүүлэх, энэ авлигатай тэмцэх, энэ хулгайтай тэмцэх, тэр уйл ажиллагаанд илүү хариуцлагатай орох тийм зүйлийг л би хэлж байгаа юм.

Тэгээд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Яах вэ би ч гэсэн хэлж байгаа нь дотоод асуудал чинь юм биш уу л гэж би хэлж байгаа юм. Энэ парламентын танхим төрийн ажил явж байна. Тийм учраас аль хурлаараа яаж хэлэлцэх нь та хэдийн маань дотоод асуудал юм биш уу? Надад одоо би аль 3, 4 хүнтэй зэрэг харьцахгүй нэг л субъекттэй л харьцааж чадвал тэр өөрөө илүү төлөвшил юм биш уу л гэж. Тэгэхгүй

бол ингээд 2, 3 юм яриад байхаар бид нарын хувьд ч гэсэн юм ярьж болохгүй тийм байдалтай байна шүү гэдэг энэ л агуулгыг хэлье. Тэгээд зарчмаа анхнаасаа л бариад явчаж чадвал илүү зөв байх болов уу л гэж.

**Д.Амарбаясгалан:** Батын  
Батбаатар гишүүн.

**Б.Батбаатар:** Улсын Их Хурал хамгийн эхний ажлаа эхэлж байна. Тангараг өргөснөөс хойши. Тэгээд бид нар бол парламентын засаглалыг бэхжүүлэх улс төрийн намуудыг төлөвшүүлэх чиглэлд өнгөрсөн Их Хурлын гаргасан шийдвэр, Үндсэн хуулийн өөрчлөлт, Улс төрийн намуудын тухай хуульд оруулсан өөрчлөлт, олон намын тогтолцоо, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн энэ бүх бүлгүүдийн санаа төлөөллийг оруулж ирэх гэж энэ шийдвэрийг гаргаж өөрчлөлт оруулсан түрүүчийн 2020-2024 оны Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье. 30 жилийн ойн шинэ 30 жил гээд ярьж байна. Би бусад гишүүдийн ярьсан зүйлтэй давхардуулахгүйн тулд цөөхөн юм л хэлье дээ.

Шинэ 30 жил өмнөх 30 жил гэж байна. Цагаан морин жилийн ардчилсан хувьсгалыг Монгол Улсын ард иргэд бүгд дэмжиж хүлээж авсан. Эрх баригчид нь ч тэр энгийн иргэд нь ч тэр тухайн үеийн МАХН-ын гишүүд нь ч тэр. Бүх нийтээрээ дэмжссэн тэр үзэл санаа, тэр итгэл үнэмшил, тэр эрэмбэ зарчим, тэр бүх зүйл өнөөдөр алдагдчихсан. Наад зах нь зарим зүйл дээр ч гэсэн засвар хиймээр байгаа. Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд наадам болоход ардчилсан хувьсгал гэдэг угийг хэлжээ байсан. АН-ын дарга удирдлагууд ардчилсан хувьсгал гэж ярихaa байсан.

Өнөөдөр засагт хамтрах хамтрахгүй тухайгаа дарга цэргүүд нь хоорондоо зөрөлөөд ярьж л байна. Яах вэ өөр намын асуудал учраас би ярихгүй дотроо шийднэ биз. Гэхдээ эрх ашигийн

эрэмбээ хөл толгойг нь байрыг нь сольчихсон шиг болсон. Иргэний Зориг ногоон намын хувьд бол ямар нэг байдлаар хэн нь хатгадгийг мэдэхгүй. Засагт орох гэж байна гэнэ үү, дэд сайдтай болгож байна ч гэнэ үү янз бүрийн юм яриад байгаа. Ардын намын дарга удирдлага аль нэгнээс нь ямар нэг хэл үг чимээгээ миний хувьд аваагүй. Бид нар засагт орохыг хүсэхгүй байгаа Засаг руу гүйхгүй байгаа. Бид бол цөөнхийг төлөөлж Монголд ус агаар мэт хэрэгтэй байгаа тэр сөрөг хүчний үүргийг биелүүлнэ гэж бодож байгаа. Чадна гэж бодож байгаа зоригтой байгаа. Тийм болохоор болж өгвөл Ардын намаас манай намд ямар нэг байдлаар санал явуулахгүй туйлаас баяртайгаар бид нарын санаа бодлыг дэмжиж байна гэж хүлээж авна. Тэгээд олонх цөөнх гэдэг тухай дахиад хэлмээр байгаа юм. Улсын Их Хуралд бүлэгтэй болох.

**Д.Амарбаясгалан:** Нэмэлт нэг минут.

**Б.Батбаатар:** Улсын Их Хуралд булэгтэй 2 нам нь олонх цөөнх гээд энэ дэд хороодод өөрсдийнхөө хүмүүсийг л оруулчаж байна. Тэгвэл Иргэний Зориг ногоон нам хэн юм, цөөнх юм уу, хэн юм. Мэдэх мэдэхгүйдээ асууж байгаа биши энэ дээр Их Хурлын дарга ч юм уу Ерөнхий сайд ч юм уу ямар нэг хариулт хэлж өгвөл сайн байна. Тэр ардчилсан хувьсгал гэдэг угийг оруулж өгөөч ээ. Энийг бүгд маргчихаад байна.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Бид ардчилсан хувьсгалын хамгийн их ярьж байгаа хумүүс бид болчоод байх шиг байгаа юм шүү.

Ер нь таны хэлдэг үнэхээр үнэн. Тэрнээс бид үнэн зүйлийг бүдгэрүүлэх гэж хэн нэгэн хүн Нобелийн шагнал авахын төлөө ардчилсан хувьсгалын болсон үйл явдлыг буруугаар бүдгэрүүлээд

Элбэгдоржтой холбоотой юм байхаар хүний эрх гэж ярьдаг хүмүүс нь бүгд дуугүй болчоод Булган, Содномдаржсаа гээд хүмүүс хүн биш. Бусад дээр нь хүний эрхийг ярьж болно. Элбэгдорж холбоотой учраас чимээгүй л байя. Одоо манай Пүрэвдорж дарга их цагаатгалын комиссын дарга шүү дээ та. Одоо харж л сууя. Үндсэн хуулийн дагуу тэгши харж чадах нь уу үгүй юу.

Тийм учраас би санал нэг байна. Бид ийм л зарчмын төлөө Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг хийсэн. Илүү мэтгэлцээнтэй, илүү хяналт тэнцэлтэй ийм парламентыг үүсгэх гэж нээлттэй ингээж ярих гэж яах вэ. Мэдээж Үндсэн хуулийн энэ өөрчлөлт сонгодог парламентын зарчмын дагуу хэрвээ одоо мөрийн хөтөлбөрийн хувьд зарчмын хувьд нэгдээж чадсан тохиолдолд хамгийн олон суудал авсан дараагийн намаасаа эхлээд зөвшилцдөг. Энэ аль ч парламентад тийм. Германад тийм 100 жил л ийм явж байгаа. Шинэ Зеланд тийм. Тэгэхээр яг тэр саналын дагуу л зөвшилцэж байгаа зүйл байгаа. Тэрнээс яг тэгнэ ингэнэ гэсэн зүйл байхгүй яригдаж л байгаа зүйл. Гэхдээ төр бүрдэх ёстой. Төрийн үйл ажиллагаа доголдолгуй явах ёстой. Энэ л агуулгаараа л хандаж байгаа. Нэг зүйл нь бол хүн эхэлж ярьсан нэг ч зүйл байхгүй байгаа үнэн. Баярлалаа. Та яг үнэнийг хэлсэнд шууд ярилцсан зүйл байхгүй. Хэвлэлээр янз бурийн асуудлууд явж байгаа тэр зүйл би нэг л зүйлийг хэлж байгаа. Эхлээд зарчмаа тогтоно. Авлигатай, цахим засаглалтай, баялгийн реформтой санал нэгдвэл бид хамтарна. Тэрнээс зүгээр хүн яриад эхэлбэл тийм зүйл хийхгүй ээ.

Би намынхаа хамт олон дунд ч гэсэн энийг хэлсэн байгаа хүн бүртэй бид нар яриагүй. Яагаад гэвэл бид нар 30 жилээ өөрчилье гэж байгаа юм. Ийм зарчимтай зүйл рүү явах нь чухал юм аа. Тэгээд би Иргэний Зориг Ногоон нам орж ирсэнд маш их баяртай байгаа. Ингэснээрээ илүү парламентыг яг ялангуяа ногоон хөгжлийг илүү шударга ёсыг илүү ардчилсан хувьсгалыг илүү

Зоригийн үзэл санааг би амьдруулахад чухал тийм контраст өнгө болж чадна гэдэгт итгэл дүүрэн байгаа. Тэгээд Батбаатар даргад баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Равжихын Эрдэнэбүрэн гишүүн.

**Р.Эрдэнэбүрэн:** Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Тангараг өргөснөөс хойши анх удаа анхныхаа микрофоныг авч байна. Тийм учраас итгэл хүлээлгэсэн.govийнхондоо талархлаа илэрхийлж байна. Хэлсэн ярьснаа хийх гэж бүтээхийн төлөө зүтгэх болно oo гэж хэлмээр байна.

Тэгээд Ерөнхий сайдас 2 асуулт товчхон асуух гэсэн юм аа. Мэдээж авлигатай тэмцэх талаар их ярьсан. Тэгээд яах вэ гол нь хууль ном, хүнтэй ярихаасаа илүү энэ авлигалийн үндэс суурь ялангуяа энэ төрийн оролцоо их байгаа.

Дээр нь энэ төрийн өмчийн компаниуд энэ эдийн засаг чинь бараг хэчинээн ч хувийг нь эдэлж байгаа 60, 70 хувийг нь эзэлж байх шиг. Ийм байхад бол авлигалийг багасгах талаар ярихад хундрэлтэй гэж ингэж бодож байгаа юм. Тэгээд энэ талаар таны байр суурь ямар байгаа вэ?

Хоёрт нь орон нутагт хөрөнгө оруулалтууд нэмэгдэж байгаа, хийгдэж байгаа. Тэгээд үр дүн их муу байдаг аа. Энэ гол нь нөгөө иргэдийг оролцуулах өөрсдийг нь оролцуулах, ялангуяа орон нутагт тэдний хандлагыг өөрчлөх сэргэлгээг нь өөрчлөх энэ чиглэлээр ажил хийгдэхгүй яг л төрөөс бэлэн юмыг нь хийж өгөх гэж оролдоод байгаатай их холбоотой юм шиг санагдаж байгаа юм. Тэгээд цаашид энэ талаар ямар байр суурьтай байгаа вэ? Ийм 2 асуулт асуух гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Яах вэ нэг зүйл дээр нөгөө өндөг анхдагч уу, тахиа анхдагч уу гэдэг шиг хүн огт ярихгүйгээр авлигатай тэмцээ гээд байгаа юм л даа. Худлаа шүү дээ тэр чинь хүн л байжс таарна биз дээ. Системээ л хий битгий хүн ярь, өнгөрснөө битгий ярь зөвхөн ирээдүйгээ ярь гээд байгаа юм. Энэ чинь өнгөрснөө дүгнэхгүйгээр ирээдүйг дүгнэх боломжгүй биз дээ.

Тэгэхээр системтэй нь ч хүнтэй нь ч хамт л тэмцэх ёстой л гэж хэдүүлээ яринаар байгаа юм. Тэрнээс энэ хүнийг битгий ярь аа зүгээр л системтэй нь тэмцичих ээ гээд. Төрийн өмч буруу. Гэхдээ Эрдэнэтийг хувийн мөнгөөр хувьдаа авчихъя гээд ингээд байвал болохгүй л дээ. Тэгэхээр хэдүүлээ би нөгөө нэг зүйл нь яг үнэн байя гэж яриад байдаг нь тэгээд л буруу бол буруу, хамт засаад л явчихъя. Нам дотор байгаа асуудлууд ямар асуудлууд байна тэрийг ярилцаад л ингээд л явчихвал их зөв болно. Тэгэхгүй бол ингээд нам гээд л ингээд субъектив хараад байхаар л хаацайлаад л, худлаа яриад л ингээд л ийм зүйл болчихно. Тэгэхээр тэгэхгүй л байвал их чухал.

Говьтой холбоотой асуудал дээр усжуулахаас авхуулаад орон нутгийн төсөв хөрөнгийг илүү шилжсих гэж тавиад байхлаар л дуусахгүй байгаад байгаа юм. Тэгэхлээр одоо хэдүүлээ бүсчилчхэж байгаа юм чинь хөрөнгө оруулалтын асуудлууд ер нь бүтэн дүнгээр аль болохоор энэ 3 жил 4 жилийнхээ бүрэн эрхийн хугацаанд бүтэн дуусах хэмжээнд л парламент маань Засгийн газраас орж ирсэн төсвийг нэг их өөрчлөхгүйгээр баталж өгч чадвал энэ маш их чухал аа. Тэгэхгүй бол амсуулаад ингээд 10 хувийг нь тавьчихдаг тэгээд нөгөөдөх нь 10 жил тэгээд дунд нь төсөв нь өөрчлөгдөөд ингээд явчихдаг ийм гажуудлыг хэдүүлээ засах ёстой шүү. Тэгээд бүсчилсэн хөгжлөөр анх удаа тойрог томсож байгаа. Тэгээд би их ахиц гарна гэдэгт итгэлтэй байгаа.

Ялангуяа говийн бус нутаг мөн төвийн бус нутаг бол нэг нь ХАА-н нэг нь аж үйлдвэр, эрчим хүчиний том төрөлжссөн бус болно. Тэрэн дээр манай Эрдэнэбүрэн гишүүн туршилагатай илүү их хувь нэмэр оруулж хамтарч ажиллах байх аа гэж бодож байна. Засгийн газрын хувьд хөтөлбөрт хамгийн их хөрөнгө оруулалт орох 2 бус энэ 2 бус байгаа. Тийм учраас олон олон төслүүд дээр хамтран ажиллах ийм боломж гарна гэдэгт итгэлтэй байна. Тэгээд дахиад парламентад орж ирж байгаад танд баяр хүргэе. Их зарчимтай тийм дуу хоолойтой гишүүн байсан. Би ч таныг хүндэлдэг байсан. Тэгэхээр та орж ирснээр энэ авлигатай тэмцэх яг энэ систем төрийн өмчийн компаниудыг багасгах төрийн бүтцийг данхайлгахгүй байх энэ зүйл дээр хэдүүлээ хамтраад их том ахиц гаргаж чадна гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Батбаярын Жаргалан гишүүн.

**Б.Жаргалан:** Баярлалаа. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

2024 оны Улсын Их Хурлын сонгууль бол маш хүнд сонгууль байлаа. Томсгосон тойргоор явагдсан. Олон аймгууд нэг дор эмэгтэйчүүд, залуучуудад танигдаагүй хүмүүст их халгаатай дээрээс нь маш их хэмжээний мөнгөний нөлөө орсон мөнгө тараасан явдлууд их гарсан. АН-ын гишүүний амь насанд халдсан явдал хүртэл гарсан. Би энийг яагаад хэлж байгаа вэ гэхлээр сая СЕХ-ны даргын мэдэгдэл анхдугаар чуулганы нээлт дээр яваад бүх зүйл ийм гоё болоод өнгөрчихсөн юм шиг бүгдээрээ баяр баясгалантай тангаргаа өргөж байгаа юм шиг тийм сэтгэгдэл төрсөн учраас цохон тэмдэглэж байгаа. Маш их хар тиар явагдсан. Энэ дээр бид нар хөгжлийн бодлогын асуудлуудаа бол төдийлөн бодол мөрийн хөтөлбөрүүдээ уралдуулж чадсангүй. Энэ бүхний эцэст МАН 126 суудлаас 68 суудлыг буюу 53.9 хувийг энэ парламентад эзлэх болсон. Өөрөөр хэлбэл

Үндсэн хуулиар МАН бие дааж Засгийн газар байгуулах боломжтой ийм суудалтай болсон. Өчигдөр бол МАН-ын даргын гарын усэгтэй хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх тухай гэсэн гарчигтай зөвшилцөлд урьжс байна гэсэн албан бичиг АН-д ирсэн байгаа.

Тэгэхээр Ерөнхий сайдад нэр дэвшиж байгаа Оюун-Эрдэнэ гишүүнээс яг энэ энэ шийдвэрээ нэг тайлбарлахыг хүсье. Тэгээд аль аль намуудад ямар утгатай ийм зөвшилцөлд урьсан бичиг явуулсан бэ? Тэгээд яагаад ийм шийдвэр гаргах болсон, яагаад бие дааж Засгийн газар байгуулах тэр эрхээсээ татгалзаж байгаа вэ? Энэ асуудлаа тайлбарлаж өгөхийг хүсье.

Хоёрдугаарт өнгөрсөн 8 жилийн хугацаанд бол макро эдийн засгийн үзүүлэлтүүд бол төдийлөн ахисангүй. Тэр битгий хэл баян ядуугийн ялгаа улам бүүр нэмэгдэж байна. Жини коэффициент бол 40 гаруй хувь болоод 40 гарчихсан явж байгаа. Ядуурал буурахгүй байгаад байна. Ажиллах хүчин оролцооны түвшин бас жил ирэх тусам буурч байна. Хүмүүс ажил хийх сонирхолгүй болж байна. Тэгэхээр энэ макро эдийн засгийн асуудлуудаа хэрхэн яаж шийдвэрлэх бодолтой байна. Ер нь цаашидын ирэх 4 жилийн асуудал дээр яаж эдийн засгаа тэлэх вэ хамгийн гол нь яаж ядууралтай тэмцэх үү гэдэг асуудал дээр нэг товчхон хариулт өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа.  
Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Гишүүний асуултад хариульяа.

Би сая тайлбарласан. Нэгэнтээ бид тогтолцооны өөрчлөлт хийчихсэн учраас мөрийн хөтөлбөрүүдтэй холбоотой давхцуулахлаар яг өөрийн чинь хэлж байгаатай адилхан ийм тулгамдсан нэг юм шийдвэрлэхгүй болохгүй ийм асуудлууд байгаа Монголд. Жишээлбэл 30 жил бид нар эрчим хүчиний унийг чөлөөлөх

тухай, либераллах тухай ярьсан. Эрчим хүчиний үйлдвэрлэлийнх нь өртөг зарж байгаа унээсээ хэд дахин бага байдал аа. Харамсалтай нь бид нар үүнийг ярьж чадлаггүй айгаад байдал. Тэгээд эрчим хүчиний салбарын хөрөнгө оруулалт хийх ямар ч боломжгүй. Ингээд бүх эрчим хүчиний салбарууд дамжуурчихсан. Ингээд 4 дүгээр цахилгаан станц, тэгээд шугамууд нь шинэчлэгдэхгүй ингээд 30 гаруй жил болсон. Жишээлбэл энэ асуудлыг шийдвэрлэхэд энэ зөвшилцөл хэрэгтэй.

Тийм учраас би гэх мэтчилэн ийм нэг 4-өөс 5 асуудал байгаа. Жишээлбэл Улаанбаатар хотын энэ Бага Их тойрууд манай эрх мэдлийн 90 хувь төвлөрч байна. Хэчнээн бид нар тойрог зам тавилаа гээд эндээ ингээд бүгд байгаад байгаа нөхцөлд энэ хэцүү. Сая Тэмүүжин гишүүн анхдугаар чуулган дээр хэлсэн. Би санал нэг байгаа. Засгийн газар нүүх ёстой. Гэхдээ Үндсэн хуулиар заавал Засгийн газар нийслэлд байх ёстой гээд байгаа. Ингээд маргалсаар байгаад 34 жил болчихлоо. Уг нь ТЭЗҮ 86 онд гарчихсан юм байна лээ. Тэгээд ингээд 5, б удаа оролдлого хийгээд чадаагүй. Энийгээ шийдчихвэл энэ л их тийм том ахиц дагаад эрх мэдэл задарна. Хяналт тэнцлэтий парламент нь тусдаа, Засгийн газар нь тусдаа ингээд болно. Шүүх нь тусдаа тийм ээ тэгэхээр энийг хийчихвэл энэ их чухал.

Дээрээс нь хотыг тойрсон ийм хурдны зам хэрэгтэй. Газар чөлөөлөлт газар чөлөөлөлтийг хийгээд эхлэхлээр орон нутгийн сонгууль болно гээд нөгөө талд нь ингээд хөөргөөд, ингээд байхлаар хийгдэхгүй, тэгсээр байгаад 34 жил болчихсон. Тэгэхээр энийг ингээд хийвэл нийслэлийг тойрсон газар чөлөөлөлт буюу орон сууцжуулалтын том асуудлыг шийдвэрлэх боломжтой. Хөшигийн хөндийг бид нар төрийн албан хаагчдад зориулсан том хэмжээний орон сууцын бүтээн байгуулалтыг хийх боломжтой. Тэгээд ер нь яах вэ 4 жилийн бүрэн эрхийн хугацаа гэдэг 3 удаа төсөв хийх л эрх. Ер

нь яах вэ яг зүгээр төсөв талаасаа харвал маш хурдан явна. Тийм учраас бид нар илүү тийм прагматик бодитой зүйлүүд дээрээ төвлөрч чадвал чухал.

Энэ агуулгаараа хамгийн их суудал авсан АН хүн нам 2-т миний хувьд яг энэ хөтөлбөрүүдийн шийдвэрлэх саяын асуудлуудыг бичээд тэгээд геополитикийн хүндрэлтэй байгаа үед хамтарч бид нар мөрийн хөтөлбөр зарчим дээрээ нэгдсэн тохиолдолд хамтран ажиллахад бэлэн байна аа гэдэг л ийм л саналыг хүргүүлсэн. Гэхдээ хүсээж байгаа зүйл бол яг институцийн хувьд илүү тийм бат бөх ийм шийдвэр гаргаасай билээ л гэж хүсээж байгаа. Тэгэхгүй бол тэгээд энэ маргаанаас цааши хэтрэхгүй ийм зүйл болно. Энэ тохиолдолд бид нар дараагийн намуудад санал тавиад ингээд явах яг л нөгөө нэг сонгодог парламентын засаглал руугаа орох байх. Олон улсын энэ нийтлэг жишээгээр явахаас өөр сонголтгүй ээ гэдэг зүйлийг хэлье. Амжилт хүсье өөрт чинь шинэ үеийн төлөөлөл орж ирж байгаад баяртай байна. Гэхдээ хүний амь насан дээр дандаа улс төр хийгээд байх нь их зохимжтой зүйл биш шуу.

Мэдээж саяын сонгуульд маш харамсалтай зүйл болсон. Бидний хувьд чадах бүх зүйлээрээ л тухайн цаг үеийн сэтгэл зүй болон нөхцөл байдлыг үнэлж дүгнэж маш их харамсаж байгаагаа илэрхийлсэн. Гэхдээ түүнээс болж төрийн сонгууль таслах хэмжээний тийм улс төрийг хийгээд ингээд явбал цаашилаад ч гэсэн ингээд хэцүү. Ер нь зүгээр цаашидаа бид нар энэ намуудын ухуулагчдын тоог зөвхөн намын байхгүй бол энэ жил бараг 180 орчим мянган ухуулагч явсан энэ л их эрсдэлтэй.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. 76-тai парламент сонгуулийн үр дүнгээр 40-өөс 45 хувиар шинэчлэгдэж чаддаг байсан. Томсгосон тойрогтой, 126 гишүүнтэй парламентын 80 хувь шинэчлэгдэж чадсан байх. Одоо яг энэ танхимд сууж байгаа 126 хүний 80 хувь нь анх удаа парламентад сонгогдохгээ орж

ирж байгаа хүмүүс. Тэгэхээр энэ сонгуулийн талаарх дүгнэлтээ сайн судлах нь зөв байх аа гэж бодож байна.

Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилигийн Лодойсамбуу асуулт асууна.

**Ч.Лодойсамбуу:** Асуулт нь төгсгөлдөө байх нь шүү дарга аа.

Ерөнхий сайдад хүмүүс баяр хүргээд амжилт хүсэх байх. Тэрнээс өмнө энэ бол ерөөсөө баярт үйл явдал биш шүү гэдгийг сануулах гэсэн юм. Нийт сонгогчдын 62 хувь нь эсэргүүцсэн Ерөнхий сайд намтайгаа хамт орж ирээд Засгийн газраа байгуулах гэж байгаа. Нийт сонгогчдын 62 хувь нь энэ Ерөнхий сайд биш байна аа гэж дүн тавьсан. Яагаад тэгсэн бэ гэхээр ардчиллын индексээрээ бид нар сүүлийн 3 жилд огцом ухарсан. Өмчийн эрх гэж байхаа больсон. Уг хэлэх эрх чөлөө байхгүй болсон. Хэвлэлийн эрх чөлөөгөөрөө хойшио үсэрсэн. Сэтгүүлчдийг худалдааж авах гэж оролдоод наймаанд нь орохгүй бол гутгэж доромжлоод гэрт нь хүртэл хорьж байгаа. Авлигын индексээр бас хойшио үсэрсэн. Авлигатай тэмцэж байгаа гээд сая өөрөө хэлж байна хүлээн зөвшөөрч байна л даа. Авлигатай биш авлигачидтай тэмцсэн, авлигачинтай тэмцсэн. Авлигатай тэмцэнэ гэдэг нэртэй нэг хэдэн авлигачийн нэр л хэлсэн. Түрүүн Эрдэнэбүрэн гишүүн яг хэлж байна. Авлигатай тэмцэнэ гэдэг бол авлигын шалтгааныг авлига үүсэх нөхцөлийг арилгахыг хэлнэ. Тэр зүгт анхаарахыг бас хэлнэ. Тэр хэсгээ орхисон.

Манай Жаргалан гишүүн хэл хэлж байна. Хэтэрхий хар бараан ти ар хийсэн гэж. Үнэхээр өнгөрсөн 3 жил бол ялангуяа энэ жилийн сүүлийн хэдэн сар бол Монголын нийгмийг хувааж талиуулсан узэл суртлын аргаар нийгмийн оюун ухааныг хордуулж бохирудуулсан энэ үйл явдлыг ийм арга хэмжээнүүдийг хийсэн. Ер нь хүний хандлага бол ямар арга хэрэглэж байгаа, зорилгодоо хүрэхдээ

ямар арга хэрэглэж байгаагаасаа хүний хандлага шууд харагддаг л даа. Ренбүүк дээр чинь Монголын ард түмэн дүн тавьсан. Тийм болохоор энэ баяртай биш Монголын ард түмний хувьд гунигтай мэдээ шүү гэдгийг бас энд байгаа хүмүүстээ хэлье ээ гэж бодож байгаа. Тэгээд асуулт нь авлигатай тэмцье ээ, дахиад л тэнцье л гэж байна л даа.

Одоо Засгийн газар бүтэц, бүрэлдэхүүнээ яаж шийдэх бодолтой байгаа вэ? Одоо яг энэ байгаа энэ данхар бүтцээрээ явах уу? Нөгөө элсэж хамтрахаасаа болоод буур улам дахиад нэмээд явах уу яаж шийдэх вэ? Энэ хувийн хэвшлүүд чинь ажиллаж амьдрах боломжгүй боллоо. Одоо энд цалингаа тавьж чадахгүй дансаа хаалгачихсан хэд хэдэн томоохон үйлдвэр компанийд байна аа. Энэ төрийн дарамт дор чинь юу ч хийх боломжгүй болчихсон энэ нөхцөлүүдийг.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Би өөрийг чинь парламентад орж ирсэнд баяртай байгаа. Яагаад гэхээр та одоо бол төрийн эрх барих дээд байгууллагын гишүүн. Танд бүх мэдээллийг авах онцгой бүрэн эрх байгаа. Засгийн газрын, төрийн байгууллагуудын бүх мэдээллийг. Тэгэхээр гаднаас харах яг дотор орж ирээд хийх 2-т нэлээн ялгаа бий шүү.

Тийм учраас магадгүй би зүгээр өөрөөс чинь нэг зүйлийг хүсье. Тэр нь юу вэ гэхлээр үнэхээр яг үнэн байя гэж хүсвэл магадгүй б сар нэг жил ажиллаад өөрийн чинь яг саяын хэлсэн угэн дээр өөрөөс чинь бодож байгаа энэ бүх зүйлүүдийн факт өөр байвал чи бас яг эр хүн шиг энэ өөр юм байна лээ гэдгийг бас хэлээрэй. Харин хань болох ёстой олон олон асуудлууд өөр байдал юм аа. Жишээлбэл яг энэ танхимд авлигын эсрэг шүүх байгуулах асуудал яригдаж байх үед тэр орой сэтгүүлчийг хорих үйл ажиллагаа давхар болж байсан.

Алтанхуяг дарга мэдээж байгаа. Ерөнхий сайдын зөвлөх хоригдоод байж байхыг Ерөнхий сайд мэдэхгүй байх тохиолдол байдал юм уу? Энийг чи энд орж ирээд л ойлгоно. Хууль хяналтын байгууллагууд, шүүх засаглал дээр яг асуудлыг гаргаж ирээд тавих үед нийгмийн анхаарлыг холдуулах гэж юу болдог вэ гэдгийг.

Тийм учраас өнөөдөр би бас хэвлэл мэдээллийн дуу хоолой болсон олон хэвлэл мэдээллийн төлөөлөл парламентад орж ирсэнд баяртай байгаа. Тийм учраас яг ярьж байгаа шигээ л байвал их сайн. Тэгэхгүй нэг яриад л тэгээд нэг тийм өөр хүнтэй нэг юу хийгээд л яваад байвал тэгээд л яваандаа худлаа байвал тэгээд л баригдана манай Монгол чинь цөөхөн хүн амтай. Тэгээд л биеийн хэлэмжээс авхуулаад л дороо л уншигддаг ийм зүйл л дээ. Тэгэхлээр би өөрийг чинь үнэн байж чадах болов уу гэж хичээж байгаа. маш их талархаж байгаа. Тэгээд олон олон энэ мэдээллүүдийг илүү чи дотроос нь олон нийтэд зөв ойлголтыг өгөх ийм бүрэн боломж чамд байгаа. Өмч хувьчлал яг юу болсныг, баялгийн лицензүүд энэ танхимд Засгийн газраас орж ирээд ажлын хэсэг дээр яагаад өөрчлөгдчихсөнийг, гаднаас харж байгаагаас дотроос харах маш их өөр шүү.

Тийм учраас эрхэм парламентын гишүүн танд амжилт хүсээд мэдээллийг ил тод нээлттэй болгох энэ бүх зүйл дээр хамт байхыг хүсье. Авлигын индекс төсөөллийн индекс шүү дээ. Персепин асуудлуудыг гаргаж тавих тусам илүү төсөөлөл өсдөг нь дэлхийн нийтлэг жишиг шүү. Гаргаж тавихгүй байж болно. Гэхдээ гаргаж тавьсныг буруутгаад байвал тэгээд л чимээгүй л бүгдээрээ байж болно. Гэхдээ өнгөрсөн хугацаанд цахимжаад энэ 500 гаруй сангийн нээлттэй болсныг ингээд улс төржүүлээд байвал тэгээд л нуугаад л явдаг болно. Нуугаад явахад хэн ч намайг боль гэхгүй л байсан. Гэхдээ нээлттэй ярилцах нь зөв л гэж үзсэн шүү.

Тийм учраас энэ дээр тэр л дуу хоолойн дээр хүч нэмбэл их чухал. Шүүмжлэлтэй зүйлийг би хүлээж авна аа. Чадах чадахгүй, болж байгаа, болохгүй ойлгуулж чадсан, чадахгүй байгаа зүйлүүд зөндөө байгаа. Эдийн засгийн узүүлэлтуүд ч гэсэн сайн хараарай. Сүүлийн бараг 2-оос 3 жил ДНБ чинь мянга мянган доллароор ахичихсан байгаа шүү. Яах вэ угийсгэж болно. Гэхдээ бодитой бас тоонуудыг хэдүүлээ яриад л урагшаа явахгүй бол бүх зүйлийг ингээд байвал дордоо хий эргэсээр байгаад л явна. Тэгээд I мэдэхэд 2-оос 3 жилийн дараа та өөрөө парламентын гишүүний хувьд хариуцлага хүлээх тал руугаа явж эхэлнэ шүү. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа.  
Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Шинэ парламентад парламентын гишүүддээ амжилт хүсье ээ. Энэ парламентын сонгуулийн үр дүнд нэг нам 12 дахь жилдээ, нэг Ерөнхий сайд улиран сонгогдох ийм нөхцөл байдал уусэж байна аа. Тэгэхээр энэ богино биш хугацаанд бид нарт ер нь ямар асуудал хуримтлагдсан бэ? Бараг бүгдээрээ мэдэж байгаа. Бүгдээрээ мэдэж байгаа.

Нэгдүгээрт нь эдийн засаг өсөж байна гээд байдал. Асар их хэмжээний нүүрс зэс зарж байна гээд байдал. Ард иргэдийнхээ амьдрал сайжирдаггүй. Ядуурал нь нэг процентоор ч буурдаггүй он жилүүд, нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь авлигалтай тэмцэж байна гэдгийг бас угийсгэхгүй. Тэгэхдээ авлигалтай тэмцээд байхад авлигал нь буурдаггүй авлигалаан узүүлэлтуүд нь улам дордоод байдал олон улсын байгууллагууд нь тэгж дүгнээд байдал. Авлигалаан хэргүүд нь ихсээд байдал. Энэ яг ямар логиктой юм бэ гэдэг асуултыг Монголын ард түмэн бараг бүгд бие биеэсээ асууж байгаа байх гэж бодож байна. 7 хувь өслөө, 10 хувь өслөө гэдэг ядуурал нь нэг процент ч буурдаггүй 10 жилд. Тэгээд энэ өсөлт яг хэнд

хэрэгтэй юм бэ гэдэг яг энэ асуултын хариулт яг өнөөдөр энэ 2 дахia улиран сонгогдох гэж байгаа Ерөнхий сайдын тавигдах ёстой асуулт байх гэж бодож байгаа. Та яг энэ асуудлыг үндэс сууриар нь яаж харж байгаа юм? Яг энэ чигээрээ л бид нар эдийн засаг өсөж байна, гоё болж байна, их юм зарж байна гэдэг ард түмэн нь ядуу хэвээрээ ядуурал нь бараг ихсээд байдал ингээд л яваад байвал энэ чинь энэ бодлого зөв үү гэдэг. Авлигалтай тэмцээд байдал авлигалаан буурдаггүй ээ. Тэгэхээр таныг энэ дээр байр сууриа илэрхийлээч. Ирэх 4 жилд энэн дээр яаж бодлогын ямар ч байсан өнгөрсөн бодлогод чинь алдаа байна. Ямар ч байсан ямар ч л байсан. Тэгэхээр энэн дээр та яг ямар бодлогын өөрчлөлт барих гэж байгаа юм бэ? Миний хувьд энэн дээр би өнгөрсөн 4 жилд байнга л барьж ирсэн ганц л байр суурь байдал.

Монгол Улсын төр жижгээрэх ёстой. Эдийн засагт эзэлж байгаа төрийн хувь хэмжээ буурах ёстой л гэж боддог. Энэ асуудлын үндсэн суурь шалтгаан энд хэн бурхан ирсэн ч энэ авлигалаан яг энэ тогтолцоо нь буурахгүй. Таны засаглаж байсан 4 жилд эдийн засаг дахь төрийн оролцоо жилээс жилд нэмэгдсээр л ирсэн. Одоо бараг 40 хувьдаа хүрч байгаа төсвийн хувь хэмжээ. Тэгэхээр таныг үндсэн шалтгаантайгаа тэмцэхэд тийм улс төрийн зоригoo гаргаж удахгүй 1 сарын дараа орж ирэх Монгол Улсын төсөө дээр эхний байр сууриас чинь ингээд илрэх байх аа гэж би лав хувийн байр суурь таныг тэгээд сая шалтгаан нь энэ дээр үндэс шалтгаантай нь яж яаж тэмцэх гэж байгаа вэ, яаж тэмцсэн нь бодит үр дүн гарсан 4 жилийг төсөөлж байгаа вэ гэдгээ л таныг хуваалцаач ээ гэж хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа.  
Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Та ч мэдэж байгаа бид нар бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Манай экспортын 93 хувь уурхай учраас л ийм байдал. Энийг бид нар

бүгдээрээ л мэдэж байгаа. Тэгээд уул уурхайн наад стратегийн ордууд чинь хэдхэн л хүний өмчид байгаа бүгдээрээ тэр нь паблик компани биш. Та ч энийг мэдэж байгаа. Тэгээд энийг л уг нь яриад л Үндэсний баялгийн сан эд нар байгуулаад л яриад л явж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр манайд нүүрс, зэс гээд л ийм 2 том бүлэглэл л байгаа юм. Тэгээд уур уурхай, эдийн засаг, экспорт өсөөд байхаар яах вэ гэхлээр төсвийн орлого тэлээд байдаг тэр нь тэтгэвэр, тэтгэмж болж очих гэж байгаа нь сайн, хөрөнгө оруулалт болдог нь сайн. Харамсалтай нь бусад салбаруудаа татаж унагаачхаад байдаг. Тэгээд тэгэхгүй гээд ялтай билээ хөдөө аж ахуй, аялал жуулчлал гээд 2 салбарыг л бид нар татаж гаргаж ирэх боломжтой, 4 улиралтай, далайд гарцгүй ийм л зовлон бидэнд байгаа.

Тэгээд нөгөө талдаа уур уурхайн компаниудаа яг үнэндээ Монголын төр нь дийлэхээ больчихсон. Бүгдээрээ л сонгууль болохлоор уул уурхайн компаниуд дээрээсээ очиж хандив авчхаад. Тэгээд энд орж ирчхэнгүүтээ яагаад вэ гэж асуугаад ингээд л 30 жил явлаа шүү дээ. Тэгээд яах вэ дээ тэгээд хэдүүлээ ялтай билээ улс маань ийм л юм чинь. Харин энэнээс яаж гарах вэ гэдэг дээр л хэдүүлээ их тийм нягт байж чадвал гарна.

Хоёрдугаарт энэ тэгээд монопол шүү дээ. Манайхаас өөр улсад банкнууд Түү ажиллуулдаг ийм газар байхгүй шүү дээ. Эсвэл банк нь ингээд ийм том том төслүүд рүү ороод байдаг нэг нь хуутэй зээлтэй, нэг нь хүүгүй зээлтэй яаж өрсөлдөх юм бэ. Тэгээд ярихлаар хувийн хэвшил рүү дайрлаа гээд ингээд болиулчихдаг. Хувийн хэвшил ЖДУ-лэгчид гэдэг нэрэн дунд монопол нуугдаж байдаг. Энэнээс л болоод хүртээмжгүй байгаа шүү дээ. Өөр юу ч биш. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Гэхдээ яах вэ гэхлээр тэр лоббиндоо ороод л энийгээ ярьж чаддаггүй л болохоос.

Тийм учраас энийг бид нар энэ монополын эсрэг хууль мөн энэ паблик

компани болох, хөрөнгийн зах зээл ЖДУ-лэлээ дэмжих, уур уурхайгаас хэм хамааралгүй тулгууртай болох энэ бүх зүйлүүд рүүгээ хэдүүлээ хамтдаа л орох ёстой. Тэгээд энэ 1, 2 жилийн дотор шийдвэдэх зүйл биш шүү. Тэгээд эдийн засаг өслөө гээд бухимдаад байхаар тэгээд ялтай билээ? Эдийн засгийг ямар тэгээд хасах байлгальтай нь биш -4.7-той байвал төсөв ч байхгүй бизнес ч байхгүй л юм болно. Тэгээд одоо ямар ч байсан 7 хувьтай байна. Дэлхийн эдийн засаг дунджаар 3 хувьтай өсөөд явж байна. Тэгээд энийг жишээлбэл өсөөд байна гэж муулаад байх хэцүү 7-оос дээши хувь өсөж чадахгүй 7-оос дээши хувь өсвөл яг үнэндээ шатахуун нь ч тасраад дэд бүтцүүд нь ч дийлэхээ болиод бусад компаниуд нь ч хундэрнэ.

Яагаад гэхлээр нөгөөдүүл нь бүгдээрээ уурхай дээр байгаа. Тийм учраас энэ 4 жил эрчим хүч, хөдөө аж ахуй, экспорт, эрчим хүч бүгдийг аргамжиж байгаа та өөрөө мэдэж байгаа. Тэгээд аялал жуучлалтай холбоотой энэ асуудал дээр бид нар адаглаад 30 хувь руу очиж чадвал энэ их том амжилт болно. Мөн Баялгийн сангийн тухай хуулиараа бид нар ерөнхийдөө энэ том уул уурхайн компаниудыг олон нийтийн паблик компани болгож чадвал энэ их тийм чухал зүйл болно.

Тэгэхээр энийг та маш сайн мэдэж байгаа. Олон удаа ярилцаж байсан тэгээд энэ дээр хамтраад ингээд ер нь явах нь л зүйтэй. Ер нь бид нар асуудлаа мэдэж байгаа мөртөө зоригтой шийдвэл гаргаж чадахгүй л ингээд л яваад л байсан. Тэгээд одоо явж байна. Мэдээж бүгдийг нэг доор өргөс авсан юм шиг шийдвэж чадахгүй. Гэхдээ ахиц гарч байгаа. Авлигын индексийг ярьж байна. Би сая хэлсэн би Трансперенси интернэйшнлийнхэнтэй бид нар уулзсан. Үгүй ээ тэгээд авлигатай ингээд тэмцээд асуудлуудыг гаргаж байгаа нь буруу бол тэгээд л бүгдээрээ больчихъёл доо. Шилэн болгоод гаргалаа, санг ил болголоо гээд л ингээд л

бухимдаад л байгаа бол тэгээд л ярихаа больчихъё.

**Д.Амарбаясгалан:** Цогтгэрэл гишүүн тодруулга явъя.

**О.Цогтгэрэл:** Угүй ээ, би уг нь тодорхой л асуулт асуусан юм л даа. Бид нар тойроод олон юм ярьж болно. Ерөөсөө л энэ эдийн засаг дахь гол эмчилгээ чинь өөрөө төрийн оролцоогоо бид нар одоо энэ өргөн барих төсвөөсөө эхлээд тодорхой хувиар бууруулаад явах бодлого тодорхой ийм бодлого шийдлүүд саналууд байгаа юул гэж асуусан. Тэрнээс бид нар яриад байвал зөндөө л олон юм ярина. Яг тодорхой тоотой ийм үр дүнгүүдийг та төсөөлж харж байна уу? Энийг чинь дагаад аяндаа тэр авлига маань эрс буураад эхлэх байх аа. Энийг дагаад тэр ядуурал чинь өөрөө эрс буурчих байх аа. Энийг дагаад тэр төр жижигрээд иргэнд очих мөнгө ихэсчихээр энэний дунд тэр авлигат чинь буурчих байх аа. Бүх зүйлийн огтолцоон дээр байгаа ганц эмчилгээний эм тарцаа маань бэлээхэн бид нарын өмнө харагдаад байна л гэж би хувьдаа хардаг л байхгүй юу. Тэгээд таныг энэн дээр тодорхой тоо, байр суурь байна уу? Тодорхой тоо хэлж өгөөч л гэж л уг нь би хүссэн юм.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайдын микрофоныг өгье. Угүй ээ би ч тодорхой тоо л тодорхой жишигээтэй л яриад байна л даа. Нөгөө талдаа би зүгээр ях вэ үнэхээр ингэж хүсээд байгаа бол тэгээд өөрөө хийгээч. Одоо тэр боломж чинь байна шүү дээ. Тэгээд л Эдийн засгийнхаа гол яамдууд дээр та нар оролцоод л Тэгээд л хий л дээ. 4 жил л та нэг ийм л юм ярилаа шүү дээ. Нэг л их гомдоллосон хүн. Угүй ээ тэгээд барьж аваад л хий л дээ. Юу нь болохгүй байгаа юм? Тэгэх гэж л Үндсэн хууль хийгээ биз дээ. Тэгэхгүй тэгээд л одоо ингээд л нэг ийм бусдадаа ингээд л ингээд байна тэгээд байна гээд л. Тэгээд л өөрөө орохгүй зугтаагаад л тэгээд л ард нь нэг дарга болчих санаатай ингээд явваад байгаа юм. Тэгээд наадах чинь ингээд л

хугацаа чинь өнгөрнө шүү дээ. Угүй ээ худлаа биши шүү дээ. Тэгээд л ингээд явж байхын оронд тэр үнэхээр л эдийн засгийнхаа тийм асуудлыг хийх гэж байгаа бол тэрийгээ барьж аваад л тэгээд л либералчлаад л хий л дээ. Ярьж байсан зүйлдээ. Тийм боломж чинь ингээд ард түмэн өгчхөөд байна шүү дээ. Тэгээд яах гэж байгаа юм дахиад л нэг хэдэн хүмүүсийг хойноос нь муулаад л ийм байна, тэгээд байна, ингээд байна гээд л. Тэгээд л 4 жил явах гэж байгаа юм уу?

**Д.Амарбаясгалан:** Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асууна аа.

**О.Алтангэрэл:** Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд анх уг хэлж байна аа тэгээд итгэж сонгосон Хангайн бүсийн нийт сонгогчдодоо талархал илэрхийлээд Улсын Их Хурлын гишүүддээ ажлын амжилт хүсье. Бүгдээрээ өнгөрсөн удаагийн Улсын Их Хурлын сонгуулиар тойроод явцгаасан. Ард иргэдтэйгээ уулзсан. Хамгийн их тавьж байгаа асуудал бол ядуурал, унийн өсөлт. Үүнээс дутахгүй асуудал энэ. Шударга бус байдаг байна авлигат байна. Дарга нар яагаад ингээд төрийн өндөр албан тушаал хашсан байж ийм их хөрөнгөтэй байгаа юм бэ ард иргэдийн амьдрал яагаад сайжрахгүй байгаа юм бэ гэдэг асуудал ярьж байгаа. Тэр дунд Ерөнхий сайдын авлигатай хийж байгаа энэ тэмцэл үр дунд хүрэх ёстой гэсэн байр суурь илэрхийлсэн хүмүүс цөөнгүй байгаа.

Өнөөдөр бид нар авлигатай тэмцэх бодлогоо цогцоор нь харах цаг болчихсон. Өнөөдөр дагнасан байгууллага байгуулаад авлигатайгаа тэмцэнэ үүнийгээ арилгана гэж төөрөгддөг үе дэлхий нийтийн тренд биши болоод 20 гаран жил болж байна. Ганцхан байгууллага дээр авлигатай тэмцэх хамаг юмаа овоолчхоод авлигынхаа индексийн тоог хараад сугаад байж болохгүй ээ. Одоо бид нар цогцоор нь өөрчлөх ёстой. Өнөөдөр төрийн өндөр албан тушаал хашиж байсан Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Засгийн

газрын гишүүн, Улсын Дээд шүүхийн шүүгч төрийн өндөр албан тушаал хариж байсан хүмүүс шалтгаангүйгээр хөрөнгөтэй болсон хүмүүс байна аа. Хууль бус хөрөнгийг бүгдийг нь хураах ёстой. Энэ авлигатай хийх тэмцлийн гол үндэс нь байх ёстой.

Өнөөдөр хувь хүний талаар ярихаас арга байхгүй ээ. Нэг хэсэг дэлхий дээр ресционализм ярьж байсан нео ресционализм ярьж байгаа. Институц дотор хувь хүний гүйцэтгэдэг үүрэг авлигын гэмт явдал дотор хувь хүний гүйцэтгэдэг үүргийг заавал ярих ёстой. Тэгэхлээр би Ерөнхий сайдас нэг асуулт асуух гэж байгаа нь манай авлигатай тэмцэх бодлого стратеги ер нь хуучирчихжээ. Энэ маягаараа бол цаашаагаа үр дүн гаргана гэхэд бэрхтэй байна аа. Та энэ Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын төрөөс авлигатай тэмцэх стратегийг шинэчлэх чиглэлээр бодож төлөвлөж байгаа алхмууд бий юу? Энэ төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой хууль бус хөрөнгийг хураах, хуулийн хариуцлага хүлээлгэх талаар ямар нэг бодлого төлөвлөгөө байгаа юу гэж асууяа аа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Авлигатай Засгийн газар ер нь тэмцээд 1.5 жил л болж байна шуу дээ. 1.5 жил нь ковид байлаа. Харамсалтай нь ковидыг бүгд марчихаж л дээ. Би 3 жил л ажиллаж байгаа юм. Тэгэхээр сүүлийн энэ 1.5 жил дотор яах вэ шүүмжлээд л байгаа болохоос биши уг нь авлигатай тэмцэх гэж оролдсон л ухаантай юм. Тэр нь мэдээллүүдийг ил тод болгосон цахимжуулсан авлигын эсрэг ялын бодлогыг чангалсан. Ингээд стратегийг нь нэлээдгүй өөр түвшинд хийсэн бусад улс орнуудын турилагыг гаргаж стратегийг шинэчилсэн. Гэхдээ мэдээж энэ үр дүнд хүрэхгүй. Гэхдээ яах вэ энэ

тодорхой хэмжээний хугацаа хэрэгтэй зүйл шуу.

Яагаад гэхлээр энэ удаан хугацаанд ингээд явчихсан зүйл учраас.

Дээрээс нь би Цогтгэрэл даргатай нэг санал нэг байгаа зүйл үнэхээр энэ хөрстэй нь тэмцэх ёстой давхар. Гэхдээ нөгөө аль нэгэнтэй нь биши аль алинтай нь л тэмцэх ёстой. Би Алтангэрэл гишүүнд баярлаж байна. Ер нь бол бодитой хүмүүс. Яах вэ тэгээд л шүүмжлээд л ийм асуудал болох гээд байна гэж ингэж л яриад байгаа болохоос биши дэлхийн аль ч ардчилсан улсад хэрвээ авлигалийн мөнгөөр баяжсан тэр хууль бус орлого ийм л байдаг. Манайх болохоор тэгээд уул уурхайн том юугаар баяжсихаад л тэгээд л энэ минийх гээд л тэгээд л ингээд л яваад л тэгээд л тэрнээс нь мөнгө авчихсан хэдэн нөхдүүд нь учиргүй нэг их тийм мундаг нөхдүүд болоод л ингээд л яваад байдаг болохоос биши АНУ, Англи бүгдээрээ л тийм шуу дээ. Бид мэднэ нотлогдлоо л тэр хувийн өмч биши.

Тийм учраас та парламентад орж ирсэнд би талархаж байна. Энэ авлигатай хийх энэ тэмцэл дунд хүч нэмэх болов уу, дуу хоолой нэмэх болов уу? Бодитой үнэнийг Монголын парламентад гаргаж ирж тавих болов уу гэж бодож байна. Яах вэ дээ нээрээ л өнгөрсөн цаг хугацаанд ингээд Ерөнхий сайд ийм асуудлуудыг ингээд яриад байсан нь бодоод байхад буруу ч байж магадгүй ээ. Би сүүлийн уед тэгж бодож байгаа юм. Уг нь энэ парламентын гишүүдийн ажил шуу дээ. Ингээд л ийм асуудлуудыг ярих юм. Тэгэхээрээ бараг энэ буруу ч байсан байж магадгүй. Тэгээд тэрүүгээрээ одоо авлигатай яриад, хүн амьтан гомдоогоод, тэгээд тэр нь тийм ч болчихсон байж магадгүй ээ.

Би одоо яах вэ ингээд бодоход өөртөө дүгнэлт хийгээд л байгаа юм. Гэхдээ тэгээд хэн нэг нь ярихгүй л бол болохгүй л байсан юм л даа. Гэхдээ яг цагаа тулахлаар тийм хялбар биши шуу

наадах чинь. Яг орж ирээд наад олигархуудтайгаа тулаад өөдөөс нь үгүй ээ гээд хэлээд материал задлаад ингээд явах цагаа тулахлаар тийм хялбар ажил биши. Тэгээд би олон олон парламентын гишүүд орж ирж ингэхийг ч миний хувьд их хүссэн. Яагаад гэхлээр углуургаараа өөрчлөгдөөсэй. Парламент өөрчлөгдөж байгаа нь би бас хөрс нь өөрчлөгдөж байгаа гэж амьхандaa найдаад байгаа шүү дээ.

Тэгэхээр би Алтангэрэл өмгөөлөгч Монгол Улсын парламентад орж ирснээр энэ бүх асуудлууд дээр их том реформ эрх зүйн том реформ хийж чадах байх. Олон олон залуучууд орж ирлээ. Тус тусдаа хувь нэмрээ оруулбал авлигыг бид нар бүтэн ялж чадах байх аа гээж л дотроо их найдаж байгаа юм. Миний хувьд яах вэ дээ тэгээд ялж чаддаггүй байлаа гэхэд юутай ч энэ үзэл санааг.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье өө.

17 гишүүн нэрээ өгсөн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Хэдэн гишүүн байна? Жудгийн Баярмаа, Даваагийн Цогтбаатар. 4 гишүүний нэр ороогүй байна. Оруулья тийм ээ. Ингээд 21 гишүүнээр тасаллаа.

**Бат-Өлзийн** Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Одоо Сайнбуйнгийн Амарсайхан гишүүн үг хэлнэ ээ.

**С.Амарсайхан:** Ерөнхий сайддаа цаашдынх нь ажилд нь амжилт хүсье. Улсын Их Хурлаар ингээд албажиж томилогдоно гэдэгт эргэлзэхгүй байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бол Монголын ард түмэн бодлоо цэгцэлж төр төлөөллөө тэнцвэртэй илгээсэн гэж би хувьдаа би дүгнэж байгаа. Ардын намд ачааны хүндийг үүрч үйл хэргээ үргэлжлүүлжээхлүүлсэн ажлаа цаашаа дуусга гэж.

Бусад нь бол төрийн ажлын арга барилд суралц аа, төлөв төвшин бай, тэгээд умартасаныг нь сануул аа, унтаж орхисныг нь сэргээ гэдэг ийм зарчмаар цөөнх болгосон гэж дүгнэж байгаа. Гэсэн хэдий ч МАН-ын удирдлага дарга энэ улс орныхоо нийтлэг эрх ашиг, язгуур хувь заяаг бодолцож тусгаар тогтолц, бүрэн эрхт байдал цаашлах юм бол Үндсэн хуульт ёс, ардчилал, эрх зүйт төрөө бэхжүүлэхэд үйл хэргээ нэгтгэж, бодол санаагаа уялдуулж, эв ээз хангаж ажиллаа гэж бусад улс төрийн намууддаа тэр энэ гэхгүйгээр санал хүргүүлж байгаа.

Тэгээд энэ бол бас энэ парламент Улсын Их Хурлыг төгөлдөршигүүлэхэд жинхэнэ мэргэжлийн институц болох тэр хэрээрээ талцаж хуваагдаж явцуу байдлаар асуудалд ханддаг биши нэгдмэл зорилготой, нэгдсэн үйл хэрэгтэйгээр энэ улс орныхоо ажил амьдралыг урагшлуульяа гэж. Аль юм болгон уралцааж, хэрэлдэж, хэлцэх үү гэдэг ийм агуулгаар явж байгаа учраас манай энэ санал авч байгаа улс төрийн намууд дотооддоо асуудлаа цэгцэлж нь зөв байх аа. Хэн ч энийг шаардаж яахад хүчлээгүй. Хэрвээ зөвхөн намаа бодсон, эрх ашиг бодсон, явцуу үзсэн үзлээ бодсон бол хангалттай олонх байгаа. Аль алиндаа тушиг болоод энэ улс орныхоо ажил, амьдралыг сайжруулж, ард түүнээ нэг аятай тухтай амьдрооулж төрөө төвшин байлгаяа аа гэж ийм итгэл үнэмшил дүүрэн байгаа бол тийм сэтгэл зорилго дүүрэн байгаа бол нэгдэж болно гэж байгаа шүү дээ. Тийм биши бол дотроо учраа олохгүй, тэгээд зөвхөн албан тушаал эрх мэлдээр амин биеэ чимэх гоёх гэсэн ийм зорилготой. Тэр нь хаа хаанаа ойлгомжгүй байгаад байгаа бол төрийн ажил цаашаа үргэлжилж явах ёстой. Ардын нам хүнд цаг үед ч байсан энэ цаг үед ч байгаа. Ачааны хүндийг үүрч ч ирсэн, одоо ч үүрнэ, цаашаид ч үүрэхэд бэлэн гэж бодож байгаа.

Нөгөө талаараа сая Ерөнхий сайдын хэлдэг үнэн. Зориг агсны

хөшигийнөөс эхлээд энэ Сүхбаатарын талбайгаа хүртэл 10 сая доллароор худалдчихсан байсан шүү дээ. Би хотын дарга байхдаа 19 онд цуцалж сэргээж өнөөдөр хүртэл шүүхээр авна аа гээд. Авахын тулд элдэв янзын арга хэрэглээж байгаа юм. Тэгээд би ялангуяа энэ шинэ гишүүддээ хэлье гэж бодож байгаа юм. Энэ олон жил бугшиж ирсэн энэ худал хуурмагийн нөмрөг үүрсэн нөхдүүдийн нөмрөгийг нь хуу татах амаргүй шүү. Ерөнхий сайд ч сая хэллээ. Энэ буруу зөрөөг нь ул овоог нь Ардын нам бас унагаахын төлөө зүтгэжс ирсэн шүү. Заримыг нь бол худалдаж авдаг жижигхэн зүйлээр тэгээд амыг нь үддэг.

Худалдагдахгүй нэгийг нь бол энэ ертөнц дэлхий дээр байхгүйгээр гүтгээж доромжлоод тэгээд мохоож буцаагаад явуулах ийм сонирхолтой, олон ч хүнийг тэгж явуулжс ирсэн. Олон ч хүнийг тэгж золис болгож байсан. Улс төрийн өөрсдийн эрх ашигийнхаа энэ бол өнөөдөр хүртэл тасраагүй байгаа.

Тийм учраас шинэ гишүүд маань ялангуяа залуу гишүүд маань шийдэмгий зоригтой зорилгодоо хүрэхийн тулд өмнөө тулсан аливаа зүйл саад тогтор сайн муугийн саад тогторт ажирдаггүй саар мууд тордоггүй тэгээд төрийн төлөө зүтгэж байгаа бол зурх нь.

**Д.Амарбаясгалан:** Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

**С.Эрдэнэболд:** Юуны өмнө өнгөрсөн хугацаанд Засгийн газартай хамтарч ажиллаж байсан хүний хувьд хэлэхэд энэ нийгмийн баялгийг хүртээх энэ асуудал дээр тодорхой ахицууд гарсан. Би энийг бол тоогоор л хэлнэ. 4 жилийн хугацаанд цалин яаж нэмэгдэв, тэтгэвэр яаж нэмэгдэв? Өөр буруу гараар ордог байсан зүйлүүдийг магадгүй олон хүмүүс хүртсэн. Энийг бид нар хэлж чаддаг байх ёстой.

Хоёрдугаарт нийгмийн түншлэлийн асуудал гэдэг дээр их чухал

асуудлууд байгаа юм аа. Энэ ажилчдын төлөөлөл, бизнес эрхлэгчдийн төлөөлөл энэ институцийн зарчмаар явдаг. Энэ зүйл дээр нэлээн ахицууд гарсан. Энийгээ бас цаашдаа улам их эрчимжүүлж ажиллаарай гэдгийг зүйлийг захиж хэлмээр байна. З дугаарт хүний нөөцийн асуудал манайд их тулгамдааж байгаа. Хувийн хэвшлийн Төрийн байгууллагууд ч гэсэн хүн олдохoo байчихсан байсан шүү дээ. Сүүлийн авсан арга хэмжээнүүд эргээд сум, хөдөө орон нутагт ажиллаж байгаа хүмүүсийн цалин хөлсийг бас тодорхой хэмжээгээр нэмснээр буцаад тогтох ийм зүйл сайн зүйл ажиглагдаж байгаа.

Тийм учраас энэ зүйлүүд дээрээ анхаарал хандуулж хийгээрэй. Засаг томилогдож байгаа цаашаа яаж бүрддэг вэ? Төрийн мэргэшсэн, тогтвортой, сэтгэлтэй ийм хүмүүсийг тогтворт суурьшилтай ажиллуулах тэднийгээ дэмжих тал дээр та давхар анхаарч манлайлж ажиллаарай гэдгийг хэлмээр байна. Парламентыг энэ шинэ бараг 80 хувь нь шинээр бүрдсэн. Энийг бас бий болгоход улс төрийн манлайлал гаргаж энэ хуульд пропорционал тогтолцоо болон ийм зүйлийг хийсэн. Өнөө өглөөнөөс ингээд харж байхад яах вэ ерөнхийдөө туршилагатай гишүүдээ хундлэлгүй яах вэ. 2, 3 сонгогдсон. Гэхдээ цаашдаа энэ шинэ дуу хоолой орж байгаа. Анх удаа сонгогдож байгаа Байнгын хороодын бурэлдэхүүн томилоход хүртэл харагдаж байна лээ. Аль аль намууд нь хуучин туршилагатайнууд нь хамгийн сонирхолтой байдал юм уу, эс үгүй бол тэнд ашиг сонирхол байдал юм уу. Төсөв, Төрийн байнгын хороо руу л бүгдээрээ орчих шиг болдог юм байна. Яах вэ үр дүн гарах туршилагатай хүмүүсийн маань туршилага хэрэг болох байх. Гэхдээ бас энэ парламентынхаа 80 хувь нь шинэчлэгдсэн энэ дуу хоолойгоо ингэж өнгө алаглуулж шийдвэл цаашдаа зүгээр байх. Тэгээд Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдад олон хүмүүс маань өнгөрсөн хугацаанд залуу хүний хувьд би барьцаалагдаагүй гэж би харж байгаа.

Тийм учраас чанга дуугарч чадаж байна. Тийм учраас энэ авлигат хээл хахууль нийгмийн баялгийг хүртээх шинэ олон бүтээн байгуулалтын хөтөлбөрүүд явж байгаа. Нэг сүүдэр нь ард нь нийгмийн асуудлууд орхигдчих гээд байдаг төсөв өөрөө хязгаартай учраас. Тэгээд энийг тэнцүүлж ажиллахад та бас анхаарч ажиллаарай тэгээд цаашид амжилт хүсье. Улс төрийнхөө намуудад хэлэхэд бид нар улс төржих юман дээрээ улс төржөөд улс төржихгүй юмандаа хамтраад нийгмийн л ард түмний сонголт байсан учраас зарим зүйл дээр би олон санал бодлуудыг дэвшүүлнэ. Өөрийнхөө хардаг өнцгөөс гадна өрөөлийн хардаг өнцгүүдээс сайн харж хамтарч ажиллах байх аа гэж би найдаж байна шинэ засагт.

**Д.Амарбаясгалан:** Буланы Бейсен гишүүн үг хэлнэ ээ.

**Б.Бейсен:** Улиран сонгогдоож байгаа Ерөнхий сайддаа ажлын амжилт хүсье. эрүүл мэндийн салбарыас гарч ирсний хувьд бас энэ салбартай холбоотой тулгамдаж байгаа асуудлуудыг ярья гэж бодож байна. Ер нь эмнэлгийн салбарын ачаалал их байгаа. Эмч эмнэлгийн ажилчдын цалин бага, өнгөрсөн 4 жилид нэмэгдээгүй. Өргөн хэрэглээний бараа энэ бензин шатахуун нь дийлэхээ байлаа.

Тэгэхээр энийг цалингийн үндсэн сүлжээгээ 2 дахин нэмэх дээр нь ихэвчлэн санхууч дээр явбал эднийх ажиллах боломжтой. Яагаад гэвэл одоо зарим эмч нар, сувилагч нар гадагшаа гарад явчхаад байна. Хотод сувилагчийн дутагдалтай байна. Тийм учраас энэ дээр та нэг анхаарч ажиллаач ээ гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт тоног төхөөрөмжийн асуудал дээр аймаг болгонд оношилгооны төв байгуулахгүй бол хотын клиникийн эмнэлгүүдийн ачаалал маш их байгаа. Судалгаа хийгээд

үзсэн. Тэгэхэд хотын 1 дүгээр эмнэлэг энэ тэрээр үзүүлж байгаа улсуудын 43-аас 47 хувь нь хөдөөгийн иргэд байна. Орон нутагт зарим оношилгооны тоног төхөөрөмж дутагдалтайгаас болоод төвийг бараадаж байна. Тэгээд тоног төхөөрөмжөө тавиад эмчийн мэдлэг мэргэжлийг дээшилүүлэх тал дээр анхаарч ажиллана уу гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотой хавдар маш ихсэж байна, залуужисж байна. Гаднаас гений өөрчлөлттэй хүнс ч гэх юм уу даа яг энэ цэвэр хүнстэй холбоотой 10-аас 20 хувь нь эмтэй холбоотой л байх, 80 хувь нь хүнстэй холбоотой л байна. Энэ тал дээр эх орны хөрсөнд ургасан тэр Ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний аюулгүй байдлын программтай нь хамтарч ажиллаад дотоодын эх орны хөрсөнд ургасан хүнсний ногоогоор хангах тал дээр салбарын яамдуудаа анхаарал тавьж тэр төсөл хөтөлбөр дээр хяналт тавьж ажиллана уу гэдгээ хэлмээр байна аа.

Дараагийн асуудал энэ хөдөөгийн малчдын хөнгөлөлт эмийн асуудал байж байна. Аймгийн төв, Улаанбаатарт бөөгнөрсөн олон аптекууд байж байна. Гэтэл сум багийн түвшинд эрүүл мэндийн салбар өсөөд хөгжсөөд 100 жил болоход хөнгөлөлттэй эм авч чадахгүй байна. Энийг нэг реформ хийгээд сум багийн түвшинд эмийн сангийн асуудал ойртуулбал хөнгөлөлттэй эм авах бүрэн боломжтой байна аа.

Дараа нь энэ малчид сая хөдөө явж байхад хэлж байгаа нь тэтгэврийн 55 насанд тэтгэвэр авах малчид нөхцөл нь бүрдсэн малчид ерөөсөө байхгүй байна. Тэгэхээр урьд нь бид нэг нөхөн төлүүлсэн шүү дээ. Тэрэн шиг Засгийн газарт хургээсэй бид нарыг нэг тэтгэврийн шимтгэлээ нөхөн төлүүлэх нөхцөл бүрдүүлээч гэж байна. Энэ дээр анхаарч ажиллана уу гэж хэлмээр байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:**  
Хүшигдээмбэрэлийн Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Ер нь өнгөрсөн 4 жил олон жил тэр тэрний урд талын 4 жил ч гэж яриад яах вэ зүгээр өнгөрсөн 4 жилд бид нарт хамгийн их хүлээгдээж байсан гар барьж гүнзгий орж чадахгүй байгаа 2, 3 салбар байгаа. Тэр рүүгээ нэлээн сайн гүнзгий ороосой гэж хүсэж байна.

Нэгдүгээрт эрчим хүч. Үнэхээрийн энэ эрчим хүчиний чинь салбар чинь нэг талаасаа бид нарын тусгаар тогтолц аюулгүй байдалтай холбоотой. Нөгөө талаасаа энэ бизнесийг илүү таслалгүй явуулах гол дэд бүтэц байж байдаг. Францтай байгуулж байгаа гэрээ гээд л байсан, дүлэгнээд л байсан, одоогоор сонсогдохгүй байгаа гэх мэтчилэн эрчим хүчиний шинэ эх үүсвэр бий болгох, найдвартай хангамжтай болох, дотооддоо бүрэн хангах, дээр нь даварвал гадагшаагаа борлуулж мөнгө олдог байх чиглэлийн том төсөл дээр зориг гаргаарай гэж хүсэж байна.

Хоёрт нь яг энэнийг дагаад дэд бүтэц тэр дундаа тээвэр ложистиктой холбоотой нэг нарийнхаан нүхээр бүх юмаа оруулж гаргах гээд үйлээ үзэж байгаа. Энэ Монгол Улсын эдийн засгийг жуукох тэлье задалъя гэх юм бол энэ дэд бүтэц ложистикийнхoo бүтэц дээр нэг зоригтой алхам хийгээрэй. Яагаад Чойр хүртэл нарийн цариг оруулж ирээд тэнд шингэн бараа бүтээгдэхүүн буулгах ложистикийн бүтэц байгуулаад агаарын ХАБ үүсгэж болохгүй гэж. Монгол Улс одоо бол яах аргагүй энэ худалдаа, арилжсаа, үйлдвэрлэл гээд олон юмыг хөгжихэд яг энэ чиглэлийн зоригтой алхам хэрэгтэй байна шүү. Алийн болгон араа харж алийн болгон ар талаасаа айж явах вэ дээ. Одоо нэг зоригтой шийдэл гаргасан нь дээр байх шүү 3-т нь хөрөнгө оруулалт. Яг энэ парламент өмнөх парламент хугацаагаа дуусгахын өмнөх гаднын хөрөнгө оруулалт болон дотоодын

хөрөнгө оруулалт дээрээ бараг салаавч узүүлсэн шүү. Нэг хүний хувь заяа эмгэнэлтэй байх. 2 удаа ийм түүх гарлаа.

2008-2012 оны парламент дуусахдаа бас хөрөнгө оруулалтыг ингэж тэг цэг дээр нь авчраад хөөгөөд дуусгаж байсан юм. Сая яг тийм үйлдэл гарлаа. Одоо Засгийн газар нь жуукох зоригтой. Энэ хөрөнгө оруулалт дээрээ дэмжих бодлогоо нэг яваад үзээрэй. Энэ ложистикууд болон эрчим хүч хөрөнгө оруулалтаа хийхгүй бол үнэхээр бизнесийн эрх чөлөөт байхгүй болчихсон. Ул уурхай жуукох явж байгаа байж магадгүй. Ул уурхай бизнес чинь үнэтэй мөнгө төрийн дарамт дээр нь томорсон бизнес нь дээрээс нь орж ирээд тонож байгаа энэ тонуул дотор чинь жижиг дунд бизнес чинь бараг байхгүй болчихсон юм шүү.

Тийм учраас татвараа одоо яах юм. Нэг эргээд бодсон нь дээр байх аа зоригтой. Энэ төрийн дарамт айdas хүйдсээ нэг зоригтой бодсон нь дээр байх.

Гуравт нь. Ер нь бол уул уурхайгаас бусад бизнес дээрээ ер нь одоо нэг цонх нээвэл яасан юм бэ. Татварыг нь багасгаад, хяналт шалгалтыг нь багасгаад үйл ажиллагаа явуулахад нь төр садаа болохгүй. Нэг зөнд нь орхиж үзээд хамгийн их ажлын байр нэмэгдүүлдэг жирийн иргэдийн халаас руу мөнгө хуваарилдаг энэ нэг бизнесийнхээ орон зай дээр Засгийн газар ядаж нэг 3 жил нүдээ аниад явбал яасан юм бэ.

Дөрөвт нь үнэхээр залуучуудын чинь мөрөөдөл эрх чөлөө 2-т нь үнэхээр айdas доромжсол 2 зэрэг ороод ирсэн учраас олон залуучууд гадагшаа тархи нь гоожиж явсан шүү. Энэ нэг цагдаажсан төр шиг арга барилтай болчихсон дунд доод түвшиний дээрээс нь өөгшүүлээд байгаа эсэх нь мэдэгдэхгүй дүлий байгаа байдлаа засахгүй бол энэ улс оронд чинь угээ хэлснийхээ төлөө шоронд явдаг, бизнес эрхлэгчдийнхээ төлөө амьдралаараа хохирдог ийм нэг дүр зураг бий болчихлоо шүү. Тэгэхээр энэ

бизнесийн эрх чөлөө энэ нэг төрийн дарангуйлал 2-ын завсарт байж байгаа хавчигдсан энэ хэсгийгээ бид нар нэг зргээд нэг хараарай. Төгсгөлд нь түрүүн би асуултая авлигаар хэлсэн.

Үнэхээр авлигатай тэмцэх үйл явц хэцүү тогтолцооных нь хувьд сууриар нь хөрсийг нь шийдэхээс өөр арга байхгүй. Гэхдээ тодорхой манлайлал үзүүлэхийн тулд тодорхой хувь хүмүүс дээр хариуцлага тооцоогоос өөр арга байхгүй. Гэхдээ үеэ өнгөрөөчихсөн бараг домоголж байгаа хэдий рүү шүлс үсөргэж хаяхаас илүүтэйгээр хажуу хавирган дээрээ байгаа авлигачдаа бид нар бодож ёстой шүү.

**Д.Амарбаясгалан:** Лувсанбямбын Мөнхбаясгалан гишүүн.

**Л.Оюун-Эрдэнэ:** Ерөнхий сайдад амжилт хүсье. Говийн бүсээс сонгогдсон гишүүний хувьд танай намын мөрийн хөтөлбөрт байгаа б дугаар зүйлийн 6.3, үнэт баялаг бус 7 дугаар зүйлийн 4 дүгээр хэсэгт говийн бүсийн хөгжил гэсэн энэ мөрийн хөтөлбөрийн амлалтуудыг чинь онцгойлон сануулмаар байна. Танай намын мөрийн хөтөлбөрт Ардын намын мөрийн хөтөлбөрт Хэрлэн тоонот, Орхон, Онги, АН-ын мөрийн хөтөлбөрт Туул.gov, Хэрлэн.gov, Орхон.gov гэсэн адилхан усны төсөл орсон. Говийн бүсэд экологийн тэнцвэр алдагдсан. Ус татах шаардлагатай. Уул уурхайдаа гүний ус хэрэглэдэг орон ер нь манайхаас өөр байхгүй байх гэж бодож байна. Тэгэхээр энэ тал дээр Монгол Улсын Ерөнхий сайд та анхааран ажиллаж хэрвээ хамтарсан Засгийн газар байгуулагдах гэж байгаа бол энэ асуудал дээр 2 талаасаа хамтарч төсөл хөтөлбөрүүдээ нэгтгэх тал дээр анхааран ажиллаж өгөөч гэж хүсье.

Хоёрдугаарт, та бол сэтгүүлч мэргэжилтэй Ерөнхий сайд. Монголын түүхэнд сэтгүүлч мэргэжилтэй 2 Ерөнхий сайд 2, 2 удаа ажиллаж байгаагийн нэг нь та болж байна. Тэгэхээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө

алдагдаж байгаа. Заримдаа хэвлэл мэдээлэл хэрээс хэтэрч даварч байгаа энэ тал дээр хамтарч ажиллахад бэлэн шүү. Энэ парламентад тавхан сэтгүүлч мэргэжилтэй гишүүд сонгогдсон байна. Энэ тал дээр хамтарч ажиллахад бэлэн байгаагаа хэлье.

Гуравдугаарт, миний сонгогдсон Дорноговь, Говьсүмбэр аймгуудад төрийн албан хаагчдын эрх зүйн байдал дордож байна. Үг хэлэх узэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгүй дарангуйлалт байна. Энийг манай Дэлгэрсайхан гишүүн сайн мэдэж байгаа. Хамтарч ажиллана. Хамтарч энэ дээр гэрэл гэгээ оруулна. Энэ тал дээр та бас анхааралдаа авна биз ээ гэж бодож байна.

Хэвлэл мэдээллийн юугаар хүний нөөцийн яам байгуулах гэж байгаа юм шиг байна. Монгол Улс тэр чигээрээ хүний нөөцийн доройтолд орсон дутагдалд орсон. Хэрвээ ийм яам байгуулах гэж байгаа байгуулаарай. Энэ их зөв бодлого байна шүү гэж хэлье. Таны авлигатай тэмцэж байгаа тэмцэлд талархдаг зарим зүйлд нь шүүмжлэлтэй хандсаар ирсэн. Хамтарсан Засгийн газар байгуулах гэж байгаа бол Монгол Улс олон намын тогтолцоотой. Олон нам нь дотроо олон фракцын тогтолцоотой. Олон фракцууд нь дотроо олон олон эрх ашигтай. Та сонголтоо хийхдээ Засгийн газраа бүрдүүлэхдээ намаа биши улсаа бодоорой. Фракцуудын эв нэгдлийг битгий бодоорой. Улсаа бодоорой. Найз нөхдөө битгий бодоорой, улсаа бодоорой. Ингэж ажиллаж чадвал та бол авлигатай тэмцэж чадна. Энэ цочроо чинь гарчихсан Ерөнхий сайд гэдэгт итгэлтэй байна.

Тэгээд бас нэг зүйл анхааруулахад өнөөдөр тусгай хэрэгцээт иргэдийн төлөөлөл энэ парламентад сонгогдсон. Индэргүй ганц гишүүн тангараг өргөлөө. Үнэмлэхээ авч чадсангүй, өрөөгүй байна. Засгийн газрын бутцэд юм уу хаана байдаг юм. Бусад тусгай тусгай хэрэгцээт иргэдийн төлөөллийг оруулж

өгөхийг бодоорой. Улсын Их Хурлын дарга сонсож байгаа бол анхаарна биз. Ингээд танд амжилт хүсье. Авлигатай тэмцэх ажилд чинь хамтарч, хавсарч ажиллахад дуртай байна. Тэгээд хамт хэрвээ хулгай хийхээр тийм Засгийн газар бүрдэх юм бол дуугүй сууж чадахгүй гэдгээ үүгээр илрхийлье. Баярлалаа. Амжилт хүсье.

**Д.Амарбаясгалан:** Норовын Алтанхуяг гишүүн.

**Н.Алтанхуяг:** Оюун-Эрдэнэ сайд чинь бараг 3 жил шахуу Ерөнхий сайд хийчихсэн ковидын хүнд хэцүү үе тэгээд дараа үе гээд үе байгаа. Тэгээд намаа удирдаад сонгуульд орчихлоо. Би энэ саяын сонгуультай холбоотой нэг 2, 3 юм хэлэхгүй бол болохгүй нь 4 жилд нэг болдог сонгууль. Уг нь бид нар чинь 1990 оноос арчилсан сонгууль монгуультай гэж бодож явсан юм. Би саяын сонгуульд ороод мөнгөний сонгууль хэтэрхий мөнгөний сонгууль болсон байна аа Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд аа та энэ дээр Ерөнхий сайдын хувьд биш намын даргын хувьд хэлж байна. Таны хийх гэж байгаа сонгуулийн тогтолцооны шинэчлэл энэ тэр чинь бол мөнгөн дээр очоод л нурж унааж байна. Бүгдээрээ мэдэж байгаа. Та нар мөнгө ямар үүрэг рольтой явсныг. 2 дахь миний санаа зовоож байгаа зүгээр олон намын систем маань нэг том нам данхар нам, бусад нь дагуул намын систем рүү шилжсиж явна шүү. Энэ Гантөмөр хаашаа гараад алга болчхов? Энэ намын даргад би хэлж байгаа. Ингээд 90 оны гоё юмнуудыг ингэж муухай юм болгож хувиргаж болохгүй ээ.

Харин энэ удаагийн парламент бол бас та бүхний зүтгүүлсэн энэ холимог тогтолцоо маягийн юмаар бол би тодорхой хэмжээгээр дээрдсэн гэж узэж байгаа. Олонх цөөнх их ойролцоо болсон. Тийм учраас өглөө би энэ Амарбаясгалан даргад хэлсэн. Энэ Улсын Их Хурал дотор байгаа цөөнхийг жсаахан хяналтынх нь функцийг нь дэмжээд өгөөч ээ. Та нарт тэртээ тэргүй зөндөө даргалах юм байгаа. Тэгэхдээ энд би манайхныг дарга л

гэж байгаа юм биш. Хяналтын үүргээ сайн гүйцэтгэмээр байна АН. Хуучин нэг хяналтын түр хороо байгуульяа гэхлээр л 13 гишүүнтэй б хүн дутаад та хэд гүйгаад гарын үсэг өгдөггүй ингээд л нурдаг байсан.

Одоо 32 хүнээр энэ хяналтын түр хороог байгуулж болж байгаа. 42 хүнтэй шүү дээ манайх. Гэх мэтчилэн асар их боломжууд байгаа. Энэнийг сайн ажиллуулаад өгөх юм бол таны толгойлох гэж байгаа Засгийн газар чинь ажил хийхэд маш их сайн болно. Бид нар бол болохгүй байгаа юмнуудыг чинь гаргаж өгч чадах байхгүй юу цөөнх.

Тийм учраас энэ дээр та дэмжисж ажиллаач ээ. Төсвийн дэд хороогоо хурдхан өгчих, Хүний эрхийн хороогоо өгчих. Хяналтын түр хороонуудыгаа энэ цөөнхөд өгчих. Бас өнгөрсөн хугацаанд таны хийсэн ажлаас би тэр баялагтаа эзэн больё гээд жсаахан юм хийх гэж чардайсан. Ерөнхий сайдын ажил бол хэцүү. Би ойлгож байна аа. Та харин овоо ийм 3 жил гаруй явчхаад дахиад сунгах гээд сууж байна. Би наана чинь 2 жил болов уу, үгүй юу хүний өөрийнгүй нийлж байгаад боорлож байгаад огцруулаад хаячхаж байсан юм.

Тийм учраас би зовлонг чинь хуваалцаж байгаа баялагтаа эзэн болохын тулд юм хийх гэж оролдож байгаа. Шударга бусын хонгилтой тэмцэх гэж оролдож байгаа. Авлигыг бууруульяа гээд амыг чинь асуугаад баалахаас өөр аргагүй юм. Авлигатай тэмцээд байхад яагаад авлига чинь ихсээд байдаг юм бэ гэдэг чинь парадоксалны ийм нөхцөл байгаа. Тэгэхээр энэ дээр бас жсаахан тэр механизм гээд манайхан ярьсан шүү. Зүгээр л нэг Авлигатай тэмцэх газар байгуулчхаад тэрний даргыг тавьчихаар авлигатай тэмцихдэг юм биш. Хулгайлаад байгаа, идээд байгаа, уугаад байгаа, дээрэмдээд байгаа тэр бүх юмныхаа үр үндсийг нь таслах тэр ажлыг хийгээч ээ. Би бас дэмжисж ажиллахад бэлэн байна.

Төгсгөлд нь нэг 3 жижигхэн юм захичихъя. Улсын Их Хурал дээр орж ирж мэдээлэл хийж бай л дээ. Би чинь 14 хоногт нэг удаа орж ирж мэдээлэл хийдэг байсан. Одоо өнгөрсөн 4 жил та харагдаагүй шүү. Энэ чинь их буруу коммуникаци болохгүй байгаа юм Их хурлын гишүүдтэйгээ. Олон нийттэй давхар 2 дахь нь энэ санхүү эдийн засгийн бодлогоо нэг жсаахан гайгүй шиг амьтанд өгчих л дөө. Танайд ер нь энэ чиглэлээр олигтой амьтан байхгүй болчихсон уу ясан юм? Хүрэлбаатар, Жавхлан гээд 2 юм бүтэн дамжууруулсан шүү. Энэ бол тан дээр хамгийн том хар толбо болж очоод байгаа шүү дээ. Эдийн засаг нь өсөөд байдаг ард түмэн ядуураад байдаг гэдэг чинь ийм бодлого чинь.

**Д.Амарбаясгалан:** Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн.

**М.Нарантуяа-Нара:** Ерөнхий сайддаа болон нийт гишүүддээ ажлын амжилт хүсье. Тэгэхээр юуны өмнө Үндсэн хуулийн шинэчлэлийн хүрээнд энэ сонгуулийн шинэчлэгдсэн тогтолцооны үр дунд олон намын төлөөлөл энэ парламентад орж ирж чадлаа. Энэ хүрээнд миний бие ч гэсэн 3 дахь удаагаа сонгуульд нэр дэвшиж байж Иргэний Зориг ногоон намаасаа энэ удаад парламентад орж ирж жагсаалтаар орж ирж чадлаа. Уг нь би түрүүн Ерөнхий сайдаас асуух асуултад микрофон дарсан ч хоцорчихлоо. Тийм учраас надад нэг зарим нэг зүйлүүд тодруулмаар байгаа ч гэсэн зүгээр тодруулах боломжгүй юм чинь ярчихъя.

Тэгээд Ерөнхий сайд дахин улирч сонгогдсоноор, томилогдсоноор Засгийн газрын мөрийн хөтөлбөр яах вэ? Шинэчлэгдэж явагдах уу эсвэл үргэлжлүүлэн явагдах уу? Хэрвээ үргэлжлүүлэн явагдах бол одоо ингээд наадмын дараа намар гэдэг. Монголчууд бид нар наадам морь мал ингээд явж байтал намрын чуулган эхлэх үеэр бид нар дахиад нөгөө сайжруулсан түлиээ

Улаанбаатар хот даяараа түлэх тэр цаг үе тулчихнаа аа. Тэгэхээр иргэдийн маш том айдастай нэг асуудал байгаа нь энэ Улаанбаатар хотын гэр хорооллын бусийн иргэдийн энэ сайжруулсан түлиний асуудал байгаа. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд 3600 орчим иргэд энэ сайжруулсан түлиний хэрэглээний улмаас тийм ээ энэний чанар стандарт уу, үр дүн үү юу вэ мэдэгдэхгүй ингээд иргэд амь насаа алдсан ийм бид нарт эмгэнэлтэй дүн тоо байна.

Тэгэхээр зэрэг энийг цаашид манай Ерөнхий сайд маш сайн анхааралдаа аваасай. Одоо иргэдийн дунд бол нэгэнт иргэдийн төлөөлөл болж гарсан юм чинь энэ талаар асуудлыг сайн хөндөж өгөөч ээ. Хэрвээ ингэж ийм их хүн энэ 4 жилийн хугацаанд амь нас эрүүл мэндээрээ хохирч байгаа бол дараагийн хохирогч хэн болох нь мэдэгдэхгүй байгаа энэ үед бид нар хэрэглэж дассан түүхий нүүрсээ эргээд түлье ээ гэдэг ийм саналууд маш их иргэдийн дунд байгаа.

Тийм учраас та шинэчлэгдэн байгуулагдах Засгийн газрынхаа хүрээнд энэ асуудал дээр маш сайн тийм ээ бараг ийм иргэддээ баталгаа гаргаж өгөх хэмжээний ийм ажлыг хийгээсэй гэж хүсэж байна аа. Мөн түүнчлэн нийт гишүүдээсээ бас энэ гэр булийн хуулийн батлах асуудлыг бүгдээрээ маш сайн дэмжисж хамтарч ажиллаасай гэж бодож байна аа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Дашидондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Түүхийн хуудас сэргэж байна аа 76 гишүүнтэй парламент бид нарын ард үлдээж. 126 гишүүнтэй парламент өнөөдөр ажлаа яриад сууж байна аа. Ингээд ажлын 2 дахь, 3 дахь өдөр байна уу. Ерөнхий сайдын нэг л буруу байна гээд та сүүл рүүгээ нэг хэлчих шиг боллоо. Тантай би санал нэг байна. Энэ жсоохон нэг юм буруу байна. Тийм ер нь энэ ирж байгаа 4 жилийг мэдээж хэрэг ард түмэн итгэл найдвартай байна харж

байх шиг байна. Энэ сонгууль маань ингээд ямар ч байсан явчихсан. Ингээд сонгуулийн үр дүн гарчихлаа. Тэгээд иргэд ингээд харж байна. Бид нар ингээд тайван замаар сонгуулийг хийгээд засаг төрөө өөрчлөөд ингэж явж чадаж байна аа. Энэ маш сайн. Та ч гэсэн манай АН-д албан бичиг явуулсан байна лээ. Бид нар танилцсан мэдээж хэрэг тэгээд ярилцах байгаад нэг тийшээ болоод яриад явах байх.

Тэгэхээр энийг би сайн гэж бодож байна. Яагаад гэвэл гадна дотнын нөхцөл ямар байгаа билээ, дотоод нөхцөл ямар байгаа билээ. Та хэд маань 8 жил ингээд л хэт олонхоороо ажилалаа. Мэдээж хэрэг үр дүнгүүд байгаа. Жишээлбэл Оюутолгой сүүлийн 3 жилд 4 мяняган доллароос хөдөлдөггүй байсан нэг хүнд ноогдох 5 мяняган доллароос орчихлоо гэх мэтчилний зүйлүүд байгаа. Энэ сонгуулийн систем ард түмний санал гээгдэхгүй байх энэ тал дээр болж байна. Энэ бүсчилсэн хөгжлийг хөтлөх гээд чаддаггүй байсан. Ингээд сонголтыг сонгуулийг энэнтэй уялдуулаад хийчихсэн болохоор энэ цаашаа явах байх аа гэж харж байна.

Нөгөө талаар мэдээж хэрэг танай намын барьдаг баримтлалдаг тэр бодлого үзэл бодол байгаа. Тэр чинь одоо эдийн засаг энэ хүмүүсийн амьдрал дээр ингээд гарч байгаа байх л даа. Хэрэв засагт чинь энэ олон намын систем чинь орж ирээд тэрийг хоорондоо ярилцдаг, бодлого шийдвэр нь зөв гардаг өөрчлөгдөж байвал хүлээлт байгаа байх. Мэдээж хэрэг тэр ч үр дүн гарна гэж бодож байна.

Энэ 4 жил одоо энэ 5 мяняган доллар 1 хүнд ноогдох нь чамлахаар тоо л доо. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл боломжийг ингээд үзэхээр 2 хөрийн маань хэчинээн хүнтэй билээ. Тэгтэл бүгдээрээ нэг 12 мяняган доллароос дээши байгаа байхгүй юу. Нэг хүнд ноогдох нь энэ дээрээ бид нар анхаарч ажиллая гэж бодож байна. Тэгээд 7 хувийн өсөлттэй эдийн засаг өнгөрсөн онд байсан. Энэ онд

хулээгдэж байгаа нь 4.8-аас нэг б хувьтай байгаа юм уу даа гэж ойлгоод байгаа юм. Урьдчилсан юугаар цаашдаа бол энэ 4 жилд мэдээж хэрэг 8 мяняган төгрөг өгөх. Хамгийн наад зах нь гэхэд өнөөдөр л гэхэд Тяньжинь дээр өчинөөн олон контейнер бөөгнөрчихсөн хүмүүсийн ирж байгаа зардал юм хум нь өндөрсчихсөн ийм л байдалтай байгаа л даа. Энэ мэтчилний зүйлүүд дээрээ бид нар анхаарч ажилламаар байна аа.

Тэгэхгүй бол одоо ерөөсөө л нөгөө л хурдан түргэн ажиллаад л энэ юм нь ирж л байвал хүмүүсийн өртөг зардал нь хямдарсан, амьдрахад арай арай дээр л байх. Энэ зохион байгуулалтын л асуудал гэж ойлгож байна. Энэ дээрээ ажиллах хэрэгтэй. Тэр Түгжрэлийн сайд Улаанбаатар хот маань ямар байгаа билээ хүн амын хэдэн хувь нь энд амьдарч байгаа билээ. 2 хүний нэг нь амьдарч байна. сүүлийн арваад жил бол ерөөсөө 3 хүний нэг нь ядуу гэдэг юм өөрчлөгдөхгүй л яваад байна шүү дээ. Энэ зүйлүүд дээрээ өөрчлөлт хийхийн тулд нэг их 5 мяняган доллартой 1 хүнд ноогдох 2 хүний нэг нь ядуу шахуу 3 хүний нэг нь ядуу байхад нэг их бид нар нэг улс төржилтөөсөө холдмоор байна.

**Д.Амарбаясгалан:** Жуковын Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Баярлалаа. Юуны өмнө надад итгэл хулээлгээж сонгосон Хан-Ул дүүргийнхээ иргэдэд гүн талархал илэрхийлье ээ. Өнгөрсөн 30 жил маань өнгөрлөө. Одоо бид нар шинэ 30 жилийг эхлүүлж байгаа гэж бүгдээрээ ярьж байгаа. Бидний мөрийн хөтөлбөрт олон шинэ санаачилга орсон. Түүний дотор Улаанбаатар хотод засаглалын болоод бодлогын том шинэчлэл хийе гэсэн ийм том зорилт орсон байгаа. Олон ойлгомжгүй байдлыг цэгцэлье энэ хороо дүүргийн эрх мэдлийг анхан шатанд нь шилжүүлье гэсэн том шинэчлэлийн санаачилгууд орсон. Тэгээд энэ олон намууд орж ирсэн энэ парламентын одоогийн байдлыг харж байхад энэ

шинэчлэлүүд маань бэрхшээлтэй тулгарах вий гэдэг надад айдас төрж байгаа юм аа.

Тийм учраас улс төрийн намууд маань тал талдаа байгаа зөв санаачилгуудаа зөв бодлогуудаа ширээн дээр гаргаж тавиад аль зөвийг нь хэрэгжүүлээд явбал ясан юм бэ гэдгээ бол улс төрийн намууддаа уриалмаар байгаа юм аа.

Хоёрт нь нийслэл Улаанбаатар хотыг дэмжих тийм Байнгын хороотой болмоор байгаа юм. Улаанбаатар хот маань дандаа л энэний хавчуурганд явж байдал. Энэ дээр Байнгын хороотой бол ясан юм бэ гэсэн ийм бодолтой байна.

Гуравдугаарт сөрөг хүчинийхэн гэх юм уу цөөнх маань юу ч байсан эсэргүүцнэ гэдэг зарчим барих юм бол явж явж Монгол Улс хохирно. Тийм учраас та бүгд маань бидний зөв бодлогыг өөрсдийнхөө зөв санаачилгатай хамтруулаад хэрэгжүүлээд явбал ясан юм бэ гэдэг надад ийм санал байгаа юм аа. Тэгээд Монгол Улсын Ерөнхий сайд маань энэ улс төрийн намуудыг зөвшүүлцөх том ажлыг манлайлаад явах явж таарах юм байна гэж ойлголоо. Тэгээд Ерөнхий сайдын эхэлсэн ажлаа амжилттай дуусгаарай гэж хүсэж байна. Амжилт хүсье ээ. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Цэндийн Баатархүү гишүүн.

**Ц.Баатархүү:** Сайн байцгаанаа уу? Шинээр бүрдэж байгаа 126 гишүүнтэй парламентад өндөр амжилт хүсэн ерөөө өө. Шинэ байгуулагдаж байгаа Засгийн газрын уйл ажиллагаанд амжилт хүсэж байна. Тэгээд шинэ 30 жил гэж нэрлэж байгаа хэдий боловч өнгөрсөн жилүүдэд гарсан өнгөрсөн 30 жилийн алдаа болсон энэ нүүрсний, зэсийн, боловсролын зээлийн сангийн, ЖДҮ-ийн, ногоон автобусны хулгайг марталгүй орхилгүй бид хөөн хэлэлцэж хариуцлага тооцох ёстой ер нь асуудал хаана байна вэ гэхээр төрийн

институцад байгаа. Асуудал хаана вэ гэхээр Улсын Их Хурал бидэнд байна аа. Бид асуудлыг дандаа ирээдүй цаг дээр ярьж байна. Бид өнгөрсөнөө дүгнэхгүй бол ирээдүйд зөв шийдвэр гаргах боломжгүй.

Өнөөдөр Улаанбаатар хотын 2020 оны өрөнхий төлөвлөгөөний биелэлт 29 хувьтай гарсан байна. Хаана энэ алдаа гарч байгаа юм бэ гэдгээ бид нар олж илрүүлэх хэрэгтэй. Өвчнийхөө учир шалтгааныг олж харахгүйгээр эмчилгээ хийгээд байх юм бол төсвийн мөнгийг хий дэмий үрсэн асуудалолж байгаа юм. Төлөвлөлтөд нь алдаа байна уу? Төлөвлөлтийг хэрэгжүүлж байгаа хүний нөөцөд алдаа байна уу? Процесс алдаа байна уу гэдэг энэ төрийн шийдвэр гаргах уйл явц түүнийг хэрэгжүүлж байгаа төрийн албаны уйл ажиллагаанд бид нар нэг нэгдсэн дүгнэлт хийх цаг болсон.

Энэ Төрийн албаны зөвлөл тэгээд гүйцэтгэх удирдлага бол энд анхаарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна. Ингэж байж бид нарын төсөв хамгийн ур ашигтай зөв зүйлд зарцуулагдана гэж бодож байгаа.

Хоёрдугаарт, Монгол Улс энэ хотуудын хөгжлийг ярих хэрэгтэй. Зөвхөн Улаанбаатар хотоос гадна Монгол Улс олон хоттой байх хэрэгтэй. Хотууд бол эдийн засаг ажлын байраа дагаж хөгжинө. Энэ нэг зүйлийг энд Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүд анхаарч ойлгож байгаа байх. Хотод бүтээн байгуулалтын ажил хийх гэхээр газар чөлөөлөлтийн ажил дээрээ 5 жил, 10 жил гацааг юм аа. Тэгэхээр дэлхийн хот юу руу чиглэсэн бэ гэхээр газрыг нь булааж авдаг биш газрынх нь нөхөн төлбөрийг нэмээд тэнд үйл ажиллагаа явуулж байгаа бизнесээс хотынхоо иргэдэд хувь эзэмшиүүлдэг болсон. Ингэх юм бол бүтээн байгуулалтын ажил бүрэн дүүрэн хурдан шуурхай хэрэгжисж байна. Жишээ нь Сэлбийг тойрсон 2300 айл байна. Нүүх гэж 8 жил болсон.

Сэлбэ төвийг тойрсон бизнесийн оролцоог нь дэмжих юм бол тэр бүтээн байгуулалтын ажлууд маш хурдтай явах боломж байна гэж бодож байгаа. Тэгэхээр энэ удаагийн Улсын Их Хуралд сонгогдсон миний бие бол энэ иргэдийнхээ хувийн өмчийг хамгаалах, дээрэмдэх биш хамгаалах, хуулиар нь хамгаалах, нэмээд иргэдийнхээ энэ орлогын үүд хаалгыг нээх энэ хуулиудыг гаргаж ажиллана гэж бодож байна. Ерөнхий сайд энэн дээр анхаарч ажиллах байх гэж бодож байна.

**Гуравдугаарт хөрөнгийн менежментийг цоо шинээр хиймээр байна.** Улаанбаатар хотын хөрөнгийг үнэлээд үзэх юм бол 2016 оны дунгээр шүү. 1.5 их наяд байна. Энэ 1.5 их наядын өмч бол хэн нэгэн дарга нар биш нийт Улаанбаатарчууд эзэмших боломж байна аа. Дэлхийн хотууд энэ чиглэл руүгээ явж байна аа. Тодорхой хэсгийг нь хотын иргэд нь хотынхoo өмчид хувь эзэмшидэг болох юм бол тэр хот илүү амжилттай хөгжих энэ боломж бололцоо руугаа явж байгаа учраас хотыг шинээр зохион байгуулах ийм боломж байна гэж бодож байна.

**Гуравт нь бол өнгөрсөн парламент бол нэг зүйлийг эхлүүлсэн.** Гэхдээ дутуу эхлүүлсэн гэж бодож байна. Энэ бол банк санхүүгийн салбарын шинэчлэл. Өнөөдөр хувийн хэвшил, жижиг дундынхан, өрхийн аж ахуйнхан хэний өмнө бөгтийж байна вэ гэхээр банкны өмнө бөгтийж байна. Банк бол маш өндөр хүйтэй зээл өгдөг. Банк төрөлждөггүй. Тэгээд нээлттэй компани болно гэхээр лоббидож байгаад хорьхон хувийн хувьцаатай болгосон. Энэ дутуу шинэчлэл. Өнөөдөр банк санхүүгийн шинэчлэлийг нээлттэй болгоод Монголынхоо хөрөнгийн биржээр.

**Д.Амарбаясгалан:** Дашиэрэнгийн Энхтувшин гишүүн.

**Д.Энхтувшин:** Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Юуны өмнө Монголын ДНБ-ий 76 хувийг бүрдүүлж байгаа хувийн хэвшлийн төлөөллийг

парламентад оролцож дуу хоолойгоо илэрхийлэх бололцоо олгосон Ерөнхий сайдад талархсанаа илэрхийлье. Тэгээд Ерөнхий сайдын хувьд Монголын Үндсэн хуульд энэ түүхэнд хамгийн удаан ажиллах ийм бололцоотой Ерөнхий сайд болж байгаа гэж бодож байна. Тэгээд таны цаашдын ажилд амжилт хүсье ээ. Тэгээд МАН-ын мөрийн хөтөлбөрөөс би нэг 4 зүйлийг онцолж хэлэхийг хүсэж байна.

Энэ нь болохоор эдийн засаг нэгдүгээрт нь эдийн засгийн өсөлтийг 7-гоос 8 хувийн түвшинд хадгална гэсэн узүүлэлт байгаа.

**Хоёрдугаарт нь төсвийн зарлагыг ДНБ-ий 25 хувиас хэтрүүлэхгүй мөн гадаад зээлийг 40 хувиас хэтрүүлэхгүй инфляцыг нэг оронтой тоонд байлгана гэсэн ийм 4 зүйл байгаа юм. Тэгээд эндээс харахаар эдийн засгийн бодлогын хувьд МАН-ын дэвиүүлж байгаа мөрийн хөтөлбөр дээр энэ илүү жижиг төр, төрийг жижиг болгох жишээлбэл ДНБ дэх төсвийн зарлагын хэмжээ 32 хувь байгаа. Энийг багасгахаар нэлээн том зорилт тавьсан. Тэгэхээр энэ бол нэлээн амаргүй зорилт байгаа юм. Тэгэхээр энэ зорилтуудаас харахад хувийн хэвшлийг л дэмжиж байж саяын хэлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх бололцоотой байгаа. Тэгэхээр энэ дээр бусад улс төрийн намуудын хувьд ч гэсэн одоо яг яриад хусээд байгаа жижиг төр мөн хувийн хэвшлийг дэмжих гэсэн энэ зорилтууд энэ тусгагдсан байгаа учраас энэ зорилт зорилго зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжиж ажиллана байх гэж найдаж байна.**

Тэгээд энэтэй холбоотойгоор хувийн хэвшлийг дэмжихтэй холбоотойгоор ер нь энэ хувийн хэвшлийн хувийн өмчийн эрхтэй холбоотой асуудлууд мөн хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд. Зарим тохиолдолд энэ хувийн хэвшлийн гол хөшүүрэг болсон үнийн хяналттай холбоотой асуудлууд дээр ахиц дэвишил гарна байх аа гэж

бодож байна. Бизнесийн орчны судалгаа хийхэд ер нь ААН-үүдэд тулгарч байгаа ундсэн 3 асуудал байгаа нэгдүгээрт нь татвар, нийгмийн даатгалтай холбоотой энэ чиглэлээр бол өөрчлөлтүү реформ хийнэ гэж ойлгож байгаа. Мөн зээлийн хүйтэй холбоотой тодорхой зорилтуудыг энэ мөрийн хөтөлбөртөө тусгасан байгаа. Тэгээд энийг үргэлжлүүлж хэрэгжүүлнэ гэж найдаж байна.

Гуравт нь хувийн хэвшилд тулгарч байгаа нэг том асуудал хүний нөөцийн асуудал байгаа. Тэгээд энэ чиглэлээр бас мөрийн хөтөлбөрт гаднаас ажилтан авах квотыг байхгүй болгоно. Дээр нь энэтэй холбоотой төлбөрүүдийг чөлөөлөхөөр заачихсан байгаа. Тэгээд энэтэй холбоотой ажлууд өнгөрсөн Засгийн газрын яг сүүлд шийдвэр гаргаад энэ чиглэлээр арга хэмжээнүүд аваад эхэлчихсэн байгаа гэж ойлгож байгаа юм. Тэгээд ер нь хувийн хэвшлийн зүгээс яг төр засагтай холбоотой нэг хэд хэдэн асуудлууд байдаг. Тэгээд эвслийн засаг ч юм уу байгуулагдаад ер нь нэг анхаарах ёстой нэг хэдэн асуудал байгаа. Энэ нь төрийн бодлого, засгийн мөрийн хөтөлбөр гэхээс илүү хувь хүмүүсээс хувь сайдуудаас их бодлогууд хамаардаг. Тэгэхээр энийг одоо төрийн залгамж халаа гэдэг утгаараа энэ хувь хүнээс хамаарсан байдлыг байхгүй болгох талаар анхаарч өгөхийг хүсэж байна.

Дээр нь яамдууд хоорондоо уялдаагүй асуудлууд байдаг. Тэгэхээр энэ нь буцаад хувийн хэвшлүүдийн хувьд тодорхойгүй байдлууд үүсгэдэг. Дээр нь яамдуудаас гадна Засгийн газар болон орон нутагтай холбоотой асуудлууд гардаг. Тэгээд энэ тал дээр анхаарч өгөхөрэй гэж хүсэж байна. Тэгээд түрүүн бас Тэмүүжин гишүүн хэлж байсан. Засгийн зүгээс бид нар хувийн хэвшил зарим ажлуудыг хийж өгөхийг хүсдэг. Энэ нь ялангуяа дэд бүтэцтэй холбоотой том ажлууд байгаа. Хувийн хэвшлийн бизнес хөрөнгө оруулалт дээр хамгийн том гардаг зардал бол хөрөнгө оруулалтын

зардлууд байгаа. Тэгээд энэнтэй холбоотой эрчим хүч тээвэр ложистик дэд бүтэцтэй холбоотой ажлууд дээр төлөвлөсөн ажлуудаа шахаж хийж гүйцэтгэнэ байх гэж найдаж байна.

Тэгээд энэ чиглэлээр өмнө та бас ийм санаачилга гаргаж байсан. Одоо энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт байгаа энэ зорилтуудыг гүйцэтгэлийг хангах үүднээс диливерийн юнит буюу энэ гүйцэтгэлийг нь байнга хянаж байдаг тэрийг нь шахаж байдаг нөөцийг нь шаардлагатай нөөцүүдийг нь дайчилдаг яамд хоорондын уялдаануудыг нь хангаж байдаг энэ чиглэлээр үргэлжлүүлж бас ажиллана байх аа гэж найдаж байна. Тэгээд таны ажилд амжилт хүсье.

**Д.Амарбаясгалан:** Цэндийн Сандаг-Очир гишүүн баярлалаа.

**Ц.Сандаг-Очир:** Энэ цаг мөчөөс эхлээд 4 жил ажиллах Засгийн газар, парламентын цаг цохицэж эхэлж байна. Тийм учраас энэ 126 гишүүнтэй анхны парламентын 80 гишүүн нь шинээр орж ирсэн гишүүн байна гэдэгт их талархалтай байгаа. Гэхдээ шинэ орж ирсэн гишүүд маань шинэхэн дээрээ сонин гэдэг шиг уулыг эргүүлчихмээр, нураачихмаар, усыг эргүүлчихмээр л санагдаж байгаа байх. Хөндлөнгөөс гаднаас харах дотроос орж ирээд хийх 2 өдөр шөнө шиг зөрөөтэй байдаг гэдгийг хэлье.

Нөгөөтээгүүр парламентын гишүүд маань бас ирэх 4 жил суухдаа хурал чуулгандаа идэвхтэй суудаг байгаарай гэдгийг энэ юуны өмнө хэлэх гэж байгаа юм. Сүүлдээ ч хурал чуулгандаа суух хүнгүй болчихдог, Байнгын хорооны ирц хурдэггүй энэнээс болоод парламентын нэр хунд унах асуудлууд хуртэл гарч байдаг. Тийм учраас энэ шинээр сонгогдсон гэлтгүй бүх гишүүдийг хурал чуулгандаа идэвхтэй суудаг байхыг нэгдүгээртэй байгаа юм.

Хоёрт энэ танхимаас шударга ёс, энэ танхимаас хариуцлага, хуулиа дагаж мөрддөг байх асуудлууд эндээс хийгдэх ёстой. Өнгөрсөн парламент хамгийн олон Их Хурлын гишүүдийг бүрэн эрхээс нь түдгэлзүүлсэн хариуцлага оногдуулсан ийм парламент байсан шүү. Тийм учраас энэ хариуцлагын асуудлыг цаашидаа бас яагаад энэ удаагийн сонгуульд МАН-д үнэмлэхүй ялалт өгсний нэг шалтгаан бол өнгөрсөн 4 жил хариуцлагын асуудал, авлига хээл хахуультай тэмцсэн асуудал ахиц өөрчлөлт гарсанд сонгуулийн ялалтын тодорхой хувь нэмэр байгаа гэж хувьдаа урьж байгаа.

Тийм учраас цаашидаа энэ ажлаа үргэлжлүүлээсэй гэж Монголын ард түмэн хүсэж байгаа учраас ийм сонголтыг хийсэн гэж ингэж ойлгож байгаа. Тийм учраас гишүүддээ бас цаашидаа ёс зүйтэй байхыг хариуцлагатай байхыг уриалж байна. Нөгөө талаар цаашидаа 2, 3 зүйл дээр анхаарч ажилламаар байгаа юм. Авлигатай тэмцэх ажил дээр Их Хурал, Засгийн газрын гишүүд бол алган дээр тавьсан юм шиг шилэн байдаг аа. Харин энэ төрийн дунд шатанд анхан шатанд авлигатай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, авлигатай тэмцэх ажлын овоо хараагаа төрийн дунд анхан шат руу чиглүүлмээр байгаа шүү. Тэр зөвшөөрөл өгдөг, гарын үсэг зурдаг, тэр сонгон шалгаруулалт хийдэг тэр одоо тендер юм зохион байгуулдаг энэ улсуудын дунд энэ авлига хээл хахууль чинь асар их байгаа гэдгийг би зориуд хэлмээр байгаа юм.

Тэгээд хөшигний цаагуур нуугдихаад урд талд нь дарга нарыгаа сайд нарынхыг барьчхаад ингээд асуудлын араас бултаж зугтдаг. Ийм учраас авлигатай тэмцэх ажлыг анхан, дунд шатад эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага туилын чухал байна гэдгийг нэгд хэлье.

Хоёрт Монголын ард түмэн өнөөдөр банкнаас банк нь зээлээс зээлийн хооронд амьдарч байгаа. 17, 18, 19 хувийн хүүтэй ийм зээлд амьдарч байгаа юм.

Тийм учраас банк санхүүгийн салбарт энэ өрсөлдөөнийг бий болгох санхүүгийн чадавхтай банкийг оруулж ирэх энэ асуудал дээр онцгой ахиц гаргамаар байна аа. Банкны зээлийн хүүг бууруулах асуудал дээр онцгой анхаарал хандуулж ажиллах.

**Д.Амарбаясгалан:** Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн уг хэлнэ ээ.

**Ж.Золжаргал:** Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдыг энэ парламентад олонх болсон намын дарга гэдэг үүднээс нь захиж хэлэх нэг хэдэн зүйлс байна аа. Тоон дээр бид нар их анхаарах хэрэгтэй байна. ДНБ-д харьцуулахад төсвийн эзэлж байгаа хэмжээ, дээрээс нь энэ төрийн өмчийн томоохон компаниудын Эрдэнэт Эрдэнэс Тавантолгой, тэгээд томоохон сангуд гол банкнууд төрийн өмчийн. Эд нарыг нэмээд үзэхээр ДНБ-ий 70 хувь гараад явчхаж байгаа юм. 70 хувь ойролцоогоор. Өөрөөр хэлбэл хэдийгээр бид эрх баригчид маань ч гэсэн энэ эдийн засгaa илүү их чөлөөтэй болгоё төрийн өмчийн томоохон компаниудыг нээлттэй ХК болгоё гээд ярьж ирсэн боловч тоо эсрэг зүйл үзүүлээд байгаа. Тооноос харахаар энэ цаашидаа бас нэмэгдэх хандлагатай байгаа. Тэгээд энэ маань эдийн засаг улам их төржсүж байна аа. Улам их төвлөрч байна. Тэгэхээр бодит зорилт маань тоон үзүүлэлттэйгээ зөрж байгааг анхаараасай гэж. Тэгээд энэ зорьж байгаа зорилтуудаа зоригтойхон шиг эхлүүлж хийгээд тэр томоохон төрийн өмчүүдийг Монгол иргэд өөрсдөө хувьцаа эзэмшидэг, нээлттэй компани болгохгүй бол эдийн засаг улам л их данхайна төржинө. Тэр чигээрээ хулгайтай тэмцэхэд хүнтэй тэмцэнэ дээрээс нь нөхцөлийг нь ч бууруулна гэж түрүүн ярьж байсан та. Тэгэхээр тийм байдлаар нөхцөлийг нь бууруулах хэрэгтэй байна аа. Энэ аж ахуйд орооцолдлогийг багасгах нь бол энэ бүх ярьсан өөрчлөлтийн гол нөхцөл юм болов уу гэж бодож байна.

Хоёрт нь нэг тоо байна. Монгол Улсын нэгж бүтээгдэхүүнд ноогдох өртгийн тээвэр логистикийн өртөг олон улсын дундаж 13 хувь, Монголд 26 хувь буюу газар зүйн өгөгдлөөрөө манайх чинь өндөр өртөгтэй улс. Тийм болохоор Монголын татвар харьцангуй хямд гэдэг нь өөрөө зөрчилтэй тодорхойлолт. Монголд үйлдвэрлэлийг бид нар хөгжүүлье гэж маш их ярьж ирсэн. Гэхдээ үйлдвэрлэл хэзээ хөгждөг вэ гэхээр ашигтай үед хөгждөг. Ашигтай байхын тулд байгалийн газар зүйн сул талаа нөхөх татварын зохицуулалт бол зайлшгүй шаардлагатай байгаад байгаа юм. Тэгээд хөрөнгө оруулъя гэхээр нөгөөх нь хөрөнгө оруулалт нь ашигтай байдаггүй. Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн хөгжүүлье гэхээр олигтой бас явж өгдөггүй. Яг ийм эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлээд экспортод гаргаж байгаа эсвэл одоо үйлдвэр барих гэж байгаа бол байхгүй юмнаас татвар авах гэж байхаар ирээдүйд бий болсных нь дараа авна гэдэг утгаараа гааль НӨАТ-аас нь чөлөөлөх гэх мэтчилэн. Яг ингээд төсөл дээр ажиллаж байсан хүмүүсийн хувьд аягүй их том зардал болдог л доо.

Тэгэхээр иймэрхүү үйлдвэрлэлийг дэмжссэн бизнесийг, хөрөнгө оруулалтыг татсан тэр нь тэгэхдээ яг бодитой татварын бодлогоор зохицуулах шаардлагатай зүйлс маш тодорхой харагддаг болчоод байгаа. Энэ дээр анхаарч өгөөсэй гэж хүсэж байна. Тэгээд эцэст нь хэлэхэд парламент холимог их тийм сонирхолтой парламент Монгол Улсын түүхэнд бүрдлээ. Хяналттай тэнцвэртэй гэж та өөрөө хэлсэн.

Тэгэхээр энэ хяналт тэнцвэрийг тогтооход дахиад нөгөө чөлөөт эдийн засаг чиргэдийн шууд оролцоо гэж ярьдаг боловч бодит байдал дээр тоо өөр гарцаад байгаатай адилхан буцаад нэг нам нь бас хэтэрхий их давамгайчих вий дээ гэдэг тийм болгоомжлол хүмүүсийн дунд их яваад байна л даа. Тэгэхээр энэ дээр сөрөг хүчиний хувьд мэдээж сөрөг хүчин ч юу байх вэ дээ. Цөөнхийн хувьд тэр

тэнцвэрийг хадгалахын төлөө л ажиллаж таарна. Тэгээд олонх бас өрөнхий нөгөө олон улсын нөхцөл байдалын дунд бид олон өнгөтэй байна гээд тиймэрхүү мэдээллүүд хийгээд яваад байгаа. Тэгээд тэр үндэснийхээ эрх ашигийн үүднээс зарим зүйл дээр нэлэн хулээцтэй магадгүй зарим зүйл дээр орж татсан иймэрхүү байдалтай эрх баригч байх болов уу гэж бодож байна. Тэгээд танд амжилт хүсье ээ. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

**С.Эрдэнэболд:** Баярлалаа. Бид яг гүйцэтгэх засаглалын тэргүүний тухай ярьж байгаа. Тийм учраас яг энэ мөчид бас Монгол Улсын үндэсний аюулгүй байдалын үзэл баримтлалын, 1.1.4-ийг Монгол Улсын Ерөнхий сайдыар нэр дэвшижид хэлж протоколд үлдээхийг хүсэж байна. Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд сууринсан нийгмийн тогтвортой байдалыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдалыг хангах баталгаа мөн гэж. Тэгэхээр энэ үндэсний аюулгүй байдалын үзэл баримтлалын энэ зүйл заалт бас энэ Засгийн газрын бүүр хатуу чиг баримтлал болж яваасай гэж бодож байгаа. Яагаад гэхлээр суулийн үед бид нар маш их туйлиширч талцдаг болсон. Тухайлбал ардчилалд дайсагнаж ханддаг болсон. Тэр ардчилал гэдэг бол аль нэгэн намын өмч гэхээс илуутайгээр нийгмийн хөгжил дэвшил аюулгүй байдал энэ бүх зүйлийн баталгаа гэдгээ бид бүгдээрээ намчирхалгүй бас хулээн зөвшөөрөх цаг болсон. Тэгээд Ерөнхий сайдад З зүйлийг хэлмээр байгаа юм.

Нэг, та үйл ажиллагаандaa бүхий л талаар популизмаас ангид байх бодлого руу чиглэсэн байх тал дээр Засгийн газраа манлайлан ажиллаарай. Энэ Монгол Улсын Засгийн газрын чухал зарчим байх ёстой байх.

Хоёр, Форм Осмос Дес гэж байгууллага суулийн 42 жилийн 42

жилийн судалгаагаар 10 саяас доош хүн амтай орнууд маш хурдтайгаар хөгжихөд 3 зүйлийн бодлого хэрэгтэй.

Нэг, боловсролын салбар гэж ярьдаг. Боловсролын салбарыг салбар гэж бодохоос илүүтэйгээр нийгмийн хөгжлийн суурь ойлголт гэж ойлгомоор байна аа. Эцэг эхийнхээ баян ядуу хөдөө хотод амьдарч байгаагаас хамаарч хүүхдүүд чанартай чанаргүй ижил гарааны биши нөхцөлөөс эхэлж байгаа. Эндээс шударга бус байдал эхэлж байгаа. Өнөөдөр цэцэрлэгийн хүүхэд 2475 төгрөгөөр өдрийн хоолоо идээж байгаа. Гэхдээ Монголд менежмент хийвэл мөнгө байж болно.

Тийм учраас боловсролын салбарыг суурь салбар гэж бодож энэ тал дээр хөрөнгө оруулалтыг тултал нь хийж явах нь ирээдүйн хөгжилд маш чухал аа гэж үзмээр байна.

Хоёрдугаарт бизнесийн таатай орчин. Түрүүн Энхтувшин гишүүн хэлчихсэн учраас давтахаа болж болох.

Гуравдугаарт Шударга ёс. Хууль зүй, дотоод хэргийн яам гэж ярьдаг. Бид нар англи хэл дээрээ орчуулахдаа жастис гээд нэр ашиглачихдаг. Монгол хэл дээр орчуулахдаа Хууль зүйн яам гэж хэлдэг. Тэгээд энэ хууль хүчний байгууллага нь өөрөө хүний эрхийг хамгаалах гэхээс илүүтэйгээр тодорхой хэмжээнд өөрсдөө хүний эрхийг зөрчих субъект болчхоод байдаг аа.

Тийм учраас энэ Засгийн газар Хууль зүйн яамыг олон улсын жишигийн дагуу шударга ёсны яам гэж нэрлээч ээ гэж хүсэж байгаа юм. Ингээж хандлагaa өөрчилж олон улсын жишиг рүү хандаж шударга ёс гэдэг энэ зүйлийн төлөө бид нар явах ёстой. Өнөөдөр энэ зүйлийг олон удаа хэлсээр байгаад үнэ цэнгүй болчихсон юм шиг хүмүүс бүүр сонсоод уурладаг болсон байна аа. Тэгэхдээ энэ бол Монголын ирээдүй үнэт зүйл учраас арчилал, эрх чөлөө, шударга ёсыг

баталгаажуулах хэм хэмжээ учраас энэ Засгийн газар том утгаараа энэ шударга ёсны төлөө тэмцүүлэх шударга ёсны яам гээж ХЭДХЯ-ыг тэгж нэрлэмээр байна аа. Энэ олон улсын жишиг рүүгээ явсан алхам.

Ингээд ер нь энэ Засгийн газар хэнийг ч гэм буруутай нь шүүхээр нотлогдоогүй байхад гэмт хэрэгтэн мэтээр зарладаг байдлыг таслан зогсоосноос, хүний эрх, эрх чөлөөг хамгаалнаас энэ Засгийн газрын үйл ажиллагаа эхэнэ ээ гэж бодож байна аа. Төгсгөлд нь хэлэхэд бид гүйцэтгэх засаглалын тэрэгүүний асуудлыг ярьж байна. 126 парламентын гишүүдийн 60 хэд нь танхимд сууж байна аа. Ер нь энэ парламентын гишүүд эхнээсээ хариуцлагатай ханддаг баймаар байна аа. Бие засах гээд гарч болно. Гэхдээ энэ коридор дотор ингээд хоорондоо халаасандаа гарцаа хийчхээд ингээд яриад байдаг. Ер нь бол ард түмний эрх ашигийг хамгаална гэж төлүүлнэ гэж элч мөн гэж хэдхэн хоногийн өмнө тангараг өргөсөн хүмүүс энэ гүйцэтгэх засаглалын асуудал дээр ч гэсэн бух асуудал дээр хариуцлагатай баймаар байна гэж хэлмээр байна.

Ингээд Монгол Улсын Ерөнхий сайд цаашидаа мэдээж асуудлууд дээр олон төрлийн уулзвар зөрчил зөндөө юм гарна. Энэ дээр яг энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дээр байгаа 1.1.4 гэдэг зарчмыг баримталж ажиллахыг хичээнгүйлэн хүсье ээ.

**Д.Амарбаясгалан:** Банзрагчийн Түвшин гишүүн. Гишүүдийг танхимдаа цугларахыг сануулъя.

6 гишүүний дараа санал хураалт явагдана.

**Б.Түвшин:** Баярлалаа. Тэгээд энэ Их Хурлын гишүүн болоод танхимдаа анхныхаа уг хэлж байгаа учраас сонгогчдодоо Цагаан морь сарын цагаан морь өдрийн мэндийг өргөн дэвшүүлье ээ.

Дээрээс нь Амарбаясгалан даргадаа нэг санал хэлчихье ээ. Анхны шийдвэрээ гаргахдаа жоохон зөв хандаарай. АН-аас бүлэг дээр төсвийн хороон дээр оруулахын тулд зургаа дээр бичихсэн байна лээ шүү. Та 9, 10 руу бичсэн гэж байгаад хасаад уничихсан байна лээ. Эхний шийдвэрүүдээ зөв гаргаж хянаж яваарай. Ордны хоронд орчихвоо. Бичиг цаасаа сайн шалгаж байж зөв шийдвэрээ гаргаарай. Ерөнхий сайдын нэр дэвшигч Оюун-Эрдэнэ даргадаа амжилт хүсье. Нэг уг их таалагдаж байгаа.

Та нар тэгээд өөрсдөө оролцоод яв л даа гэж. Яг ийм байдлаар явах юм бол болж байна. Яг оролцоод явна. Оролцох оролцохдоо маш их санал санаачилгатай гомдол шүүмжлэхгүй, узэл баримтлалаа илэрхийлээд зөв санал санаачилга гаргаад явна. Тэрийг нь авахгүй явах юм бол харин сүүлдээ шүүмжлэгч болоод олон нийт руу харьцагдай ийм л үүрэгтэй функцтэй. Олон түмэн намайг ялангуяа манай намынхныг шүүмжлэгч, гомдогч, цөөнх бай гэж сонгоогүй байх. Дийлээгүй учраас л бид нар цөөнх болчихсон байх.

Тийм учраас цөөнхийн ч үүргээ гүйцэтгэж мөрийн хөтөлбөр дээр тавьсан бодлогоо ч хэрэгжүүлнэ. Сая энэ Төсвийн байнгын хорооны тухай ингээд АН-аас б дээр дэвшээд ороогүй. Ер нь энэ ашиг сонирхлын тухай сая сурвалжлагч асууж байна. Төсвийн байнгын хорооныхон төсөв дээр төсөв тавиулахыг нь болиулчихъя. Төсвийн байнгын хорооныхон юу хийдэг болох вэ гэхлээрээ төсвөө яаж сайжруулдаг болох вэ. Жинхэнэ ашиг сонирхол бол мөнгө тавих гэж тэнд орсон хүмүүс.

Тийм учраас дахиад Байнгын хороонууд дээр ер нь тиймэрхүү чиглэл гаргачих нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгэхгүй бол Төсвийн байнгын хороон дээр орж байгаа хүмүүсийн ихэнхийг нь харахлаар нэг төсөв илүү тавьчих гэсэн л хүмүүс орж ирээд байх

шиг байна. Ийм зарлагын шинж чанартай ашиг сонирхлоор энэ чинь жинхэнэ ашиг сонирхол. Тийм учраас Төсвийн байнгын хорооныхон төсвийн бодлого гаргадаг болъё.

Дээрээс нь түрүүн ярьж байна лээ. Манай Монгол Улс уур уурхайн орон гэж. Өнөөдөр АН-ын мөрийн хөтөлбөр дээр ч байсан. Та бүгдийн мөрийн хөтөлбөр дээр ч байж байгаа. Монгол Улсыг газар тариалан, мал аж ахуй, хөдөө аж ахуй болгох ёстой. Нуудлийн МАА-г нүүдлийн чигээр нь сэргээх энэ мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх бодлогуудыг гаргаж тавина. Энэ бодлогууд хэрэгжсээд явах юм бол энэ энэ бодлогуудыг хэрэгжүүлээд яваасай гэж ингэж ард түмэн сонгосон учраас энэ байна. Энэ нь нэг их тийм шүүмжлэхээсээ илүү илүү ажлаа хийе, санал санаачилгатай байя гэсэн бодлого байж байгаа. Тэгээд илүү 126 гишүүн бол пропорциональ болон мажоритороор орж ирсэн илүү тэнцвэртэй байлгах олон намын төлөөллүүд ялангуяа жижиг намын төлөөллүүдийг орж ирснээрээ олон санаа бодол, олон ургалч үзлийг хөгжүүлэх гэж энэ парламентын хууль энэ тогтолцоо систем нь урьд нь шийдвэгдсэн юм байна гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ тогтолцооныхоо дагуу энэ нэгэнт хуулиа батлаад ингээд ороод ирсэн учраас цөөнхийнхөө угийг авч, бодлогодоо хэрэгжүүлж, хамтарсан бодлогыг цааш нь үргэлжлүүлж ер нь Монгол Улсын нийт эдийн засгийнхаа болон улс орныхоо хөгжлийн төлөө төрийн эрх мэдэл нэр хүндээ хувийн ашиг сонирхолдоо явуулахгүй явах тал дээр шударга ажиллаарай гэж хэлэх байна. Тэгээд та бүхэнд бүгдээрээ мөрийн хөтөлбөрөө зөв болгуулж хувийн ашиг сонирхлоос ангид байж шударга байцаа. Ялангуяа тэр Байнгын хороодын нөхдүүд бодлогоор уралдах гэж байгаа л гэж ойлгож байгаа шүү. Баярлалаа та бүхэнд.

**Д.Амарбаясгалан:** Бат-Өлзийн  
Бат-Эрдэнэ гишүүн.

**Б.Бат-Эрдэнэ:** Ерөнхий сайддаа амжилт хүсье. Тэгээд Хөвсгөл, Булган, Орхон аймгийн нийт сонгогчдоодоо итгэл үзүүлсэн явдалд туйлаас талархаж байгаагаа илэрхийлье. Өнгөрсөн хугацаанд шинэ сэргэлтийн бодлого маань унэхээр амжилттай маш сайн хэрэгжсэн. Энэ бол манай Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын маань хийсэн томоохон ажил амжилттай ажлуудын үндэс суурь юм болов уу гэж бодож байгаа юм. Нэг хунд ноогдох ДНБ нь 5900 ам долларт хурлээ, эдийн засгийн өсөлт 7 хувьд хурлээ, валютын нөөц маань 5.3 тэрбум ам долларт хурлээ ковидыг бид нар амжилттай давж гарлаа.

13.3 их наяд төгрөгийн өрийг бид нар төлж чадсан. Энэ ч утгаараа Монгол Улсын ард түмэн бол МАН Монгол Улсын Засгийн газрыг маш сайн ажил хийсэн болов уу гэж унэлж дахииж олонхоор сонгосон болов уу гэж бодож байгаа. Одоо бол ирээдүйд бид нар энэ эдийн засгийн өсөлтийг өрх болгонд оруулахын төлөө МАН-ын мөрийн хөтөлбөр тусгагдсан. Энэ ажил маань ч гэсэн цаашидаа амжилттай сайн хэрэгжинэ гэдэгт итгэж байгаа.

Монгол хүн бүр баялагтаа эзэн болох Үндэсний баялгийн сангийн сангийн тухай хуулийг баталсан. Энэ Үндэсний баялгийн сангийн тухай хууль маань бол цаашидаа илүү сайн бодлого илүү сайн хэрэгжиж ард түмэн маань бол унэхээр баялагтаа эзэн болж явах ёстой гэж харж байгаа. Эдийн засгийг сэргээх дээр бусад улс төрийн намууд маань ялангуяа парламент суудалтай улс төрийн намууд маань бол маш сайн дэмжиж оролцоосой гэж хүсэж байна. Аялал жуулчлалын салбар өнгөрсөн хугацаанд 1.3 тэрбум ам долларыг давж Монгол Улсын тэрбум доллар давсан орлогыг бурдүүлсэн 2 дахь салбар болсон. Миний хувьд бол Байгаль орчин, аялал жуулчлалын сайдар өнгөрсөн 2 жил хагасын хугацаанд ажиллаа. Аялал жуулчлалыг хөгжүүлэх

үндэсний хорооны даргаар Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ маань амжилттай сайхан ажиллаж кабинетыг бол маш сайн удирдааж ажилласны үр дүн гэж харж байгаа.

Монгол Улсын парламентад аялал жуулчлалын салбарыг дэмжих лобби бүлгийг бид нар байгуулахаар ажиллаж байна. Улсын Их Хурлын гишүүд маань нам, эвсэл, бүлэг харгалзахгүйгээр энэ лобби бүлэгт нэгдэн орж Монгол Улсын экспортын орлогыг нэмэгдүүлэхийн төлөө эдийн засгийг дэлгэхийн төлөө та бүхнийг дэмжиж ажиллаасай гэж хүсэж байгаа. Өөр нэг амжилттай хэрэгжсэн ажил унэхээр “5 ш” ажиллагаа, шүүр, шүгэл, шувуу, шилжүүлэх, шилэн гэдэг энэ “5 ш” ажиллагаа маань бол МАН-ын мөрийн хөтөлбөрт тусгагдсан. Энэ үйл ажиллагаа бол илүү их идэвхжиж ажиллаасай гэж хүсэж байгаа.

Ялангуяа орон нутагт энэ үйл ажиллагаа бол маш сайн явагдах ёстой юм байна гэдгийг бол маш сайн ойлгосон. Тэгэхээр энэ үйл ажиллагаа “5 ш” ажиллагааг бол орон нутагт илүү эрчимжүүлжс ажиллаасай гэж хүсэж байна. Авлигын шүүхийг байгуулах ёстой. Авлигын шүүхийг байгуулах энэ ажлыг бол Монгол Улсын Ерөнхий сайд санаачлан ажиллаж ажил хэрэг болгооор МАН-ын мөрийн хөтөлбөрт орсон энэ авлигын шүүхийг бид нар яаралтай байгуулах хэрэгтэй. Өнөөдөр Монгол Улсын ерөнхий сайдар ажиллаж байсан сай Чимэдийн Сайханбилигээс авхуулаад эх орноосоо зугтааж АНУ-д орогнол ирж амьдарч байгаа. Энэ хумүүсийг бид нар буцааж эх оронд нь авчрах шаардлагатай байгаа.

Тэгэхээр энэ 5 ш ажиллагаа бол цаашидаа илүү их сайн өргөжиж хөгжөөсэй илүү их сайн бодлогын түвшинд яваасай. Энэ дээр бол Монгол Улсын Ерөнхий сайдын манлайлал үргэлжлээсэй гэж хүсэж байна. Тэгээд Монгол Улсын Ерөнхий сайд

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэдээ ажлын өндөр амжилт хүсье ээ. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Жудгийн Баярмаа гишүүн.

**Ж.Баярмаа:** Сонсогдож байна уу?  
Одоо сонсогдож байна. Бүгдийн оройн амрыг эрье ээ. Тэгээд коммент ба санал хэлье гэж бодож байна. Коммент хэсэг чинь юу хэлэх вэ гэвэл арчиллын, авлигын гээд маш олон индексээр ухарч байгааг маш олон удаа ярьж байгаа. Энэ дээр бол манай Ерөнхий сайд бол нэгдүгээрт төсөөллийн индекс ээ гээд ингээд байх юм.

Хоёрдугаарт би тэмцээд байгаа учраас ил гарчхаж байгаа юм аа гээд байх юм. Гэтэл энэ чинь АН-ын үеийнхээс тавиад 49 байраар ухарсан. Энэ сүүлийн таныг тэмцсэнээс эхлээд ил гарцаад индекс нь буураад байгаа явдал биш тогтвортой буурч байгаа юм. Буурсаар буурсаар 49-өөр буюу тавиад байраар ухарсан. Энэ бол коммент. Тэгээд ер нь бол шүүхүүд, шүүгчид буруутай гээд л нэг ярих юм. Эсвэл гаднын хүчин зүйлсийн буруу гэх юм эсвэл Элбэгдоржийн буруу гэх юм. Сүүлийн үед бол Зоригийн хэргээс боллоо гэх юм.

Ингээд дандаа ямар нэгэн бусдын буруутай үйл ажиллагаанаас болоод л энэ Засгийн газрын амжилтгүй явваа нь ингээд шалтгаалаад байгаа юм шиг л байнга ийм юм л сонсогдоод байна л даа. Өнөөдөр ч гэсэн дандаа л ер нь нэг тиймэрхүү байдал ингээд сонсогдоод байгаа учраас зориуд энэ комментыг хэлье гэж бодсон юм аа. Тэгэхээр энэ индексүүдийг бол сөрөг хүчин зохиогоод байгаа юм биш. Энэ чинь олон улсын байгууллагууд олон 100 жилийн түүхтэй энэ байгууллагууд институцууд зохиогоод байгаа. Бизнес хийх үе, эдийн засгийн эрх чөлөө, засаглалын индекс бух л индексээр ухарч байгаа юм.

Яг эндээс улбаалаад би дараагийн нэг хэсэг рүүгээ орьё гэж бодож байна. Сонгууль саяхан энэ Олон улсын байгууллага буюу И паб Европын аюулгүй

байдал хамтын ажиллагааны байгууллагын ажиглагчид ирээд манай сонгуулийг дүгнээд явсан. Энэ бид нар унэлж, дүгнээгүй Олон улсын байгууллага дүгнэсэн. Юу гээд дүгнээд явсан гэхээр хүч тэнцвэргүй ээ, тэги бус гаралтай юм байна гэж хэлсэн.

Энэ дээр нэг хамгийн анхаарал татааж байгаа нэг зүйл юу вэ гэвэл энэ цалин, тэтгэвэр нэмснээс болсон. Ер нь гэдэг энэ зүйлийг дүгнэсэн байна лээ. Тэгэхээр манай сонгууль ер нь бол шударга болж байна уу гэдэг асуудал эндээс үүснэ. За яах вэ бид нар дэвшил, сонгуулийн тогтолцоогоо холимог болгосон энэ дэвшил гэж үзэж байна. Гэхдээ сонгууль дахь мөнгөний нөлөө ер нь улс төр дэх мөнгөний нөлөө оролцоо огт багасаагүй ээ.

Сонгуулийн тойрог томрохын чинээгээр тараадаг мөнгө нь ихэссэн. Эндээс дахиад Улс төрийн намын тухай хууль буюу улс төрийн намын асуудал гарч ирнэ. Тэгэхээр ний нуугүй хэлэхэд улс төрийн намууд бол маш дамжуу байгаа. Тэрний энэний нам гэхийн эцэсгүй парламентад суудалгүй намууд нь болохоор нэг туслан гүйцэтгэгчийн үүрэгтэйгээр ордог. Сүүлийн энэ сонгуулиар бол бүүр мөнгө тараагчийн статустай орсон. Ардын намын нэр дэвшижчийн нэрийн өмнөөс өөрийнхөө нэрийг хамтарч оруулаад ингээд мөнгө тараасан. Энийг бол бид нар баривчлаад бариад гэх юм уу зохих холбогдох байгууллагуудад нь өгсөн.

ТЕГ-т өгсөн, ЦЕГ-т өгсөн боловч харамсалтай нь энэ бол асуудал үүсэхгүй байх гэж би бодож байна. Айж байна. Тэгэхээр энэ хамгийн гол арчиллын үнэт зүйл болсон энэ шударга сонгуулиа бид хийж чадахгүй бол нөгөө арчилал чинь алсарсан хэвээрээ л байна. Тэгэхээр энэ Сонгуулийн тухай хуулиа эргэж харах шаардлагатай юм байна.

Тэгэхээр бид нар сонгууль дөхөөд ирэхээр нэг б сарын өмнө жилийн өмнө

гээд нэг бөөн уралдаан тэмцээн болоод Сонгуулийн тухай хуулиа өөрчилдөг биш саяын энэ өнгөрсөн Сонгуулийн тухай хууль нь ямар үр дүн авчрав аа ямар үр дагаварт хүрэв гэдгээс асуудлыг эхлэх хэрэгтэй. Тэр мөнгө тараалт бол огт багассангүй. Тэгэхээр бид нар бол ер нь төрийн төлөө ажил хийх гэж орж ирж байгаа хүмүүс. Тэгэхээр бид нар буюу энэ нэр дэвшигчид яагаад хувиасаа мөнгө гаргаж байгаа юм. Ер нь яахаараа тэр аудитаас гаргаж өгсөн тэрбум тэрбум төгрөгийг зарцуулах ёстой юм. Тэр мөнгийг гаргасан хүн тэрийг яаж байна гэж ойлгох вэ?

**Д.Амарбаясгалан:** Даваагийн Цогтбаатар гишүүн.

**Д.Цогтбаатар:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Юуны өмнө Өвөрхангай, Баянхонгор, Архангай аймгийн сонгогчдоо итгэл хүлээлгэн Улсын Их Хурлын гишүүнээр тангараг өргүүлж илгээсэнд баярлалаа. Хичээж ажилана гэдгээ илэрхийлье.

Тэгээд өнөөдөр банкны салбарын 100 жилийн ой тохиож байгаа. Тэгээд хамтран ажиллаж байсан нийт банкирууддаа болон энэ системд ажиллаж байгаа нийт банкирууддаа баярын мэнд хүргээд амжилт хүсье ээ. Тэгээд Ерөнхий сайдад хандаж нэг 2-оос 3 санал хэлье ээ. Хувь гишүүний болон сонгогчдоос ирүүлж байгаа саналаар эрх баригчид өнгөрсөн хугацаанд хэвлэлийн эрх чөлөөгүй, хүний эрхийг уландаа гишгэж хэлмэгдүүлж өдий хурсэн. Энэ тал дээрээ анхаарч ажиллаарай гэж хүсээж байна. Тэгээд хууль сахиулагчид нь хуулийн хүрээнд ажлаа хийх боломжийг нь олгож өгөөрэй. Улс төрчид нөлөөлдөг байдлыг таслан зогсоогоорой гэж хүсээж байна. Тэгээд МАН ялсан гэж үзэж байгаа бол Засгаа дангаараа байгуулаад яваасай гэж хүсээж байна. Хамтраг нэртэй АН-ын нэг хэдэн албан тушаалтнуудад ашиг хонжсоо хайгчдад

ажилд манай тэр хүмүүсийг ажилд авах гэж байгаа бол бүүр намдаа элсүүлээд авчхаарай гэж хэлж байна. Тэгээд ер нь цаашдаа бол ноосон бордооны үйлдвэр барих малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулаад экспортод гаргах гэх мэт зөв зүйлийг бол дэмжээд явна буруу зүйлийг шүүмжлээд явах болно. Тэгээд танд амжилт хүсье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ганбатын Очирбат гишүүн.

**Г.Очирбат:** Юуны түрүүнд энэ ардчилал эрх чөлөөний төлөө 430 мянган иргэн саналаа өгсөн энэ 430 мянган иргэддээ талархал илэрхийлье ээ. Өнөөдөр бол энэ танхимиын зүүн жигүүрт эрх чөлөөний манаач нар сууж байгаа гэж та бүхэн ойлгоорой. Ялангуяа бид нар хувь хуний эрх чөлөөн дээр хатуу байр сууриа байнга илэрхийлж байх болно. 4 дэх засаглал буюу хэвлэн нийтлэх энэ та бүхэн сайн мэдэж байвал Өнөрцэцэг сэргүүлчийн яг сэргүүлчийнх нь хувьд бид байр сууриа нэлээн чанга илэрхийлнэ.

Хоёрт гэх юм бол эдийн засгийн эрх чөлөөний үзэл санааг хамгаалагч нар энд сууж байна гэж та бүхэн ойлгоорой. Хувийн хэвшлээ АН-ынхан бүх чадлаараа дэмжисж ажиллана гэдгээ бас энэ индэр дээрээс илэрхийлье.

Гуравт нь бол бид нар, шударга, ёсны, эрх чөлөөний манаач нар энд сууж байгаа. Түрүүн бас Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын асуултад хариулж байгаа хариултууд дээр нэлээн сэргэл эмзэглэж сууж байлаа. Ерөнхий сайд нь шударга ёсыг энэ хуулийг шударга ёсыг хэрэгжүүлэх гээд байдал дотор нь байгаа МАН-ын 8 жил эрх барьсан хүмүүс эсрэг ажиллаад байдал юм байна гэдэг ойлголтыг авлаа хувь хунийхээ ууднээс.

Дараа нь бид нар үндэсний эрх чөлөөгөө хамгаална. Монгол Улсын сая 500м2 талбайд 3.5 сая иргэдийн төлөө өдөр болгон ажиллаж дуугарна гэдгийг

энэхүү индэр дээрээс хэлэхийг хүсэж байна аа. Тэгээд ер нь суулийн 8 жил юу болсныг Монголын ард түмэн бүгд мэдэж байгаа. Бид нар “5 ш” ажиллагаа гээд явуулсан. Авч ирсэн хүмүүсийн маань үр дүн хаана байна аа? Үр дүн байхгүй сонсгол хийсэн. 350 тэрбум төгрөгийн асуудал гээд л ногоон автобус гээд явсан. Сонсгол хийсэн үр дүн байхгүй.

Дараа нь дээрээс нь Хөгжлийн банкны асуудал яригдаж эхэлсэн. Монголын бүр 8 настай хүүхдээс 80 настай азай буурал маань хүртэл бүгд ойлгож мэдсэн үр дүн байхгүй. Тэгээд ингээд ажлаа хийдэггүй. Шударга ёсыг тогтооно гэж аман дээрээ ярьдаг начир дээрээ очихоор Ерөнхий сайдыгaa энд тэндээс нь бойкотолдог, боодог хаадаг, эрх чөлөөг нь хасдаг шударга ёсны төлөө дуугарахад нь ард нь ажлыг нь боодог л гэж ойлгож байна шүү дээ.

Түрүүний асуулт хариултаас бол. Энэний ар дээр бид нар бас нэг асуудлыг аягүй нухацтай ярих ёстой. Юу гэхээр манай АН-ын гишүүд бол ихэнх нь хэлж байна. Энэ төрийн сонгууль бол үнэхээр шударга бус явдаг болжээ. Асар их мөнгөний зодоон хэруул тэмцэл ард иргэдээ 2, 3 хуваадаг. Ийм юм болсон байна. Тэгэхээр энэ дээрээс нэлээн байр суурьтай бид нар АН-ынхан ялангуяа энэ Сонгуулийн тухай хууль дээр дахиад ажиллах ёстой юм байна гэдгийг хувь гишүүнийхээ хувьд ойлгоод сууж байгаа. Хамгийн сүүлд бол Ерөнхийлөгчийн, Ерөнхий сайдын санал болгож байгаа ажлаа хамтраад хийе ээ гэдэг дээр байр суурь нэг байгаа. Ялангуяа бид нар энэ эрх чөлөөний арчиллын манлай болсон Зориг агсныхаа угийг АН-ын мянга мянган гишүүд ойлгож ухаарах ёстой. Бид нар хувь хүний эрх ашгаа хойшио татна.

Бүлгийнхээ эрх ашгийг хойшио татна. Улс эх орныхоо эрх ашгийн төлөө ажиллах ёстой. Яагаад гэхээр бид анхны чуулган дээрээс төрийнхөө төлөө тангараг өргөөд энд сууж байгаа. Тэгэхээр АН-ын Их Хурлын гишүүд болон

АН-ыг дэмждэг 1200 мянган гишүүд арчилсан узэл санааг дэмждэг нийт Монголчууд энд сууж байгаа 42 гишүүнийг ойлгох ёстой. Бид Монгол Улсын эрх ашгийн төлөө энд сууж байгаа. Тэгээд Монгол Улсын бас Ерөнхий сайд удахгүй болох гэж байна. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайддаа амжилт хүсье. Шударга ёсныхоо тэмцлийг явуулаарай. Таны зоригтой хийсэн энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр чинь энэ олон залуучууд орж ирээд сууж байна. Энэ шударга ёсны чинь талд зогсоно. Аж үйлдвэрийн салбарын хөгжлийн талд зогсоно. Та түрүүн хэллээ бид нар эрчим хүчиний салбар дээр реформ хийж Монгол Улс өөрөө энэ эрчим хүчинийхээ тусгаар тогтолыг хамгаалж явахгүй болохгүй ээ гэж хэллээ.

**Д.Амарбаясгалан:** Ренчинбямбын Сэддорж гишүүн.

**Р.Сэддорж:** Та бүхэндээ оройн мэнд дэвшүүлье. Тэгээд шинэ нийт гишүүдээ ажилд нь өндөр амжилт хүсье ээ. Юуны өмнө өмнийн цэнхэр.gov нутаг Өмнөговь аймгийн ард иргэд Дундговь аймгийн ард ард иргэд, Говьсүмбэр аймгийн ард иргэд, Дорнынговь нутгийн ард иргэддээ баярласан талархсанаа илэрхийлж байна аа. Та бүгдийнхээ итгэл сэтгэлийг дааж явахыг хичээнэ ээ.

Хамгийн чухал захих зүйл Ерөнхий сайддаа захья аа. Тэгээд та угэндээ хэллээ. Говийг устай болгоё. Сонгуулийн өмнө ч ярьж байсан тэгээд тэрэнд их баярлаж байгаа. Тэгээд.gov үс байвал юу ч хийж болно. Одоо үнэхээр харамсалтай нь бороо орохoo болиод байна аа. Тэгээд Ханбогд суманд тэмээчин айлд очсон бид нар тэгээд ботго харангадаж ухэхийг анх удаа харлаа гэж хэлсэн. Тэгээд үнэхээр энэ жил бороо орохгүй маш хэцүү боллоо гэж хэлж байсан. Тэгээд тэмээ гэдэг амьтан тэсвэртэй амьтан тэгж байхад бусад мал аж ахуй хэцүү байдалд орно. Ийм учраас 3 жилдээ багтаагаад бүгдээрээ нийлээд энэ говийг устай болгох гадаргын усыг л крантаар явуулах л энэ ажлыг л

хэдүүлээ хийх хэрэгтэй гэж бодож байна. Тэгээд энэ ажлыг манай 7 бүсийн 7 гишүүн байгаа. Тэгээд Дээгий гишүүнээр ахлуулаад энэ туршилагатай төмөр зам тавьж байсан Баттулга Ерөнхийлөгчийг оруулаад бид 7 ороод тэгээд говиос төрсөн ажиллаж амьдарч байсан зондоө хүн байгаа. Ганмаа гишүүнтэй сайн танилцаа. Энхтуяа гишүүн байна, Шижир гишүүн байна.

Тэгээд бүгдээрээ нийлээд энийг яаралтай явуулбал энэ төслийг дагаад хоолойг дагаад Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэр эрүүл Монгол хүн, эрүүл хүнс, тэгээд тэрбум мод гээд энэ бүгд ерөөсөө ус байвал тэнд хамгийн сайхан мод тарьж болно. Хамгийн сайхан хүнс тарьж болно. Жинхэнэ нарны энеригиэр ажилладаг бүх зүйлийг хийж болно. Тэгээд энийгээ сайн анхаараарай гэдгийг хэл хэлье ээ.

Дараагийн асуудал нь эрх мэдлийг энэ орон нутаг руу чиглүүльвээ гээд бид хэд чинь ер нь гучин хэдэн жил ярьсан байх тэгээд энийгээ бас яахгүй босоо тогтолцоотой байгууллагууд ингээд аймаг орон нутагт нэмэгдээд байхаар нэг л биш болоод байх шиг байна аа. Тэгээд эмнэлэг байна сая боловсролыг тэгчихлээ. Ер нь аймгийн сая нөгөө дүүргүүд руу зөвшөөрлийн эрхийг шилжүүлсэн шигээ аймгууд руугаа сумдууд руугаа энийгээ шилжүүлэхгүй бол болохгүй байна гэдгийг хэлье. Тэгээд аймгийн Засаг даргад бол ер нь архины зөвшөөрөл л гэдэг зүйлээс улдсэн юм шиг иргэд ярьж байгаа юм.

Тэгээд 3 дугаар асуудал нь төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулиа манай улс яаралтай хэрэгжүүлээд эхэлбэл аймаг сумд хэрэгжих хийх ажлууд их байна. Сумдын хоорондын замуудыг хийх ажлууд яаралтай хэрэгтэй байна. Омнөговь, Өвөрхангай аймгийг холбосон замыг яаралтай хийчихвэл баруун бүс тэр чигээрээ аялал жуулчлалын эргэлтэд ороод ард иргэд өөрөө өөрсдийнхөө амьдралыг аваад явчих ийм боломжууд их байдаг юм аа. Тэгээд энэ ирэх жилүүдийн

төсөөвт яаралтай энэ сум орон нутгуудаа 330 хэдэн сум л байгаа. Тэгээд энэ сумдуудаа нэг ядаж нэг сумын төв дээрээ модон бие засах газрыг нь өөрчлөөд энэ аялал жуулчлалын ямар ч хүн очиход нэг нүүр улайхгүй болгочих хэмжээний төсөв Монгол Улсад маань байгаа. Тэгээд төсөвөө зөв чиглүүлээд явбал.

**Д.Амарбаясгалан:** Гишүүдийг танхимд цугларах зарыг хүргээрэй.

Сүүлийн хүн үг хэлэх нь байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

**Ц.Идэрбат:** Юуны түрүүнд бидэнд итгэл хүлээлгэсэн зүүн бус Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн ард иргэддээ чин сэтгэлийн талархал илэрхийлье. Бид бүхэн энэ бүсийн хөгжлийн төлөө багаараа хамтаараа сайхан хичээж ажиллана гэдгээ хэлье ээ гэж ингэж бодож байна. Мөн Монголын ард түмний итгэлийг хүлээж Ерөнхий сайдаар улиран сонгогдож ажиллах гэж байгаа Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танд ажлын амжилт хүсье гэж ингэж бодож байна. Энэ удаагийн сонгуулийн үр дүн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг зоригтой хийсний үр дүнд өнөөдрийн парламент бүрдсэн гэж ингэж бодож байгаа юм.

Өнгөрсөн хавар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг танилцуулж улс орон даяар явж байх үед тийм сайхан байгаагүй. Нүүр халуу оргисон олон хундрэлүүдийг уулзалт болгон дээр давж байлаа. Тэгээд өнөөдөр ч гэсэн тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхийг энэ Улсын Их Хурлын танхим дээр яригдаж байх үед даргынхаа тоог нэмэх гэж байгаа гэсэн хүмүүс өнөөдөр Их Хурлын гишүүн болчихсон урдуур сууж байгаа. Би бас баярлаж байгаа болов уу гэж ингэж бодож байгаа.

Тэгэхээр улс орныхоо эрх ашигийг бодож байгаа аливаа шийдвэрийг ирэх жилүүдэд нэлээн углуургаар нь бодож байх ёстой юм болов уу даа гэж надад

шинэ гишүүний хувьд тухайн уед бодогдох байсан гэдгээ бас нэг хэлчихье ээ. Энэ чуулганы хуралдаан дээр. Энэ өнөөдрийн бүрдсэн парламентын энэ бүтцийг үндсэн хуулийн өөрчлөлтийг ярьж байх уедээ л олон намын тогтолцоо энэ парламентын засаглалд орж ирэх юм аа. Зөвшилцөл явж эхлэх юм гэдэг ийм л шинэ улс төрийг эхлүүлье гэж ийм зорилго анхнаасаа л тавьж байсан. Тэрнээс бусдын хэлж байсан шиг дарга нэмэх гээгүй. Тэгээд энэ маань үргэлжлээд Засгийн газрын түвшинд яригдаж эхэлж байгаа юм байна. Тэгээд би Ерөнхий сайдад нэг 2, 3 зүйл дээр анхаараач л гэж ингэж хэлэх гэж байгаа юм.

Нэгдүгээрт энэ авлигалын асуудал дээр таны энэ зоригтой хийж байгаа ажил арга хэмжээ нам харгалзахгүй хийж байгаа энэ зүйлүүд ард түмний дунд үнэхээр цаашаа үргэлжлээсэй гэдэг түйлын чин хүсэл байгаа. Өнгөрсөн хугацаанд хараад байхад энэ Монголын ард түмний баялаг руу дайрсан энэ Дарханы хулгай, Эрдэнэтийн хулгай, Хөтөлийн хулгай энэ бүх зүйлүүд дээр манай АН-ын ах нар нэг ч уг ган хийгээгүй шүү. Нэг ч уг шүү. Алтанхуяг гуай харин дуугарч байсан байх.

Би энийг өнгөрсөн хавар нэг хэлэх гээд хэлээ хазаад өнгөрсөн юм. Сонгууль болох гэж байгаа юм гээд. Одоо шинэ парламент бүрдэж байгаа учраас энэ авлигатай тэмцэх тэмцэл дээр, зоригтой дуугараар, энэ олон залуучууд би зоригтой дуугарна гэж байгаа. Хэлж байгаа илэрхийлж байгаад нь баяртай байна гэдгээ нэгдүгээрт хэлье ээ гэж ингэж бодож байна. Хүний эрх ярьж байна. Содномдаржсаа, Чимгээ гэдэг 2 хүний талаар нэг ч хүн ган хийгээгүй шүү. Би 2 жил 8 сар парламентын гишүүнээр байсан хүн.

Тийм учраас энэ дээр ярьсан шигээ байгаасай гэж хэлчихье гэж ингэж бодож байна.

Дараагийн зүйл энэ сонгуулиар гол ярьж явсан энэ бүсчилсэн хөгжил, энэ шинэ хоршоо, энэ түүхэн аялал жуулчлалын асуудлууд дээр үнэхээр хамтарч чадах эсэхийг нь бас энэ дээр нэг зарчмын байр суурьтай болж чадах уу гэдгийг нь би сайн нягтлаарай гэж ингэж хэлэх гэж байгаа юм. Шинэ хоршоо гэдэг зүйл энэ Монголын 300 гаруй мянган малчдад маш том ирээдүй гэрэл гэгээ өгч байгаа. Энийг маань эсэргүүцээд явах юм бол энэ 3 сарын аян болоод өнгөрөх вий дээ.

Тийм учраас энэ улс орныхоо хөгжлийг харж байгаа энэ том зүйлүүд дээрээ бас нэгдсэн байр суурьтай байж чадна гэж нэлэн сайн ярилцаасай гэж ингэж бодож байгаа юм гэдгээ хэлье. Тэгээд эцэст нь энэ Баялгийн сангийн хууль гэж өнгөрсөн парламентын.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын Ерөнхий сайдаар Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулахаар байгаа. Гишүүд танхимд 104-үүлээ байна. Тийм ээ 104 гишүүн танхимд байна. Ингээд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуульяа. Гараа өргөж илээр явж байгаа шүү дээ. Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүд гарaa өргөхийг хүсье. Алга байна. 104 гишүүний 100 хувийн саналаар. Хаана байна жсоохон өндөр өргөхгүй бол харагдахгүй байна. 103 гишүүний саналаар дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын Ерөнхий сайдаар Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжссэн тул Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо. Ушииж таницуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

*Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай*

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн б дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3 дахь хэсэг санал хураалтын дунг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

*1. Монгол Улсын Ерөнхий сайдаар  
Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг  
томилсугай.*

2. Энэ тогтоолыг 2024 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоолын төсөл байна. Тогтоол байна. Тэгээд тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Тогтоол батлагдлаа.

Ингээд Монгол Улсын Ерөнхий сайдаар улиран томилогдож байгаа Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэд Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс болон Монгол Улсын нийт ард иргэдийнхээ нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт хүсэж сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Ингээд Ерөнхий сайдаар сонгогдсон Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнийг индэрт урьж байна аа.

**Л.Оюун-Эрдэнэ:** Эрхэм Монголчууд аа, Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Юуны өмнө арчилсан Монгол Улсын иргэн танд эрхээ эдэлж, мөн үүргээ биелүүлж, сонгуульдаа идэвхтэй оролцсонд чин сэтгэлийн талархал илэрхийлье ээ. Монголчууд та бид хамтдаа арчилсан тогтолцоонд шилжссэнээс хойш 9 дэх удаагийн Улсын Их Хурлын энэхүү сонгуулиар нутаг дэвсгэрт сууринсан 76 гишүүнтэй

парламентыг түүх болгон жаазлан үлдээж байна аа.

Өнөөдөр бид хамтдаа олон нам, нийгмийн бүлгүүд, салбар салбарын дуу хоолой болсон 126 төлөөлөлтэй цоо шинэ парламентын шинэ эрин үеийг ийнхүү хамтдаа эхлүүлж байна. Амны бэлгээс ашдын бэлгэ гэдэгчлэн сонгуулийн шинэ өглөөг олон монгол ахан дүүс маань 1990 оны арчилсан өөрчлөлтийн дараах өдрүүдтэй шинэ өглөөтэй зүйрлэн ярилцааж угтсаныг та бүхэн мэдээж байгаа. Энэ удаагийн парламент олон намын төлөөлөөс бүрдлээ. Энэ олон жилийн мөрөөдөл байсан. Мөн анх удаа 32 эмэгтэй гишүүдтэй болсноор 25 хувийн босгыг давж Ази тивийн дундаж үзүүлэлтээс давлаа гээд нийт эрэгтэй гишүүдийнхээ өмнөөс нийт сонгогдсон 32 эмэгтэй гишүүндээ ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Мөн энэ удаагийн парламент Монгол Улсын түүхэнд хамгийн олон инженерүүдтэй, хамгийн олон эрдэмтэн судлаачидтай, хамгийн олон их дээд сургуулийн профессоруудтай мөн мэргэжил мэргэжлийн экспертуудтэй, эмч, багши нарын хамгийн олон төлөөлөлтэй мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл хилийн чанадад амьдарч байгаа Монголчуудын төлөөлөл мөн нийгмийн зөвшилцлийн гол байгууллагууд болох Худалдаа аж үйлдвэрийн танхим. Монголын үйлдвэрчний эвлэ, Шинжлэх ухааны академи мөн иргэний нийгмийн байгууллагууд мөн 4 дэх засаглал болсон хэвлэл мэдээллийн салбарынхан орж ирж төлөөлөл хангагдсанаараа энэ удаагийн парламент илүү мэдээлэлтэй илүү олон ургалч үзэлтэй, илүү олон нийттэй ойрхон ийм парламент болж чадна гэдэгт итгэлтэй байна.

Мөн энэ удаагийн парламентад нийт 81 гишүүн шинээр сонгогдсон нь нийт гишүүдийн 64 хувийг өөрчилсөн ийм үзүүлэлт Монгол Улсын түүхэнд гарч байгаа анхны тохиолдол болж байна.

Тийм ч учраас энэ ард түмний ялалт Монголын ардчиллын мөн Монголын парламентын шинэ хуудас буюу шинэ 30 жилийн эхлэл болж чадсан гэдэг улс төрийн дүгнэлтийг Ерөнхий сайдын хувьд хийж байна аа. Цагаан морин жилийн ардчилсан хувьсгалаар Монголын ард түмэн картын бараатай ч гэсэн ирээдүйдээ итгэлтэй байсан. Сая эрхэм гишүүний хэлж байгаа үнэн өнөөдөр ч Цагаан морин өдөр гэж хэллээ. Би гэхдээ нягталж узээгүй. Магадгүй бэлгэдэл байж болох юм. Тэр үед ардчилсан хувьсгалын удирдагч Санжаасүрэнгийн Зориг Улсын эрх ашиг бол нэгдүгээрт юм аа. Улс төрийн намын эрх ашиг 2 дугаарт тавигдана. Харин эцест нь хувийн эрх ашиг байх ёстой хэмээн ардчилсан нийгмийн эрх ашигийн эрэмбийг эрэмбэлж байсан.

Харамсалтай нь Зоригийн хүсээж мөрөөдөж байсан мөн манай ахмад зүтгэлтнүүд болох Жамбын Батмөнх, Буурал Очирбат гуай, Даш-Ёндөн даргаас эхлээд олон ахмадууд маань итгэж тайван замаар төрийн эрх мэдлийг шилжүүлсэн ардчилсан хувьсгалын узэл санаа бүдгэрч иргэдийн урам хугарсан зүйл ялалт ч үгүй энэ эрх ашигийн эрэмбэ алдагдсан, авлигат хэмээх узэгдлээс болсон гэж бид нар хамтаараа нийгмийн дүгнэлтийг 30 жилийн дараа хийж байна. Мартагдсан зорилго руугаа эргэн буцах алдагдсан зарчим руугаа эргэх ухаарлын Ерөнхий сайд Амар нар түүхэнд шинэ эргэлтийн бодлого хэмээн тодорхойлж байсан.

Харин өнөөдөр та бид хамтдаа ардчилсан хувьсгалыг анхдагч үнэт зүйл дээр нь авчрахын төлөө мөн ардчилсан хувьсгалын 2 дахь давлагагаа болсон парламентын шинэ ардчиллыг төлөвшүүлэн бий болгохын төлөө хамтдаа мэтгэлцээж, хамтдаа ярилцаж, мөн хамтдаа тэмцэх ийм түүхэн шаардлагын өмнө байна. Авлигатай бид нар нам харгалзахгүй тэмцэж энэ тогтолцоог энэ системд оролцсон хүмүүсийнх нь хувьд ч мөн бүрдүүлж

байгаа хөрс суурийнх нь хувьд ч хамтдаа засах ийм сонголт руу л алхах ёстой. Гэхдээ ярилцаж мэтгэлцээж байна гэдэг бол өөрөө авлигатыг үргэлж ялдаг парламентын ардчиллын хамгийн давуу тал аа. Энэ ч агуулгаар өнөөдөр тангараг өргөж, бүрэн эрхээ хэрэгжүүлээд удаагүй байгаа ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурлын эрхэм гишүүд мөн шинэхэн Улсын Их Хурлын дарга эрхэм журмын нөхөр Дашзэгвийн Амарбаясгалан та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Саяын үг хэлсэн бүх зүйлүүдийг тэмдэглэж авлаа. Үйл ажиллагаанд тусгаж ажиллахыг эрмэлзэх болно оо гэдгээ та бүхэндээ илэрхийлээд бүрэн эрх нь нээгдсэн. Гэхдээ энэ ард түмний төлөөлөл учраас үүрэг хариуцлага давхар байгаа гэдгийг эрхэм парламентын гишүүд маань санаж гүйцэтгэх засаглалтай хамтарч ажиллахыг хичээнгүйлэн та бүхнээсээ хүсье ээ.

Энэ удаагийн сонгууль зөвхөн парламентын хувьд шинэ 30 жилийг эхлүүлсэн биши мөн удаан хугацаанд хуримтлагдсан нийгмийн болон манай улсын хөгжлийн суурь асуудлыг шийдвэрлэхэд шинэ хандлагаар парламент Засгийн газрыг дэмжинэ гэдэгт чин сэтгэлээсээ итгэж байна. Улс орныг би төсөөлдөг. Энэ бол хүний биетэй адилхан амьд организм. Эд эс эрхтэн бүхэн эрүүл байж, цусны эргэлт хурдсааж, дархлаа хэвийн байж, эрүүл, эрч хүчтэй байж чаддаг шиг улс орны хөгжил цогц ойлголт. Аль нэг нь урдаа, аль нэг нь хойноо асуудал гэж байхгүй.

Тийм ч учраас бид нар шинж тэмдэгтэй зууралдах биши харин амьд организмыг доголдуулж буй шалтгааныг зөв оношилж суурь реформуудыг хийж чадвал аяндаа бусад зүйлийг өөрөө амьд бие өөрөө эдгээх боломжтой. Энэ ч агуулгаараа бид нар өнгөрсөн 4 жилийн хугацаанд эхлүүлсэн боомтын сэргэлтийн асуудлууд, дэд бүтцийн асуудлууд, мөн цахилгаан станцууд, аялал жуулчлал, “и

монгол”, “цахим засаглал” гээд нефтийн үйлдвэр зэрэг олон асуудлуудаа энэ бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлжс дуусгах бүтэн санхүүжилтийг Их Хурлаар шийдүүлэх учиртай. Бид эхлүүлсэн ажил олонгий ч дуусгасан ажил бас цөөхөн байдгийг бид бүхэн мэднэ. Дандаа л улс төржилт болон эрх ашигасаа болж энэ төслүүд удааширсныг бид бүхэн мэднэ.

Тийм ч учраас энэ бүрэн эрхийн хугацаанд би хэд хэдэн зүйл дээр Монгол Улсын парламентыг Засгийн газрыг дэмжисж ажиллахыг хичээнгүйлэн уриалж байна. Энэ дандаа суурь реформын асуудлууд байгаа.

Нэгдүгээрт 30 жил хүлээгдсэн эрчим хүчиний салбарыг либералчлах асуудлыг цаг алдалгүй хийхийг үнэхээр хүсэж байна. Энэ маш галтай асуудал, нэгдүгээрт.

Хоёрдугаарт гэвэл эрчим хүчиний салбар өөрөө ойлгогддоггүй нь маш их хэмжээний хөрөнгө оруулалтыг газрын доор булдаг учраас улс төрчид дэмжихгүй байсаар ирсэн. Яагаад? Нүдэнд харагдахгүй гарч тэмтрэгдэхгүй. Гэтэл эрчим хүчиний салбар маань өнөөдөр доголдсон байна. Эрчим хүчиний салбар доголдсон учраас үйлдвэрлэл аж үйлдвэрлэл бий болохгүй байгаа. Эрчим хүчиний салбар доголдсон учраас хот байгуулалт явахгүй байгаа. Эрчим хүчиний салбар доголдсон учраас нийслэл Улаанбаатар хот тэлж чадахгүй. Мөн бүсчилсэн хөгжлийн узэл баримтлал ч гэсэн амьдарч чадахгүй байгаа суурь шалтгаан бол ерөөсөө л дэд бүтэц эрчим хүчиний асуудал байгаа.

Тийм учраас эрчээ алдсан эрчим хүчиний салбарыг эргэн сэргээхгүйгээр хот байгуулах эдийн засгийг тэлэх гэдэг олон бодлого дэвшүүлсэн ч гэсэн энэ зөвхөн цаасан дээр л үлдэх болно. Тийм учраас бид эрчим хүчиний салбарыг либералчилж эрчим хүчиний үнийг чөлөөлж эрчим хүчиний салбар, бизнесийн хувьд ашигтай болох олон хөрөнгө оруулагчид Монгол

Улсын бизнесийн салбарт тэр дундаа эрчим хүчиний салбарт хөрөнгө оруулалт хийх нь өгөөжтэй болох энэ зоригтой алхмыг бид нар агаарын тээврийн либералчлалыг хийж чадсан шиг хийх ёстой. Агаарын тээврийн либералчлалыг МИАТ-ийг дамжуурна гээд хийлгэдэггүй байсан. Бид бүгдээрээ мэдэж байгаа. Гэтэл өнөөдөр МИАТ дамжуурсангүй. Харин ч аялал жуулчлалаас бид анх удаа 1.3 тэрбум ам.долларыг өнгөрсөн жилийн хугацаанд олсныг та бүхэн мэдэж байгаа. Мөн энэ удаа бүсчилсэн тойргоор анх удаа сонгууль явагдлаа.

Урьд нь бид нар зөвхөн аймгаар асуудлыг хардаг. Нутгийн зөвлөлүүд илүү хүчтэй нутгархдаг ийм үзэл санаанд хамтдаа энэ эрх ашигас олж авчихсан байсан. Харин анх удаа бид нар бүсчилсэн том тойргос энэ удаагийн парламент бүрдэж байна. Энэ агуулгаараа бид нар аймгийн төвүүдийг хооронд нь дэд бүтцээр холбох аймгийн төвүүдэд байгаа боломжийг хооронд нь уялдуулах мөн хилийн боомтуудтай холбох мөн бид нар аймгуудыг хилийн боомтуудтай холбосон 5 тойрог дэд бүтцийн мега төслийн бүтээн байгуулалтыг энэ намартаа багтан эхлүүлэх зайлшгүй шаардлагатай.

Тийм ч учраас би эрхэм гишүүдийг бүс бүсээрээ нам харгалзахгүйгээр уулзаж томоохон энэхүү төслийн зураг төсөл ТЭЗҮ дээр цаг алдалгүй хамтарч ажиллахыг хүсэж байна. Яагаад гэвэл зураг төсөв гэдэг бол том төслийн хувьд өөрөө бараг 1.5-аас 2 жилийн хугацаа ордог зүйл байдгийг та бүхэн мэднэ ээ.

Мөн бид нүүрс болон байгалийн баялгийн экспорттой холбоотой томоохон бодлогын шинэчлэлийг хийх хэрэгтэй. Манай улсын 93 хувийг уур уурхай эзэлж байна. Түүний 50 хувийг нүүрс эзэлж байгаа. Өдрөөс өдөрт нүүрс зарагдахаа болих ийм төлөв байдал руу шилжисж байна. Энэ тохиолдолд Монгол Улсын эдийн засгийг яг юу орлох вэ гэдгийг бид одоогоос ярихгүй оройтно. Ингэж тэлсэн төсөв нэг өдөр нүүрсгүй бол маш

их хэмжээний өвдөлт өгнө. Энэ нь бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдал болон улс төрийн тогтвортой байдал маш сөргөөр нөлөөлнө. Гэхдээ энэ хамгийн багадаа 10-аас 15 жилийн хугацаа орно гэдгийг бид нар тооцох ёстой. Тийм ч учраас энэ удаагийн парламент энэ удаагийн Байнгын хороон дээр олон эрдэмтэн судлаачид орж ирсэн.

Тийм учраас нүүрсийг бид нар хэрхэн боловсруулах вэ нүүрсийг хэрхэн эдийн засгийн хувьд бид нар экспорт тооцоо орлуулах вэ гэдэг бол энэ парламентын бүрэн эрхийн хамгийн чухал асуудлуудын нэг. Ялангуяа эдийн засаг, чиглэл, аж үйлдвэрийн чиглэлийн томоохон асуудлуудын нэг энэ байгаа. Энэ ч агуулгаараа ШУА-ийн Ерөнхийлөгчийг оруулж ирэх, мөн олон эрдэмтэн судлаачдыг урьсан байгаа. Энэ ч агуулгаараа бид нар шинжлэх ухаан, техник технологи, дэвшилтэт үзэл санаа нь их өгөгдөл тулгуурлаж Монгол Улсын эдийн засгийн бүтцэд томоохон хэмжээний өөрчлөлтийг хийх учиртай. Энэ нэг дэх өдрөөс эдийн засгийн форум болно. Олон олон хөрөнгө орууллагчид түрүү жил ч гэсэн нэлээн өрөм өргөн бүрэлдэхүүнтэй ирсэн. Энэ дээр ч гэсэн бид нар гадаад талдаа нэгдмэл байдлаар Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчинд энэ парламентын засаглал дээр тулгуурласан олон намын стратегийн хөрөнгө оруулалтын ногоон гэрлийг цаашидаа тогтвортой асаах учиртай.

Мөн нэг асуудал бид дэлхийн цаг уурын өөрчлөлтөөс улбаалж манай ХАА-н салбар тэр дундаа нүүдлийн МАА-д томоохон хэмжээний ийм эрсдэл үүсэж байна. Та бүхэн ажиглаж байгаа бол Монгол цас мөн борооны гэдэг 2 улиралтай болж байна. Энэ ч агуулгаараа бид нарын өмнө нь баримжаалдаг идэр 9-ийн хүйтний хүйтрэлт мөн зүн цас орох зэрэг ийм олон байгалийн гамишигт үзэгдлүүдийн давтамж ихсэж байна. Гэхдээ энэ зөвхөн Монгол Улсад биш дэлхий даяар дэлхий маань өөр болж байна.

Тийм ч учраас бид томоохон хэмжээний энэхүү цаг уурын өөрчлөлтийг сорихын тулд хамтдаа ногоон дэвшилтэт хөгжлийн бодлого мөн бусад салбаруудаа бид нар илүү дэвшилтэт болгох ийм томоохон суурь реформыг хийхээс өөр сонголтгүй болж байна. Энэ агуулгаараа малчдыг хоршиоолох, цөлжилтийн эсрэг арга хэмжээ мөн онцгой байдлын салбарыг цоо шинэ түвшинд гаргах зайлшгүй шаардлагатайг бид нар цаг уурын хувьд тулгарч байна гэж ойлгож болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч тэрбум мод, хүнсний хувьсгал, цагаан алт зэрэг хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлж байгаа нь ч энэ бол цөлжилттэй холбоотой асуудал. Хүнс, хөдөө аж ахуйтай холбоотой асуудал бол бүх нийтийн буюу үндэсний хэмжээний ийм асуудал болсон учраас л төрийн тэргүүн анхаарал хандуулж байгаа гэдгийг та бүхэндээ хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Тийм ч учраас Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн энэ дэлхийн цаг уурын өөрчлөлтөөс улбаалж нүүдлийн мал аж ахуй малчдаа бид хэрхэн аврах вэ гэдэг том асуудал. Зээл тэглэх болон бусад асуудал нэг удаагийн л арга хэмжээ. Малчдын хувьд нүүдлийн соёл иргэншил гэдэг манай тусгаар тогтнол бидний сэтгэлгээний асуудал.

Тийм учраас бид хэрхэн уламжлалт нүүдлийн МАА-гаа аврах вэ? Мөн малчдын боловсролоос авхуулаад энэ асуудалд хэрхэн том хэмжээний урт хугацаанд хэрэгтэй реформыг хийх вэ гэдэг бидний хамгийн чухал асуудал болж байгаа юм гэдгийг та бүхэндээ хэлье.

Мөн уур уурхайн салбарыг яаж бид байгаль орчинд илүү ээлтэй болгох вэ, яаж уул уурхайн салбар иргэдэд илүү хуртээмжтэй байх вэ, яаж уул уурхайн салбарын энэ экспортын том орлого илүү Монгол Улсын хувийн хэвшилүүдэд ээлтэй

байх вэ гэдэг энэ агуулга дээр томоохон хэмжээний реформ хийх зайлшгүй шаардлагатай. Үндэсний баялгийн сангийн тогтолцоонд бид нар шилжссэн. Монгол банкан дээр Үндэсний баялгийн сан энэ жилээс эхлээд хуримтлал үүсгэж эхэлнэ. Бид бас сонгуульд хүндэтгэлтэй хандаж нэг үгээр хэлбэл ирэх жилийн 1 сарын 1-ээс Үндэсний баялгийн сангаар дамжуулж эрүүл мэнд боловсрол, орон сууцжуулалтад хуримтлал үүсгэх ийм томоохон хөтөлбөрийг Засгийн газраас зарлажс эхэлнэ. Энэ агуулга өөрөө илүү баялагтаа эзэн байх мөн орон нутагт түрүүлж хөгжих уул уурхайгаа ашиглуулж байгаа мөн уул уурхай илүү дэвшилтээ технологид тулгуурлааж байгальд хэрхэн ээлтэй байх вэ? Мөн үндэсний баялгийн сангаар дамжуулж иргэд уурхайн салбар хэрхэн бидэнд үр өгөөжстэй байх вэ гэдэг энэ агуулга руу хамтдаа алхах хэрэгтэй.

Энэ хөрөнгө оруулалтын ч асуудал, энэ нийгмийн тогтвортой байдлын асуудал. Энэ баялгийн тэгши бус байдал энэ бол дундаж давхаргыг дэмжих ийм том агуулга байх болно. Энэ парламентын бүрэн эрхийн хугацаанд энэ баялгийн реформтой холбоотой энэ маргаан нэг талдаа гарасай гэж хүсээж байгаа. Энэ олон жилийн хугацааны маргаан. Хөрөнгө оруулагч талдаа ч ээлтэй, иргэд талдаа ч сэтгэл хангалуун ялангуяа томоохон орон сууцжуулалтын хөтөлбөрийг үндэсний баялгийн сантай хэрэгжүүлэх Сингапурын загвар манайд хэрэгжих бүрэн боломжтой юм байна гэдгийг судлаачид гаргаад Монголбанканд энэ хуримтлал үүсэж эхэлж байгаа гэдгийг та бүхэндээ хэлэхэд таатай байна.

Мөн энэ парламентын бүрэн эрхийн хугацаанд нийслэл Улаанбаатар хотын Их бага тойруу буюу бидний эргэн тойронд байгаа 700 гаруй га-д төвлөрсөн төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг хэрхэн задлах вэ гэдгээс нийслэлийн түгжрэлийн шийдэл шууд хамаарна. Нэг үгээр хэлбэл нийслэлийн түгжрэл бол их,

бага тойруугийн түгжрэл гэж ойлгож болно. Энэ бол Улаанбаатар хотын түгжрэл гэхээс илүүтэйгээр энэ эрх мэдлийн түгжрэл.

Тийм ч учраас бид сонгодог парламентын засаглалыг төлөвшүүлэх хүрээнд нэг байшинд хууль тогтоох засаглал, гүйцэтгэх засаглал хамтдаа байх энэ зүйлийг зоригтой шийдэх хэрэгтэй. Олон жилийн хугацаанд энэ асуудлыг бид ярьсан ч гэсэн Үндсэн хуулийн асуудал мөн ордонд байх нь илүү таатай нөхцөл байдал ч юм уу хотын төвд байх гэсэн энэ нөхцөл байдлаас болоод бид 5 удаа оролдоод энэ асуудлыг хийж чадаагүй.

Тийм ч учраас энэ бүрэн эрхийн хүрээнд манай Монгол Улсын Их Хурлын парламентын эрхэм гишүүд та бүхэн дэмжсвэл Ерөнхий сайдын хувьд би Засгийн газрыг Хөшигийн хөндий руу нүүлгэх энэ олон Улс төрийн зоримог шийдвэрийг гаргахад бэлэн байна. Ингэснээрээ Засгийн газрын харьяа байгууллагууд буюу нийт төрийн эрх мэдлийн бараг 45 орчим хувь нийслэл Улаанбаатар хотын Бага тойруугаас уе шаттай нүүх ийм боломжийг бид нар бурдүүлнэ гэсэн уг. Ингэснээрээ бид нар Улаанбаатар хот зөвхөн Бага Их тойруу төвтэй биш Улаанбаатар хот онгоцны буудалтайгаа хамт 2 төвтэй болох мөн Богд уулыг тойрсон хурдны замыг бид нар 3 жилийн дотор бүтээн байгуулах бүрэн боломжтой. Гагижүү зориглож төсвийг Улсын Их Хурал бөөнөөр нь батлах л ийм эр зориг хэрэгтэй байгаа гэдгийг хэлье.

Ингэж чадсанаар бид нар иргэдэд ээлтэй мөн эмнэлэг, сургууль, цэцэрлэг, ногоон байгууламж, соёл, спортын үйлчилгээг 20 минутын дотор авч чадах ийм нийслэл Улаанбаатар хотын шинэ стандарт буюу амьд хот төлөвлөлтийг хийх суурь реформ үүснэ гэсэн уг. Ингэснээрээ Толгойт Баянхошуу зэрэг 42 орон нутаг тухайн газраа төр захиргааны үйлчилгээний нэгдсэн цэгийг авах, тухайн газраа заавал Улаанбаатар хотод орж

ирэхгүйгээр төрийн уйлчилгээг бүхэлд нь авдаг болох нэгдсэн стандартын дагуу шийдвэрлэж улсын төсвийг 20 минутын хотын энэхүү стандартын дагуу их өгөгдөл тулгуурлаж шийдэл гаргадаг байх энэ жисиг рүү шилжсиж чадвал маш сайн. Тэгэхгүй бол Их Хурлын гишүүдийн хөөцөллөгөө сайтай нь эсвэл улс төрийн хувьд нөлөө бүхий капиталтай нөхдүүд нь илүү их төсвийг тойрог дээрээ хуваарилуулж бусад тойрог үлддэг. Энэ жисигээр явбал бид нар энэ 20 минутын хотыг шийдвэрлүүлж чадахгүй ээ гэдгийг хэлье. Мөн бид нар нийслэл Хөшигийн хөндийг холбосон хурдны зам болон хурдны замыг холбох гүүрэн байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг бид энэ жилдээ эхлүүлж чадвал нийслэл Улаанбаатар хотыг Хөшигийн хөндийтэй бид нар холбох том гүүрэн байгууламжийг хийж чадна.

Бид Энхтайваны гүүрнээс хойш ийм том гүүрэн байгууламжийг хийж чадаагүй. Би тэгээд шинэ парламент бас дэмжиж энэ гүүр шинэ парламент, шинэ 30 жилийн нүүр царай болж Монголын түүхэнд төр иргэний итгэлцэл, эргэн сэргэсэн энэхүү 30 жилийн бэлгэ тэмдэг болон улдэх томоохон бүтээн байгуулалтыг хийхэд парламентын гишүүд Засгийн газрыг дэмжиж ажиллахыг хичээнгүйлэн хүсье. Мөн бид аж үйлдвэр, уур уурхай, сэргээгдэх эрчим хүч, эрчимжссэн эрчимжссэн ногоон эрчим хүч, ХАА газар тариалан болон түүхэн болон байгаль соёлын аялал жуулчлалын төрөлжссөн бусуудийг бий болгох шаардлагатай. Тэгээд бус бус дээр бусийн ялгаатай татварын бодлогыг хэрэгжүүлэх бүтэн боломжтой.

Тэгэхээр энэ агуулгаар бас ирэх улсын төсөв дээр одоогоос бид нар бэлтгэлээ хангаж татварын болон хөрөнгө оруулалтын том реформыг бусчилсэн хөгжлийн узэл баримтлалд тулгуурлан хийх боломжтой. Нэг угээр хэлбэл алслагдах тусмаа илүү өртөг хямд байхгүй алслагдах тусмаа нийслэл Улаанбаатар хотоос унэтэй болоод

байвал төвлөрөөд байх нь ойлгомжтой. Бид хүчээр төвлөрлийг шийдэж чадахгүй нь ойлгомжтой гэдгийг хэлье. Мөн хот байгуулалтын төлөвлөгөөг бусчилэн хөгжүүлэх хүрээнд Хархорум, Шинэ зуун мод зэрэг хотуудын бүтээн байгуулалт мөн орон сууцжуулалтын томоохон реформыг төр хувийн хэвилийн түншлэлээр хийх боломжтой. Бид төсвийг болон баялагийн сангийн эх уусвэрийг үргжүүлхийн хүрд болгон ашиглах ийм боломж бид нарт байгаа.

Тавьсан зорилгоо хурдтай хэрэгжүүлэхийн тулд инновац шинжлэх ухааны ололтод тулгуурлан их өгөгдөл суурилж хүн шийдвэрлэхгүйгээр үүнийг бид нар технологиор шийдвэрлүүлэх ийм томоохон реформ руу хамтдаа орох цаг болсон байна. Мөн мэргэжлийн экспертуудийн зөвлөмжид үндэслэн хөрөнгө оруулагчид, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, мөн их дээд сургуулиудын идэвхтэй түншлэлийг Засгийн газар бүх талаар дэмжин ажиллах болно. Мөн парламентын төлөөлөл маш том бүрэлдэхүүнтэй болж байгаа учраас төлөөлөл бүхэн нийгмийн тухайн салбарыг идэвхжүүлэх ийм лобби бүлгүүд болж чадвал бид парламент хамтдаа зөвшилцөж чадвал нийгмийн бүх салбарууд оролцогч болох, мөн парламент ард түмнээсээ алслагдсан биш харин бидний төлөөлөл бид хамтдаа байна гэдэг мэдрэмжийг бид нар иргэддээ өгч чадвал бид шинэ 30 жилийг бодитоор бий болгох ийм боломж гарна. Саяын дурдсан эдийн засгийн томоохон төслүүдийг бид нар төр хувийн хэвилийн түншлэлээр хийхийн тулд эдийн засгийн өсөлт багадаа б-аас 7 хувь байх шаардлагатай.

Дэлхийн эдийн засгийн өсөлт дунджаар 3 хувь байгаа. Мэдээж олон улсын нөхцөл байдал ээдрээтэй байгаа. Гэхдээ бид нар одоо байгаагаас 7 хувийн өсөлтийг хадгалж чадна гэдэг энэ маш том амжилт. Жил бүхэн 7-оос 8 хувиар өсөх ийм боломжтой. Тэгэхийн тулд эрчим хүчээ зайлшигүй шийдвэрлэх шаардлагатай. Мөн аж үйлдвэржилт,

Эрдэс баялгийн хайгуул, ногоон технологийн шилжилт, мэдээлэл технологи, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн болон энэ салбаруудыг илүү тусгайлан эрхлэх ийм чиг үүргийг бүтцэд оруулж өгөхгүй бол энэ том салбарууд яаман дээр нэг газрын түвшинд ч юм уу эсвэл нэг агентлаг гээд төрийн захиргааны салбарын нэг хүмүүсийн дунд орхигдчихдог учраас тэдний хувьд бүтэн сэтгэл гаргахгүй. Парламентын гишүүд шиг хариуцлага хүлээхгүй улс төрчид ирж л байдаг юм. Буцаж л байдаг юм. Бид мөнхөд тогтвортой гэдэг ийм хандлагын том өөрчлөлтүүд байгаа гэдгийг парламентын гишүүд та бүхэн анхааралдаа авах нь зүйтэй байх аа гэж бодож байна.

Энэхүү эдийн засгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн бүтээмжийг эрс дээшлүүлэх шаардлага байгаа. Энэ ч агуулгаараа сонгодог парламентын засаглалыг бүрдүүлэхэд эрс шинэчлэл хийгдэх олон улсын нийтлэг жишиг болсон Герман, Сингапур, Япон, мөн Шинэ Зеландын бүтцийг бидний хувьд дахин харж нэг үгээр хэлбэл төрийн бүтцийн дахин инженерчлэлийг зоригтой хийх реформ болсон гэж үзэж байна. Яагаад гэвэл парламент өөрөө шинэчлэгдсэн учраас үзэл санааны хувьд ч гэсэн илүү хайрцгаас гарсан гэж Засгийн газрын тэргүүний хувьд үзнэ.

Нэг үгээр хэлбэл төрийн байгууллагуудын бүтэц хэт ерөнхий биш асуудлыг тухайн нарийвчлах хариуцлага, үнэлгээ, хяналт дүгнэлт өгдөг байх тогтолцоонд шилжихэд энэ парламент түүхэн үүргийг гүйцэтгэж чадна гэдэгт итгэлтэй байна. Ерөнхий сайдын хувьд сонгогчдын санал бүхэнд хүндэтгэлтэй байхыг эрмэлзэнэ. Энэ ч агуулгаараа зөвхөн сонгуульд ялалт байгуулсан МАНЫН мөрийн хөтөлбөр Монгол Улсын мөрийн хөтөлбөр гэж миний хувьд үзэхгүй санал өгөгдсөн. Бусад намуудын мөрийн хөтөлбөр ч гэсэн энэ ард түмэн санал өгсөн хүчин төгөлдөр мөрийн хөтөлбөр гэж үзэх учраас түрүүн зарим

шишүүдийн хэлж байсны дагуу мөрийн хөтөлбөрийг бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болгоходоо нэгтгэнэ. Гэхдээ товч тодорхой, хэзээ ямар хугацаатай, яаж хэрэгжсих вэ гэдэг зүйл дээр маш тийм товч тодорхой хөтөлбөрийг дэвишүүлж ажиллах нь зүйтэй.

Нэг үгээр хэлбэл бүх хөтөлбөрүүд эхлээд шууд дуусах зарчмыг барих нь зүйтэй. Тэгэхгүй эхлээд 10 жил болдог ийм хөтөлбөрүүд биш. Тийм учраас энэ дээр парламентын гишүүд та бүхний улс төрийн эр зориг манлайлал туйлын чухал болдог шүү. Яг төсвийн үеэр зөвхөн тойрог тойргоо бодоод байвал ийм том реформууд хийгддэггүй гэдгийг та бүхэндээ хэлье.

Энэхүү хөтөлбөрийг цаг алдалгүй хэрэгжүүлэх мөн олон улсын geopolitikiийн ээдрээтэй нөхцөл байдал зэргийг харгалzan мөн хөтөлбөрүүд энэ зарчмыг хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллахад аль ч улс төрийн намтай бидний хувьд санал нэг байгаа гэдгээ илэрхийлье. Гагцхүү энэ хамтын ажиллагаа илүү зарчим дээр тулгуурласан, илүү нээлттэй, ил тод мөн олон нийтийн дэмжлэг авсан байгаасай гэж хүснэ. Мөн улс төрийн намууд институцийнхээ хувьд нэгдмэл байгаасай төрийн ажлыг гацаахгүй байх энэ үндсэн зүйлийг хийх нь зүйтэй юм аа гэж үзнэ.

Энэ зарчим дээр тулгуурлаж чадаагүй тохиолдолд бид дангаараа нэг үгээр хэлбэл хариуцлага хүлээгээд явахад бэлэн байгаа гэдгээ илэрхийлье. Гэхдээ энэ хөтөлбөрүүдийг сонгогчдын саналыг гээгдүүлэхгүй байх энэ зарчмыг бид нар нэгэнт Үндсэн хуулиараа хийсэн учраас хамтдаа зөвшүүлж явах нь Монгол Улсын эрх ашигт туйлын чухал байгаа шүү.

Тийм учраас улс орны эрх ашигийг та бүхнийг нэгдүгээрт тавьж чадна гэдэгт итгэж байна. Бид тэгээд тэрбумуулаа биш бид хэдэн 100 саяулаа ч

бииш тийм учраас Монгол Улс шинэ 30 жилийг эхлүүлж үсрэнгүй хөгжлийн шинэ гарааг хийхийн тулд хүн бүхний идэвхтэй оролцоо маш чухал. Эд эс, эрхтэн бүхэн идэвхжисэж, уураг тархи бүхэн улайстаа ажиллаж байж л бид энэ өөрчлөлтийг хийнэ. Тийм ч учраас ихэнх нь парламентын гишүүд та бүхэн ард түмний төлөөлөл та бүхэн сонгогчдынхоо өмнө хариуцлага хүлээж байгаа субъект. Энэ ч агуулгаараа бид хамтдаа Монгол Улсын энэ төслүүд хэрэгжсэн байх нь л бидний хамтын ялалт байх учиртай. Энэ өөрөө Монгол Улсын ялалт байх учиртай юм аа.

Ингээд та бүхэндээ чин сэтгэлээсээ аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Маш их олон ийм урвалж үзэлтэй цэцэг мэт ийм парламент бүрдсэнд маш их талархаж байна. Яг ийм сонгуулийн үр дүн гараасай гээж ер нь төлөвлөж яг тухайн үед зөвшүүлийн үед ярьж байсан. Шинэ Зеландын загварыг бид нар харж байсан. Тэгээд яг л тогтолцоо нь Үндсэн хуулийн энэхүү үзэл санаа парламентын танхимд өнөөдөр амьдрахыг харах надад тийм гоё дурсамж болж үлдэхээр байна.

Тэгэхээрээ бидний хувьд улсаа л хөгжүүлэх нэг л ийм зорилго бидэнд

байгаа нь үнэн. Ганбат даргатай санал нэг байна. ДНБ хэдийгээр 5 мянган ам.долларт хүрээд 6 мянган ам.долларт хүрэх гэж байгаа нь зарим жилүүдтэй харьцуулахад мянган доллар ахиж байгаа нь хэдийгээр энэ ахиж байгаа боловч бид бүхэнд ноогдох ДНБ-ийг 10 мянган ам.доллароос дээши маш хурдтай тогтвортой гэхдээ зөвхөн уул уурхай биш олон тулгууртайгаар тогтвортой гаргах зүйлийг л хийх нь энэ ард түмний ялалт байх болно.

Ингээд та бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсье.

Мөнх хөх тэнгэрийн дор Монгол Улс мандан бадрах болтугай. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ингээд Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэд талархлаа.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаан хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Даваа гарагт анхдугаар чуулган үргэлжилнэ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА